



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйл

буюу

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн
зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн дүн шинжилгээ

(Судалгааны тайлан)

Улаанбаатар хот

2023



ННА 67.408
ДАА 345
К-381

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН 23.1 ДҮГЭЭР ЗҮЙЛ БУЮУ
ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ
(СУДАЛГААНЫ ТАЙЛАН)

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Б.Түмэндэмбэрэл (Ph.D)	Судалгааны багийн ахлагч
Х.Буянбат	Судалгааны багийн судлаач
О.Энххүслэн	Судалгааны багийн судлаач

© Нээлттэй Нийгэм Форум, 2023 он

Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Эхийг "Би Си Ай" ХХК-д бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9926-8-2

Нээлттэй Нийгэм Форум нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд бодлогын судалгаа, шинжилгээ ач холбогдолтой хэмээн үзэж, эрүүгийн шинэ хууль тогтоомжийн хүрээнд бодлогын 30 гаруй судалгааг олны хүртээл болгосон билээ. Энэ удаа 2015 оны Эрүүгийн хуульд туссан “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэргийн зохицуулалтад хийсэн судалгааг толилуулж байна. Тус судалгааны ажлыг Б.Түмэндэмбэрэл ахлагчтай судалгааны баг гүйцэтгэсэн бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг жил тутам өсөж байгаагийн зэрэгцээ хуулийн үйлчлэлд бүх хууль сахиулагч хамардаггүй, мөн бусад улсын адил хууль сахиулагчийн гэр бүл, ойр дотны хүний эрх ашгийг хамгаалах хэрэгцээ буй эсэхийг харгалзан үзэх эсэх зэрэг олон асуудлыг судалгаандаа хөндсөн юм. Бусад улс орны хууль тогтоомжид хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хувьд хууль сахиулагчийн шаардлага хууль ёсны байсан эсэх гэсэн шаардлагыг тогтоодог нь чухал зарчим бөгөөд манай хууль тогтоомжид энэ асуудал зохицуулагдаагүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй болохыг судалгаанд дүгнэсэн. Түүнчлэн судалгааны хүрээнд Монгол Улсад тодорхойлоогүй ойлголт болох хууль сахиулах үйл ажиллагаа, хууль сахиулагч гэдэг нэр томъёог тодорхойлохыг зорьсноос гадна хууль сахиулагчдаас практик судалгаа авсан нь онцлууштай байна.

Энэ судалгаа болон бусад судалгаатай www.forum.mn цахим хуудас болон манай байгууллагын нийгмийн сүлжээнд хандан танилцах боломжтойг дуулгахад таатай байна. Бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ	7
Судалгааны зорилго	7
Сэдвийн судлагдсан байдал	8
Судалгааны арга зүй	8
Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол	9

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ 10

1.1. Онолын үзэл баримтлал, нийтлэг тодорхойлолт	10
1.2. Эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил	11
1.3. Эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	12

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ, ҮР НӨЛӨӨ 14

2.1. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шийдвэрлэлт	14
• Цагдаагийн байгууллагын тоон мэдээлэл	14
• Прокурорын байгууллагын тоон мэдээлэл	14
• Шүүхийн тоон мэдээлэл	14
• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоон мэдээлэл	15
• Шүүхийн шийдвэрийн сангийн тоон мэдээлэл	16
2.2. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалттай холбоотой тулгамдаж буй асуудал	17
i. Хууль сахиулагч болон хууль сахиулах ажиллагааг нэг мөр тодорхойлох асуудал	17
ii. Хууль сахиулагчийн ойр дотны хүнийг Эрүүгийн хуулиар хамгаалах асуудал	24
iii. Хууль сахиулагчийн тавьсан шаардлагыг Эрүүгийн хуульд харгалзан үзэх эсэх тухай асуудал	25
iv. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг бүлэглэж үйлдэхтэй холбоотой асуудал	27

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 28

3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт, нөхцөл байдал	28
3.2. Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт, нөхцөл байдал	30

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ 33

4.1. Гэмт хэргийн нөхцөл байдал	33
4.2. Гэмт хэргийн шалтгаан	39
4.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	48

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 51

ЭХ СУРВАЛЖ 54

ХАВСРАЛТ 56

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Асуулгад оролцогчдын эрхэлж буй ажил	8
Хүснэгт 2.	Асуулгад оролцогчдын насны байдал	9
Хүснэгт 3.	Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн түүхэн уламжлал (“Хууль сахиулагч” гэдгийг тодорхойлсон байдал)	11
Хүснэгт 4.	Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт	12
Хүснэгт 5.	Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын нэр томъёоны тайлбар	13
Хүснэгт 6.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоон мэдээ	14
Хүснэгт 7.	Прокурорын байгууллагаас Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт хяналт тавьсан байдал	14
Хүснэгт 8.	Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал	14
Хүснэгт 9.	Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн мэдээлэл (Ял шийтгүүлсэн бүх этгээд, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдсэн этгээд)	15
Хүснэгт 10.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик /Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоон мэдээлэл/	15
Хүснэгт 11.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик /Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн ялын шийдвэрийн гүйцэтгэл/	16
Хүснэгт 12.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик /Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт оногдуулсан торгох ялын үзүүлэлт/	16
Хүснэгт 13.	Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд	16
Хүснэгт 14.	2002 болон 2015 оны Эрүүгийн хуульд “хууль сахиулагч” гэх нэр томъёог тодорхойлсон байдал	17
Хүснэгт 15.	Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд тодорхойлсон хууль сахиулах ажиллагааны төрлүүд	19
Хүснэгт 16.	Гадаадын улс орнуудын эрх зүйн зохицуулалтад “хууль сахиулагч”-ийг тодорхойлсон байдал	20
Хүснэгт 17.	Шүүхийн шийдвэрт тодорхойлогдсон хууль сахиулагчдын төрлүүд	23
Хүснэгт 18.	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шүүхийн тоон мэдээнд тодорхойлсон хууль сахиулагчдын төрлүүд	23
Хүснэгт 19.	Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт холбогдох гэмт хэргийн хохирогч болсон цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан шаардлага	26
Хүснэгт 20.	Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт холбогдох гэмт хэргийн хохирогч болсон цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан шаардлага	25
Хүснэгт 21.	Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт холбогдох гэмт хэргийн хохирогч болсон цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан шаардлага	26
Хүснэгт 22.	Цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан, асуулгаар тодорхойлогдсон шаардлага	27
Хүснэгт 23.	Шүүхийн шийдвэрт тодорхойлсон хууль сахиулагчийн тавьсан шаардлага /23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг/	35
Хүснэгт 24.	Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл	36
Хүснэгт 25.	Шүүхийн шийдвэрт тодорхойлсон хууль сахиулагчийн тавьсан шаардлага /23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг/	36
Хүснэгт 26.	Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэхдээ халдсан объектууд	36
Хүснэгт 27.	Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд албадын дарга нарын хүлээн авдаг байдал	42
Хүснэгт 28.	Хууль сахиулагчийн эрх ашгийг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчны талаарх хууль сахиулагчдын үнэлэмж	43

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Эсэргүүцэл үзүүлсэн иргэдэд тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлага	37
График 2.	Иргэдийн эсэргүүцлийн хэлбэр	38
График 3.	Гэмт хэргийн шалтгаан (судалгаанд хамрагдагсдын хариулснаар)	40
График 4.	Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 7 дахь асуултад хариулсан байдал	40
График 5.	Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 9 дэх асуултад хариулсан байдал	41
График 6.	Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 11 дэх асуултад хариулсан байдал	41
График 7.	Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 12 дахь асуултад хариулсан байдал	42

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	Улс орнуудын Эрүүгийн хуульд Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг зохицуулсан байдал	56
Хавсралт 2.	Америкийн Нэгдсэн Улсын хууль сахиулах байгууллагуудын бүтэц	58
Хавсралт 3.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хууль сахиулах байгууллагуудын бүтэц	61
Хавсралт 4.	АСУУЛГА-СУДАЛГААНЫ ХАРИУЛТ	63
Хавсралт 5.	СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮД	71

УДИРТГАЛ

Судалгааны зорилго

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хорин гуравдугаар бүлэг “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-т хамаарах 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэргийг хуульчилсан.¹

Практикт энэхүү зүйл, заалтын хүрээнд тулгамдаж буй асуудал нэлээд байдаг талаар алба хаагчдын зүгээс ярьдаг бөгөөд хууль хэрэгжиж эхлээд жил гаруйн хугацаанд буюу 2018 онд тус зүйл ангийн хүрээнд үйлдсэн 85 гэмт хэрэг шинээр бүртгэгдэж, 154 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан бол² 2019 онд 97 гэмт хэрэг шинээр бүртгэгдэж, 189 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа³, 2020 онд 198 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа⁴, 2021 онд 241 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа⁵ тус тус явуулснаас үзэхэд энэхүү зүйлд заасан гэмт хэргийн гаралт жил ирэх тутам өсөж байгаа нь харагдаж байна. Мөн тухайн бүлгийн хүрээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа нийт гэмт хэргийн 24-30 орчим хувь, шинээр бүртгэгдэж байгаа нийт хэргийн 27-36 хувийг энэ гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг эзэлж байна.

Түүнчлэн ХЗҮХ-гийн зүгээс 2021 онд цагдаагийн алба хаагчдаас Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох талаар санал авахад тус зүйл ангид заасан гэмт хэргийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал өгсөн байдаг. Тухайлбал, хөдөө сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын гэр бүлд заналхийлэх, дарамтлах асуудал цөөнгүй гардаг учраас “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан өөрийг нь болон тэдний гэр бүлийн гишүүдэд...” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн уг зохицуулалтын санкцыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн санал ирүүлжээ.

“Хууль сахиулагч” гэх ойлголтыг Эрүүгийн хуульд “цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно” гэж зааснаас үзэхэд энэ бүх субъектийн албан үүргээ гүйцэтгэхдээ тавьж буй хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх асуудал нэлээд өргөн хүрээг хамарсан зохицуулалт болох нь харагдаж байна. Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг өмнө нь судалж байгаагүйн зэрэгцээ ойрын жилүүдэд, ялангуяа Ковид-19 цар тахлын үеэр энэ төрлийн гэмт хэргийн гаралт өссөн зэрэгтэй уялдуулан тухайн чиглэлийн судалгааны хэрэгцээ шаардлага их байна. Иймд энэ гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, хүндрэлийг олж тогтоох шаардлага тулгарсан.

Энэхүү судалгаагаар Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийн, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, ойлгомжгүй асуудал байгаа эсэхийг илрүүлэх, уг зохицуулалт хууль сахиулагчийн албан үүргээ гүйцэтгэх баталгааг хангаж чадаж буй эсэхийг судалж тогтоох зорилготой. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтын онолын үзэл баримтлал, нийтлэг тодорхойлолт, түүхэн уламжлал, өнөөгийн байдлыг тодорхойлох;
2. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтын хэрэгжилт, түүнтэй холбоотой асуудлыг тодорхойлох, даван туулах арга замыг нээн илрүүлэх;
3. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтыг бусад улс орны тухайн зохицуулалттай харьцуулан судалж, сайн жишгийг тодорхойлох;
4. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох.

¹ Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2016, №7.

² Гэмт хэргийн цагаан ном. 2018, УБ., 2019, 89 дэх тал.

³ Гэмт хэргийн цагаан ном. 2019, УБ., 2020, 207 дахь тал.

⁴ 2020 оны Прокурорын байгууллагын тоон мэдээ.

⁵ Мөн тэнд.

Сэдвийн судлагдсан байдал

Тухайн гэмт хэрэг нь хууль сахиулагчийг эсэргүүцэх, төрийн албан хаагч, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, төрийн албан хаагч, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох гэх нэрээр Эрүүгийн хуульд хуульчлагдаж ирсэн. Тухайн гэмт хэргийн талаар дагнасан судалгаа, нэг сэдэвт бүтээл, гарын авлага, ном товхимол гараагүй ч эрүүгийн эрх зүйн талаар бичсэн ном, бүтээлүүдэд тодорхой хэмжээгээр тусгагдаж иржээ.

“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” бүтээлд “2002 оны Эрүүгийн хуулийн төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн хор аюул нь захиргааны журамд халдаж, төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчдаас хууль тогтоомжид заасан нийгмийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах эрх хэмжээгээ хэрэгжүүлэхэд нь саад хийх байдлаар илэрнэ” гэж тайлбарласан байдаг. Мөн тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн талаар Н.Жанцангийн “Монгол Улсын эрүүгийн эрх зүй”, С.Нарангэрэлийн “Монгол Улсын эрүүгийн эрх зүй (Тусгай анги)”, Ж.Авхиагийн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эрүүгийн эрх” гэх бүтээлүүдэд тус тус авч үзжээ.

2015 оны Эрүүгийн хуульд тус гэмт хэргийг “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэж тодорхойлноос хойш тухайн гэмт хэргийн талаар хийсэн судалгаа, нэг сэдэвт бүтээл, ном, гарын авлага ховор байна. Харин С.Гантулга, Б.Энхболд нарын “Эрүүгийн эрх зүй: Тусгай анги” бүтээлд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг тодорхойлж, түүний бүрэлдэхүүн болон онцлог байдлыг авч үзсэн байна.

Судалгааны арга зүй

Тухайн судалгаанд баримт бичигт дүн шинжилгээ хийх, харьцуулан шинжлэх, институтийн, дуалист-диалектикийн, түүхчлэх, статистикийн, социологийн, ажиглалтын зэрэг аргыг өргөн хэрэглэлээ. Тус судалгаа нь үндсэн 4 бүлэг болон түүнд хамаарах 10 дэд бүлгээс бүрдэнэ. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн онолын ойлголтыг гаргаж ирэхдээ холбогдох ном, судалгааны бүтээл, эрх зүйн зохицуулалт зэрэгт дүн шинжилгээ хийсний зэрэгцээ бусад улс орны зохицуулалттай харьцуулан шинжилж судаллаа. Ингэхдээ тухайн гэмт хэргийг тогтолцооны түвшинд тодорхойлж, институцийн арга ашигласан юм.

Гэмт хэргийн зохицуулалтын түүхэн уламжлал болон одоогийн зохицуулалтыг холбогдох эх сурвалжид дүн шинжилгээ хийх замаар онцлог, ялгаатай байдлыг нь тогтоон, харьцуулан судлахыг зорьсон. Тус зохицуулалтын хэрэгжилтийг статистик, социологи, ажиглалтын арга ашиглан судлахдаа цагдаагийн байгууллага, прокурорын байгууллага, шүүхийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн дүгнэсэн.

Мөн Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтын хэрэгжилттэй холбоотой тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох үүднээс холбогдох эх сурвалжид дүн шинжилгээ хийх, нэр томьёоны хувьд герменевтик арга ашиглан гол агуулгыг нь нээн илрүүлэх, салбарын мэргэжилтэн, экспертээс ярилцлага, анкетын судалгаа авах, статистикийн аргаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар тодорхой дүгнэлт хийлээ. Түүнчлэн Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоомжтой харьцуулан судаллаа.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилгоор 4 бүлэг 39 асуултаас бүрдэх анкетын асуулгыг нийт 2522 орчим хууль сахиулагчаас авсан. Асуулгад оролцсон хууль сахиулагчдаас 1542 нь өөрийн албан тушаалын талаар мэдээлэл өгсөн бөгөөд дараах 23 төрлийн ажил үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид байна.

Хүснэгт 1. Асуулгад оролцогчдын эрхэлж буй ажил

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Эрүүгийн мөрдөгч	260	16.8%
2	Хэсгийн цагдаа	175	11.3%
3	Эргүүл хамгаалалтын цагдаа	134	8.7%
4	Цагдаа зохицуулагч	134	8.7%
5	Харуулын цагдаа	104	6.7%
6	Ахлах мөрдөгч	116	7.5%
7	Цагдаа жолооч	188	12.2%

Хүснэгт 1-ийн үргэлжлэл.

8	Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн	98	6.3%
9	Мэдээлэл хүлээн авагч	58	3.7%
10	Ахлах байцаагч	56	3.6%
11	Дэд ахлагч	53	3.4%
12	Цагдаагийн дэслэгч	35	2.2%
13	Цагдаагийн газрын бичиг хэргийн эрхлэгч, архивч	28	1.8%
14	Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч	19	1.2%
15	Эргүүл хамгаалалтын офицер	14	0.9%
16	Шуурхай удирдлагын тасаг	14	0.9%
17	Бичээч, архивч	14	0.9%
18	Харуул	13	0.8%
19	Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч	7	0.4%
20	Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч	5	0.3%
21	Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн	11	0.7%
22	Цагдаагийн нярав	4	0.2%
23	Жижүүрийн техникийн мэргэжилтэн	2	0.1%
Нийт		1542	100%

Асуулгад оролцогчдын 2447 нь настай холбоотой мэдээлэл өгсөн бөгөөд 42.7 хувь нь 18-30, 47 хувь нь 31-40, 10.1 хувь нь 41-50, 0.2 хувь нь 50-60 настай байв.

Хүснэгт 2. Асуулгад оролцогчдын насны байдал

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	18-30	1045	42.7%
2	31-40	1150	47.0%
3	41-50	248	10.1%
4	50-60	4	0.2%
5	60-аас дээш	0	0.0%
Нийт		2447	100%

Асуулгад оролцогчдын 2437 нь хүйсээ тодорхойлж бичсэн байсан бөгөөд тэдний 13 хувь нь эмэгтэй, 87 хувь нь эрэгтэй байна.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол

Тухайн судалгааны ажил нь хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн талаар Монгол Улсад хийж гүйцэтгэсэн судалгааны цөөн бүтээлийн нэг бөгөөд дараах ач холбогдолтой:

- 2015 оны Эрүүгийн хууль батлагдсанаас хойш хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн талаар нэг ч судалгаа хийгдээгүй үед хийгдсэн;
- Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтын онол, нийтлэг тодорхойлолтыг судалсан;
- Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хэрэгжилтийн үр дагавар, шийдвэрлэх арга замыг өргөн хүрээнд судалсан бөгөөд шүүх, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээллийг хамруулсан;
- Тухайн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл буюу түүний криминологи шинжийг судалсан.

НЭГ. ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1. Онолын үзэл баримтлал, нийтлэг тодорхойлолт

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэх ойлголт нь хууль сахиулагчид албан үүргээ биелүүлэх явцад нь саад учруулах, саад тотгор бий болгох зэргээр илэрхийлэгдэнэ. Хууль сахиулагчийг эсэргүүцэх нь нийгмийн үзэгдэл бөгөөд үүнийг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оноож байна. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэдэг ойлголтын түгээмэл тодорхойлолт, онолын үзэл баримтлал нэг мөр тогтоогүй байгаа ч улс орон бүр өөр өөрийн эрх зүйн тогтолцоонд үүнийг гэмт хэрэг хэмээн үзэж, янз бүрээр зохицуулдаг. Энэ нь тухайн улс орны гэмт хэргийн гаралт, давтамж, хор хөнөөл, нийгэмд аюултай байдал болон хууль сахиулагчийн нийгмийн баталгаа зэрэгтэй холбоотой байж болох юм. Тухайлбал, Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуульд албан үүргийг тодорхойлж, хууль сахиулах байгууллагын ажилтан, цэргийн алба хаагч тус хуулийн үйлчлэлд хамаарахыг зохицуулсан, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хуульд үйлдлийн аргыг өөрөөр тодорхойлж, төрийн байгууллагын ажилтан тус хуулийн үйлчлэлд хамаарахыг зохицуулсан, Бүгд Найрамдах Киргиз Улсын хувьд хууль сахиулагчийн ойр дотны хүн хуулийн үйлчлэлд хамаарахыг зохицуулсан, Молдова улсын хувьд хууль сахиулагчийн биед гэмтэл учирснаар гэмт хэрэгт тооцохоор зохицуулсан, Данийн Хаант Улсын хувьд ерөнхий байдлаар зохицуулсан, Япон Улсын хувьд доромжлох, албан үүрэг гүйцэтгэхээс татгалзуулсныг тусгасан, Бүгд Найрамдах Эстони Улсын хувьд хуулийн этгээд тухайн үйлдлийг хийсэн тохиолдлыг зохицуулсан зэргээр улс орон бүрд өөр өөрөөр хуульчлагдсан байна (Тухайн улс орнуудад Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг хэрхэн зохицуулсан талаар Хавсралт 1-ээс харна уу).

Энэ гэмт хэргийг мөн Оксфордын эрх зүйн толь бичигт ерөнхий байдлаар тодорхойлсон байна. Албан үүргээ гүйцэтгэж байгаа хууль сахиулагчид саад учруулах гэмт хэргийн хувьд "саад учруулах" гэдэгт аливаа санаатай, хөндлөнгийн оролцоо байх ёстой. Жишээлбэл, биеийн хүч хэрэглэх, заналхийлэх, худал хэлэх, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх, саад тотгорыг арилгахад хамтран ажиллахаас татгалзах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэхэд саад хийн хэргээс мултлахын тулд түүнд сэрэмжлүүлэх (жишээ нь, хурд хэтрүүлсэн жолоочид цагдаа нар бүсэлсэн байгааг анхааруулах) гэх мэт үйлдлүүд байна. Гэсэн хэдий ч цагдаад хариулах шаардлагагүй асуултад хариулахгүй байх, эсвэл хэн нэгэнд хариулахгүй байхыг зөвлөсөн нь гэмт хэрэг биш юм. Цагдаагийн алба хаагчийг гэмт хэргээс (ялангуяа амгалан тайван байдал алдагдуулах үйлдлээс) урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, эсвэл дарга нарын тушаал биелүүлж байгаа тохиолдолд үүргээ гүйцэтгэж байна гэж үзнэ. Цагдаагийн ажилтан энгийн хувцастай байсан ч энэ гэмт хэрэгт хамаарч болно⁶. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэдэгт дараах үйлдлүүдийг хамруулан үзжээ:

- Хүч хэрэглэсэн эсэхээс үл хамааран баривчлахыг эсэргүүцэх;
- Цагдаагийн мөрдөн байцаалтад саад учруулах;
- Офицерт худал хэлэх;
- Албан тушаалтанд худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх;
- Офицeroос гүйж зугтаах;
- Офицерыг заналхийлэх;
- Офицерыг цохих гэх үйлдлүүд хамаарна.⁷

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Нью-Йорк хотод батлагдсан НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 23 дугаар зүйл буюу "Шударга ёсыг тогтооход саад хийх үйлдлийг гэмт хэрэг болгох" гэх хэсэгт хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалт орсон. Монгол Улс уг конвенцод 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тус конвенц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Уг конвенцын зорилго нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудлыг үр өгөөжтэй шийдвэрлэх чиглэлээр талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино. Харин олон улсын бусад гэрээнд тухайн гэмт хэрэг агуулгаараа тусаагүй.

Дээрх конвенцын дагуу оролцогч улс нь конвенцод туссан гэмт хэргийг шүүн таслахад саад учруулсан дараах үйлдүүдийг гэмт хэрэгт тооцохыг үүрэг болгосон. Үүнд:

(а) бие махбодын хүч хэрэглэх, заналхийлэх, айлган сүрдүүлэх, амлалт өгөх, давуу эрх олгох байдлаар хуурамч мэдүүлэг өгүүлэх, мэдүүлэг өгөх, нотлох баримт гаргаж өгөхөд хөндлөнгөөс оролцох, (b) энэхүү конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдуулан бие махбодын хүч хэрэглэх, заналхийлэх, айлган сүрдүүлэх байдлаар шүүх, хууль сахиулагчийн үйл

⁶ Oxford Reference: Obstructing a police officer, <https://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.20110810105516484>

⁷ Have You Been Charged with Obstructing or Hindering a Law Enforcement Officer in Georgia?, <https://www.georgiacriminalawyer.com/obstruction-of-a-law-enforcement-officer>

ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, саад хийх гэмт хэргүүд хамаарна. Ийнхүү тус конвенцын (b) хэсэгт тус гэмт хэргийг Эрүүгийн хуульд хуульчлах талаарх шаардлага тавьжээ⁸.

1.2. Эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ээс эхлэн 2015 оны “Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)” хүртэл хуульчлагдсан түүхэн уламжлалтай. 1926 оны “Шүүх цаазын бичиг”, 1929 оны “Шүүх цаазын бичиг”, 1934 оны “Шүүх цаазын бичиг”, 1942 оны “Эрүүгийн хууль”, 1961 оны “Эрүүгийн хууль”, 1985 оны “Эрүүгийн хууль”, 2002 оны “Эрүүгийн хууль”, 2015 оны “Эрүүгийн хууль”-д хуульчлагдахдаа зохицуулалт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний түвшинд тухай бүр өөрчлөгдсөөр иржээ.

Хүснэгт 3. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн түүхэн уламжлал (“Хууль сахиулагч” гэдгийг тодорхойлсон байдал)

Хуулийн нэр	Хууль сахиулагч буюу гэмт хэргийн хохирогчийг хуульчилсан байдал
1926 оны “Шүүх цаазын бичиг”	Гэмт хэргийн хохирогч нь оноосон албыг гүйцэтгэх аливаа хүн, аливаа албан тушаалтан байсан.
1934 оны “Шүүх цаазын бичиг”	Засгийг төлөөлөн яваа этгээд болох албан тушаалтан нь гэмт хэргийн хохирогч болж зохицуулагдсан.
1942 оны “Эрүүгийн хууль”	Албан тушаалын хүмүүс буюу олон нийтийн ажилтан нь хохирогч байна.
1961 оны “Эрүүгийн хууль”	Гэмт хэргийн хохирогч нь цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагын, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүн байна.
2002 оны “Эрүүгийн хууль”	Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч байхаар зохицуулсан.
2015 оны “Эрүүгийн хууль”	Хууль сахиулагч гэх байдлаар зохицуулсан.

Харин үйлдлийн тухайд хүч хэрэглэн эсэргүүцсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, доромжилсон үйлдлүүд нь 2002 оноос өмнөх Эрүүгийн хуулиудад нийтлэг байсан бол 2015 оны “Эрүүгийн хууль”-д доромжилсон гэх үйлдлийг хасаж хуульчилсан. Эрүүгийн хариуцлагын тухайд 6 сар хорихоос эхлэн цаазаар авах хүртэл янз бүрийн ял оноохоор зохицуулж ирсэн.

Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт “Эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг алсан”, 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатайгаар учруулсан” гэж хуульчилсан. Өмнөх хуульд (1926 оны “Шүүх цаазын бичиг”, 1929 оны “Шүүх цаазын бичиг”, 2002 оны “Эрүүгийн хууль” зэрэг хуулиудад) дээрх зохицуулалтыг хууль сахиулагч, төрийн албан хаагчийн хувьд хүнд хохирол учруулах, алсан тохиолдолд төрийн албан хаагчийг эсэргүүцэх гэмт хэргийн бүрэлдэхүүн болгон хуульчилсан байжээ. Энэ нь тухайн үед асуудал болоод байсан ба энэ талаар “2002 оны Эрүүгийн хуулийн 96.2-т “Бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол 7-гоос дээш, 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ. Гэтэл Эрүүгийн хуулийн 230.4-т буюу Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд “...Энэ хэргийн улмаас төрийн албан хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодод хүнд гэмтэл учирсан бол 100-500 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 5-аас 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж Эрүүгийн хуулийн 96.2-т зааснаас оногдуулах ялын төрөл, хэмжээг хөнгөрүүлэн заажээ. Өөрөөр хэлбэл, 2002 оны Эрүүгийн хуулийн 96.2 болон 230.4-т зааснаар хууль сахиулагчид хүнд гэмтэл учруулсан тохиолдолд энгийн хүнд хүнд гэмтэл учруулахаас бага ял оногдуулахаар байна.

Энэ нь нэг талаар төрөөс цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчийн эрх ашиг, үйл ажиллагааг дэмждэг эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа төдийгүй улмаар цагдаагийн алба хаагчид халдаж болдог, халдсан ч хөнгөн ял авдаг гэсэн сэтгэл зүйг нийгэмд төрүүлж болзошгүй, нөгөө талаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага, албан хаагчаа төрөөс эрүүгийн бодлогоор дэмжих нь хүн, төр, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах эрүүгийн эрх зүйн зорилтыг хангахад чухал нөлөө болж чадах юм⁹ гэж асуудлыг хөндөж судалсан байна. 2015 оны Эрүүгийн хуулиар дээрх гэмт хэргийг тусад нь гэмт хэрэг болгон зохицуулж тухайн асуудлыг шийдвэрлэсэн буюу 23.1 дүгээр зүйлд заасан хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэх явцдаа хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан болон хүнийг алсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2-ын 2.9 дэх хэсэг, 11.1 дүгээр зүйлийн 2-ын 2.1 дэх хэсэгт зохицуулснаар зүйлчилж байхаар хуульчилж дээрх алдааг засварласан байна.

⁸ United Nations Convention against Transnational Organized Crime. New York, 15 November 2000, https://treaties.un.org/doc/Treaties/2000/11/20001115%2011-11%20AM/Ch_XVIII,p.12.pdf

⁹ Л.Дорждэрэм. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, доромжлох гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, криминологийн зарим асуудал. 2013. “<https://www.esan.mn>”

1.3. Эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Одоогийн зохицуулалт буюу 2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтад хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг тусгахдаа 23.1 дүгээр зүйлд хуульчилсан. Ингэж зохицуулахдаа 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт энгийн бүрэлдэхүүнийг “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн” гэж хуульчилсан бол 23.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүнийг “галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, эсвэл хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн” гэж хуульчилсан. Мөн Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарт “Энэ хуульд заасан “хууль сахиулагч” гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно” гэж тайлбарласан. 2015 онд тухайн зохицуулалт хуульчлагдсанаас хойш 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэг удаа өөрчлөлт орсон ба тухайн өөрчлөлт нь “нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэснийг “зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчилсөн. Ийнхүү өөрчлөхдөө хорих ялын доод хэмжээг 7 хоног байхаар тогтоосон нь өргөн уудам нутагтай, хүн ам тархан суурьшсан, хорих байгууллагын сүлжээ, дэд бүтэц хангалттай хөгжөөгүй манай орны нөхцөлд хэрэгжих боломжгүй төдийгүй уг ялыг хэрэгжүүлэхийн тулд бодит хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй их хэмжээний зардал гарах, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан гэм буруугаа шүүхээр эцэслэн тогтоолгох, шүүхэд давж заалдах үндсэн эрхийг хязгаарласан байгааг үндэслэн хорих ялын доод хэмжээг дахин оновчтой тодорхойлж, ерөнхий ангид заасан ялын бодлогыг уялдуулан дахин хянах¹⁰ гэх үзэл баримтлалыг баримталжээ.

Хүснэгт 4. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт

2015 оны Эрүүгийн хууль	2017 оны Зөрчлийн тухай хууль
<p>23.1 дүгээр зүйл. Хууль сахиулагчийг эсэргүүцэх</p> <p>1.Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж;</p> <p>2.2.хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: Энэ хуульд заасан “хууль сахиулагч” гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн</p>	<p>15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах</p> <p>1.Төрийн албан хаагч, эсхүл улсын байцаагчийн эрхтэй этгээдийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор</p> <p>1.1.тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг бусдад уриалсан;</p> <p>1.2.хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн;</p> <p>1.3.хийсэн үйл ажиллагаанд нь саад учруулсан, эсхүл хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа</p> <p>2.1.төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;</p> <p>2.2.төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан;</p>

¹⁰ 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

<p>тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно.</p>	<p>2.3.төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Тайлбар: Энэ хуульд заасан “хууль сахиулах чиг үүрэг” гэж цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно.</p>
--	--

Дээрх хуулийн зохицуулалтаас харвал хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг болон зөрчлийн ялгаа нь тус бүрийн хууль бус үйлдлээр ялгарч байна. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хувьд хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн үйлдэл байх бол зөрчлийн хувьд хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан, үйл ажиллагаанд нь саад учруулсан, хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон үйлдэл туссан. 2002 оны Эрүүгийн хуулийн 231 дүгээр зүйлд заасан төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох гэмт хэрэг нь зөрчил болон хуульчлагджээ. Ийнхүү хуульчлагдсан нь 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-ын 1 дэх хэсэгт заасан зөрчил болон 2002 оны Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн “эсэргүүцсэн, хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан, гүтгэсэн, доромжилсон” гэх үйлдлүүд давхацсан, бүрэлдэхүүнийг ялгаагүй байхаар хуульчилсны улмаас практикт хэрэглэхэд хүндрэл учруулж, үндсэндээ хэрэглэх ямар ч боломжгүй болсон¹¹ байсныг ийнхүү залруулжээ.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг гэдгийг “үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан эсэргүүцсэн нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм. Хууль сахиулагч нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах талаар хуулиар хүлээлгэсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг тул гэмт этгээд, хууль зөрчсөн иргэдээс тэднийг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад хийх тохиолдол цөөнгүй байдаг. 2015 оны Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжтэйгээр хуульчилсан” гэж тодорхойлсон. Үүнээс гадна тус гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг авч үзэж объектив шинж, субъектив шинжээр тайлбарласан. Тухайн гэмт хэргийн нэр томъёоны тайлбарын тухайд дараах байдлаар тайлбарласан байна.

Хүснэгт 5. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын нэр томъёоны тайлбар

Галт зэвсэг	Дарийн шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж, амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг ойлгоно.
Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл	Иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно.
Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл	Хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно.
Хууль сахиулах албаны тоног төхөөрөмжид халдаж үйлдсэн	Цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх, тагнуулын байгууллагын мөрдөн шалгах, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагчид үүрэг гүйцэтгэхэд нь зориулж олгосон, эсхүл тоногдосон объект, тээврийн хэрэгсэл, холбооны хэрэгсэл, олон хүнд нөлөөлж болон нэг бүрийн тусгай хэрэгсэлд халдаж, булаан авч, эвдэж, гэмтээснийг ойлгоно.
Барилга, байгууламжид халдсан	Хууль сахиулагчийн үйл ажиллагаа явуулдаг, тийм зориулалтаар урт болон богино хугацаанд байрлах орон сууц, зэвсэг техникийн агуулах, сургалт, дадлагын цогцолбор, түр саатуулах, цагдан хорих, хорих ангийн байгууламжид халдаж үйлдсэнийг ойлгоно. ¹²

¹¹ Л.Дорждэрэм. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, доромжлох гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, криминологийн зарим асуудал. 2013. “<https://www.esan.mn>”

¹² С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги. УБ., 2018, 410 дахь тал.

ХОЁР. ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ, ҮР НӨЛӨӨ

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж буй байдлыг цагдаа, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон шүүхийн шийдвэрийн сангийн мэдээлэлд үндэслэн судаллаа.

2.1. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шийдвэрлэлт

• Цагдаагийн байгууллагын тоон мэдээлэл

2017-2021 онд Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу Хууль сахиулагчийг эсэргүүцэх 451 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ. Тус статистикаас харахад энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Хүснэгт 6. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоон мэдээ¹³

Он	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийн тоо	Өсөлт, бууралт хувиар
2017	46	
2018	85	
2019	97	+14.1%
2020	116	+19.6%
2021 оны 8 дугаар сар	107	-7.7%
Нийт	451	

• Прокурорын байгууллагын тоон мэдээлэл

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тухайд прокурорын байгууллага 2020 онд нийт 198 хэрэг, 2021 онд нийт 241 хэрэгт тус тус хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулжээ. Энэ нь тухайн онуудад тус гэмт хэрэг 21.7 хувиар өссөн байх үзүүлэлт юм. Энэхүү хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 7. Прокурорын байгууллагаас Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт хяналт тавьсан байдал¹⁴

	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
2020	198	2	116	3	33	143
2021	241	24	140	6	39	191

• Шүүхийн тоон мэдээлэл

Шүүхээр шийдвэрлэгдсэн Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг 2017-2020 оны хооронд нийт 279 байна.

Хүснэгт 8. Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал¹⁵

Он	Хянан шийдвэрлэсэн хэрэг	Өсөлт, бууралт, хувиар
2017 оны 7 дугаар сараас хойш	38	
2018	73	
2019	66	-10%
2020	102	+35%
Нийт	279	

¹³ Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээ.

¹⁴ Прокурорын байгууллагаас ирүүлсэн тоон мэдээ.

¹⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээ.

2015 оны Эрүүгийн хууль мөрдөгдөж эхэлснээс хойш 2020 оныг дуустал Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлээр ял шийтгэгдсэн нийт 279 хэрэг байна. Үүнээс Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх, чөлөөлөх арга хэмжээ авхуулсан 48, Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан тэнсэгдсэн 83, хорих ялаас чөлөөлсөн 11 хэрэг байх буюу ихэнх тохиолдолд шүүгдэгчийн ялыг тэнсэж шийдвэрлэжээ. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт 179 хүн холбогдсоноос 16 эмэгтэй байна.

Хүснэгт 9. Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн мэдээлэл (Ял шийтгүүлсэн бүх этгээд, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдсэн этгээд)

Огноо	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх			Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн			Ял шийтгүүлсэн бүгд			
	Бүгд	ЭХ-ийн 6.7.1.1, 2	ЭХ-ийн 7.1	Зорчих эрхийг хязгаарлах ялаас чөлөөлсөн	Хорих ялаас чөлөөлсөн	Торгох ялаас чөлөөлсөн	Нийт холбогдсон этгээд	Үүнээс эмэгтэй	Өсвөр насны хүн	Хуулийн этгээд
2017 оны 7 дугаар сараас хойш	25	15	10	-	6	-	14	1	-	-
2018 он	37	9	28	-	2	-	56	4	-	-
2019 он	30	11	19	-	-	-	37	5	-	-
2020 он	39	13	26	-	3	1	72	6	-	-
Нийт	131	48	83	-	11	1	179	16	-	-

Тухайн гэмт хэрэг үйлдэж гэмт буруутай нь тогтоогдсон этгээдүүдийн 36 нь өмнө 1 удаа гэмт хэрэг үйлдсэн, 22 нь өмнө 2 удаа гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан байна. Мөн 73 нь тус гэмт хэргийг согтуугаар үйлдсэн нь нийт хэрэгт холбогдсон хүмүүсийн 55 хувь буюу өндөр үзүүлэлт юм.

• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоон мэдээлэл

1) Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлын судалгаа

Тус гэмт хэрэгт ял шийтгүүлсэн нийт этгээдээс хорих ял эдэлж буй нь нийт 9 байна.

Хүснэгт 10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик /Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоон мэдээлэл/

№	Огноо	23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	23.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг	23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг	Нийт
1	2017	3	-	-	3
2	2018	2	-	-	2
3	2019	1	-	-	1
4	2020	3	-	-	3
5	2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар	-	-	-	-
	Нийт	9	-	-	9

2) Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт торгох, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэсэн шийдвэрийн хэрэгжилт

Тус гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн байхгүй байна. Харин торгох ялын тухайд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар нийт 120 хүн тухайн ялаар шийтгүүлжээ.

Хүснэгт 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик /Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн ялын шийдвэрийн гүйцэтгэл/

Д/д	Ялын төрөл	Огноо	Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл
1	Торгох	2017	7	2	5
		2018	14	12	2
		2019	24	14	10
		2020	33	33	0
		2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар	42	35	7
2	Зорчих эрхийг хязгаарлах	2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар	-	-	-
Нийт дүн			120	96	24

3) Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт торгох ял шийтгүүлсэн ялтны судалгаа

Тус гэмт хэрэгт торгох ялаар шийтгүүлсэн нийт 112 хүн байна.

Хүснэгт 12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик /Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт оногдуулсан торгох ялын үзүүлэлт/

Д/д	Огноо	23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг		23.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг		23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг	
		Ялтны тоо	Торгуулийн хэмжээ /мянган төгрөг/	Ялтны тоо	Торгуулийн хэмжээ	Ялтны тоо	Торгуулийн хэмжээ /мянган төгрөг/
1	2017	7	19605.0				
2	2018	14	39850.0				
3	2019	21	60510.0			3	19400.0
4	2020	30	87030.0			3	16800.0
5	2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар	40	118585.0			2	10900.0
Нийт		112	325580.0	-	-	8	47100.0

Тус гэмт хэрэгт торгох ялаар шийтгүүлсэн этгээдийн тоо жил ирэх тусам өсжээ.

• Шүүхийн шийдвэрийн сангийн тоон мэдээлэл

2017 оны 7 дугаар сараас 2021 оны 9 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд шүүхийн шийдвэрийн санд бүртгэгдсэн шийдвэрийг ангилбал Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хамаарах хэрэг дийлэнх хувийг нь эзэлж байгаагийн зэрэгцээ өссөн үзүүлэлттэй байна. Харин 23.1 дүгээр зүйлийн 2.1, 2.2 дахь хэсгийн тухайд жигд бага байна.

Хүснэгт 13. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд¹⁶

Огноо	Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг	Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг
2017 оны 7 дугаар сараас хойш	34	1	2
2018 он	59	5	1
2019 он	49	3	5
2020 он	66	3	5
2021 оны 9 дүгээр сарын 1 хүртэл	70	4	5

¹⁶ Шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://shuukh.mn/>

2.2. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалттай холбоотой тулгамдаж буй асуудал

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл буюу криминологи шинжтэй асуудлаас гадна зохицуулалттай холбоотой дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

- Хууль сахиулах ажиллагаа болон хууль сахиулагчийг нэг мөр тодорхойлох асуудал;
- Хууль сахиулагчийн ойр дотны хүний эрх ашгийг Эрүүгийн хуулиар хамгаалах эсэх тухай асуудал;
- Хууль сахиулагчийн тавьсан шаардлагын талаар Эрүүгийн хуульд хуульчлах, түүнийг харгалзан үзэж зохицуулах асуудал;
- Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг бүлэглэж үйлдэх нь түүний бүрэлдэхүүн байх эсэх тухай асуудал.

1. Хууль сахиулагч болон хууль сахиулах ажиллагааг нэг мөр тодорхойлох асуудал

2015 оны Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарт “цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагч”-ийг хууль сахиулагч хэмээн хуульчилсан. Дээрх субъектийн тодорхойлолт оновчтой эсэх, үүнийг хэрхэн тайлбарлахыг судлах шаардлагатай байна. Учир нь тухайн тодорхойлолт хэт ерөнхий тул ойлгомжгүй байдал бий болгосон юм. Тухайлбал, “хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд” гэдгийг хэрхэн ойлгох нь эргэлзээ үүсгэж байна. Үүнийг судлахын тулд суурь ойлголт болох хууль сахиулах ажиллагааг давхар судлах нь зүйтэй.

Үүний зэрэгцээ хууль сахиулагч гэсэн тодорхойлолтод хамаарах субъектүүдийн хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой эрх ашиг, ашиг сонирхол Эрүүгийн хуулиар хэрхэн хамгаалагдаж буйг судлах ёстой.

Дээрх асуудлыг судалж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд тухайн нэр томъёоны хуульчлагдсан үйл явц болон бусад хууль, гадаадын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах шаардлагатай. Ингэснээр хуулиудад хууль сахиулагч гэх нэр томъёоны тодорхойлогдсон байдал болон хууль сахиулах үйл ажиллагааны талаар ойлголттой болж, хууль сахиулагч гэдгийг оновчтой тодорхойлох боломж бүрдэнэ.

2002 оны Эрүүгийн хуульд хууль сахиулагч гэх нэр томъёог мөн аутентик тайлбараар зохицуулж хуульчилсан байна. Ингэхдээ 2002 оны Эрүүгийн хуульд “хууль сахиулагч”-ийн оронд “төрийн албан хаагч” гэх нэр томъёогоор зохицуулжээ.

Хүснэгт 14. 2002 болон 2015 оны Эрүүгийн хуульд “хууль сахиулагч” гэх нэр томъёог тодорхойлсон байдал

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
Шүүгч	Цагдаа
Прокурор	Тагнуул
Хэрэг бүртгэгч	Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч
Мөрдөн байцаагч	Төрийн тусгай албаны алба хаагч
Цагдаа	Хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	Байгаль хамгаалагч
Хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч	

2015 оны Эрүүгийн хуульд “хууль сахиулагч” гэх нэр томъёог аутентик тайлбараар хэрхэн тайлбарлах талаар саналууд гарч байжээ.

УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийх үеийн тэмдэглэлд туссанаар тухайн зохицуулалттай холбоотой тайлбар нэмсэн байна. Тухайлбал, төслийн 4.1 дүгээр зүйлд ““хууль сахиулагч” гэдэгт хуульд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх, албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий албан хаагчийг ойлгоно” гэх томъёолол тусгах саналыг ажлын хэсэг гаргасныг Байнгын хорооны гишүүдийн 87.2 хувийн саналаар дэмжжээ.¹⁷

2015 оны Эрүүгийн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай холбогдох байнгын хорооны танилцуулгын зарчмын зөрүүтэй саналын томъёололд “тухайн зохицуулалтын талаар төслийн 4.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх” гээд энэ хуульд заасан “хууль сахиулагч” гэж цагдаа, тагнуул, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон улсын байцаагч, байгаль хамгаалагчийг ойлгоно¹⁸ гэж зохицуулахаар санал оруулсан.

¹⁷ Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/. Боть III, 41 дэх тал.

¹⁸ Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/. Боть IV, 150 дахь тал.

2015 оны Эрүүгийн хуулийн нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт тараасан төслийн эцсийн хувилбарт 4.1 дүгээр зүйлд хууль сахиулагч гэдгийг хуульд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх, албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий албан хаагчийг ойлгохоор тайлбарыг¹⁹ хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн нэгдсэн хуралдааны гар болон дэлгэрэнгүй тэмдэглэлд төслийн 4.2 дугаар зүйлийн тайлбарт энэ хуульд заасан "хууль сахиулагч" гэж цагдаа, тагнуул, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон улсын байцаагч, байгаль хамгаалагчийг ойлгохоор нэмэлт оруулах саналыг 70.2 хувийн саналаар дэмжсэн²⁰.

Улмаар нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тараасан хууль буюу эцсийн найруулгад Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлд "хууль сахиулагч" гэдгийг хуульд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх, албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий албан хаагчийг ойлгохоор, Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлд "хууль сахиулагч" гэж цагдаа, тагнуул, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон улсын байцаагч, байгаль хамгаалагчийг ойлгохоор тус тус зохицуулахаар тусгасан²¹.

Энэхүү эцсийн найруулгын талаар 2016 оны 01 дүгээр сарын 26-ны чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин "хуульд "хууль сахиулагч" гэх хоёр тайлбартай байгаа тул тухайн зүйлд хамаарах тайлбарыг заалттай нь нэгтгэвэл ойлгомжтой болно" гэх, хуулийн 4.2 дугаар зүйлийн тайлбарын "улсын байцаагч" гэдгийг "эрх бүхий этгээд" гэж өөрчлөх саналуудыг тус тус гаргасан байна²².

Эцэст нь 2015 оны Эрүүгийн хуулийн ёсчлох хувьд "хууль сахиулагч" гэдгийг тодорхойлсон тайлбарыг 4.1 дүгээр зүйлээс хасаж 4.2 дугаар зүйлд "хууль сахиулагч" гэдэгт цагдаа, тагнуул, тахар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгохоор²³ зохицуулсан.

2017 оны 5 дугаар сарын 11-ний Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тухайн "хууль сахиулагч" гэдгийг тайлбарласан тайлбарт нэмэлт, өөрчлөлт орж 5 дугаар зүйлд зааснаар 4.2 дугаар зүйлийн тайлбарын "тахар," гэснийг хасахаар хуульчилсан.

Хууль сахиулах ажиллагаа, хууль сахиулагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох хүрээнд 2013 онд Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, үүнээс гурван жилийн дараа Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулсан.

Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төслийг 2016 онд боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөлд хууль сахиулагч, хууль сахиулах ажиллагааны хүрээг тодорхойлсон. Уг хуулийн төслийг боловсруулахад Хууль зүйн яам, холбогдох байгууллага, судлаачдаас энэ чиглэлээр сүүлийн 10 жилд хийсэн 20 орчим судалгаа, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, НҮБ-аас боловсруулсан Эрүүгийн процессын загвар хууль болон хэрэг хянан шийдвэрлэх процессын ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлээр тэргүүлэх туршлага бүхий Канад, Австрали, БНСУ, Япон зэрэг улсын хууль, НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Зөвлөмжийг тус тус ашиглажээ.²⁴

Тухайлбал, тус хуулийн төслийн үзэл баримтлалд "Монгол Улсад хууль сахиулах чиг үүргийг цагдаа, гааль, татвар, мэргэжлийн хяналтын зэрэг олон салбарын байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны үндэслэл, журмыг Эрүүгийн байцаан шийтгэх, Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Шүүх шинжилгээний тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуулиуд болон салбарын харилцааг зохицуулсан 10 гаруй хуулиар тогтоож байна. Эдгээр хуулиудад зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг ялгаатай байдлаар зааглан тодорхойлноос зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд цагдаа, гааль, татварын байгууллагаас гадна 40 орчим чиглэлд улсын байцаагчийн эрх бүхий субъект оролцож байна. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан "Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэснийг ноцтой зөрчиж хүний эрх, эрх чөлөөг дордуулахад хүргээд байгаа юм. Иймд Шүүх эрх мэдлийн болон Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн хууль сахиулах үйл ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, арга хэрэгсэл, журмын дагуу хэрэгжүүлэх, хүний эрхийг гагцхүү шүүхийн шийдвэрээр хязгаарлах зохицуулалтыг хуульчлан тогтоох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Түүнчлэн зөвхөн гэмт хэрэг, зөрчлийг шалган тогтоохоос гадна нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хуулийн зохицуулалтад багтаах, улмаар түүнтэй холбоотой тусгай хэрэгсэл, хүч хэрэглэх асуудлыг нэгтгэн журамлаж

¹⁹ Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/. Боть IV, 180 дахь тал.

²⁰ Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/. Боть V, 3 дахь тал.

²¹ Мөн тэнд, 104 дэх тал.

²² Мөн тэнд, 212 дахь тал.

²³ Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/. Боть VI, 14 дэх тал.

²⁴ 2013 оны "Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль"-ийн танилцуулга.

бие даасан Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах шаардлага тулгарсан” хэмээн хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлжээ. Мөн уг хуулийн төслийн хамрах хүрээ, зохицуулах харилцаанд хууль сахиулах ажиллагааны зорилгыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжоор тогтоосон журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлт (цаашид мөрдөн шалгах гэх)-ийн ажиллагаа явуулахад хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах явдал гэж үзээд тус хуулийн зорилго нь хуулиар зөрчил, гэмт хэргийг мөрдөн шалгах, шинжлэн магадлах, зөрчил хянан шийдвэрлэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, албадлага хэрэглэх эрх зүйн үндэс бүрдүүлэх явдал гэж үзсэн. Үүний зэрэгцээ олон улсын хүний эрхийн стандартыг тус хуульд тусгахыг зорьсон. Мөн хууль сахиулах ажиллагааны зорилго, хүрээг тодорхойлж, хууль сахиулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн эрх хэмжээг зааглан тогтоохын зэрэгцээ оролцогчдыг мэдээллээр хангах, эрхээ шаардах, эдлэх баталгааг хуульчилсан²⁵.

Хуулийн төсөл нийт 6 бүлэг, 6 зүйлээс бүтсэн байна. Тус хуулийн төсөлд “Хууль сахиулах ажиллагаа гэдгийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, зөрчил шалган шийдвэрлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор явуулах Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд заасан ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлжээ. Энэ хүрээнд хууль сахиулах нийтлэг үйл ажиллагаа, нийтийн хэв журмыг сахиулах үйл ажиллагаа, хууль сахиулах тусгай ажиллагаа гэсэн 3 үндсэн ажиллагаа байхаар ангилсан байна.

Хүснэгт 15. Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд тодорхойлсон хууль сахиулах ажиллагааны төрлүүд

Хууль сахиулах нийтлэг үйл ажиллагаа	Шаардлага тавих, бичиг баримт шалгах, хуулийн этгээдийн баримт бичиг шалгах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, согтуурсан, мансуурсан байдлыг шалгах, жолооч согтуурсан, мансуурсан байдалтай байгаа үед авах арга хэмжээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, түр саатуулах, тээврийн хэрэгслийг шилжүүлэн байршуулах журам, согтуурсан, мансуурсан байдалтай хүнд авах арга хэмжээ, орон байр, бусад газарт нэвтрэн орох, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх, түр хаах, иргэн, байгууллагаас өгсөн мэдээллийн дагуу ажиллах үйл ажиллагаанууд хамаарна.
Нийтийн хэв журмыг сахиулах үйл ажиллагаа	Гамшиг, хорио цээрийн дэглэм тогтоосон үед хэв журмыг сахиулах, жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох, хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх гэх ажиллагаанууд хамаарна.
Хууль сахиулах тусгай ажиллагаа	Эрэн сурвалжлах ажиллагаа, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, эрх бүхий байгууллага, хууль сахиулах тусгай ажиллагаа хамаарна.

Түүнчлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг тус хуулиар зохицуулахаар боловсруулсан байна. Тухайлбал, зөрчил хянан шалгах эрх бүхий албан тушаалтнууд болох консулын эрх бүхий албан тушаалтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, төрийн тусгай хамгаалалтын газрын эрх бүхий албан тушаалтан, аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга, тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан, олон нийтийн цагдаагийн ажилтан, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын эрх бүхий албан хаагч, гаалийн улсын байцаагч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах тогтоол гүйцэтгэгч, хорих байгууллагын төлөөлөгч, татварын улсын байцаагч, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний улсын байцаагч, оюуны өмчийн улсын байцаагч, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын улсын байцаагч, нийгмийн даатгалын байцаагч, гал түймрийн хяналтын улсын байцаагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч, улсын бүртгэлийн хяналтын байцаагч, архив албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, хүүхдийн эрхийн ажилтан, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, тахрын албаны эрх бүхий албан тушаалтан, статистикийн улсын байцаагч, нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч, төмөр замын тээврийн улсын байцаагч, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд газрын дарга, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч, Монголбанкны хянан шалгагч нь тус хуулийн үйлчлэлд хамаарахаар зохицуулсан.

Өмнө дурдсан Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төслийн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд нь одоогийн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт хуульчлагдсан. Мөн 2015 оны Эрүүгийн хуулийн төслийг батлах явцад “улсын байцаагч” гэдгийг “эрх бүхий этгээд” гэж өөрчилсөн нь тус эрх бүхий этгээдийг илэрхийлэхээр байна. 2017 оны Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий дараах этгээдүүдийг хуульчилсан:

1. Консулын эрх бүхий албан тушаалтан
2. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч

²⁵ 2013 оны “Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль”-ийн үзэл баримтлал.

3. Төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан
4. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга
5. Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан
6. Олон нийтийн цагдаа
7. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч
8. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
9. Ахлах шийдвэр гүйцэтгэгч
10. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
11. Гаалийн улсын байцаагч
12. Татварын улсын байцаагч
13. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч
14. Оюуны өмчийн улсын байцаагч
15. Нийгмийн даатгалын улсын байцаагч
16. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын улсын байцаагч
17. Гал түймрийн хяналтын улсын байцаагч
18. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч
19. Монголбанкны хянан шалгагч
20. Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
21. Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын байцаагч
22. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
23. Статистикийн улсын байцаагч
24. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч
25. Төмөр замын тээврийн улсын байцаагч
26. Хүүхдийн эрхийн улсын байцаагч
27. Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
28. Хадгаламжийн даатгалын корпорацын хянан шалгагч
29. Хорих ангийн эрх бүхий албан тушаалтан
30. Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан
31. Санхүүгийн мэдээллийн улсын байцаагч
32. Шүүхийн сахилгын хорооны гишүүн

Монгол Улсын эрх зүйн эх сурвалжуудад хууль сахиулагч гэдгийг дээрх байдлаар тус тусын хуулиудад зохицуулж иржээ. Гадаад улсуудад мөн хууль сахиулагчийг Эрүүгийн хуулиар өөр өөрөөр тодорхойлсон байна.

Хүснэгт 16. Гадаадын улс орнуудын эрх зүйн зохицуулалтад “хууль сахиулагч”-ийг тодорхойлсон байдал

Улс орнууд	Хууль сахиулагчийг тодорхойлсон байдал
Оросын Холбооны Улс	Нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль сахиулах байгууллагын ажилтан, цэргийн алба хаагч, гал сөнөөгч, онцгой байдлын ажилтан
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Төрийн байгууллагын ажилтан
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Хууль сахиулах албан тушаалтан, түүнтэй ижил албан тушаалтан
Бүгд Найрамдах Киргиз Улс	Хууль сахиулах байгууллагын алба хаагч, цэргийн алба хаагч, Засгийн төлөөлөгч (хууль сахиулах болон төрийн хяналт, шалгалт хэрэгжүүлдэг)
Бүгд Найрамдах Молдова Улс	Цагдаагийн байгууллага болон дотоодыг хамгаалах байгууллагын ажилтан
Данийн Хаант Улс	Төрийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй этгээд
Бүгд Найрамдах Солонгос Улс	Төрийн байгууллагын ажилтан
Япон Улс	Төрийн албан тушаалтан
Тайландын Хаант Улс	Албан тушаалтан

Хүснэгт 16-гийн үргэлжлэл

АНУ-ын Вашингтон муж улс	Хууль сахиулах ажилтан (ерөнхий эрх мэдэлтэй, хязгаарлагдмал эрх мэдэлтэй дэг журмын цагдаа), Вашингтоны тусгай комиссын дэг журмын цагдаа, холбооны дэг журмын цагдаа болон гал түймэр, барилга, бүсчлэл, эрүүл мэнд, аюулгүй байдлын дүрэм сахиулагч бусад цагдаа)
Бүгд Найрамдах Эстони Улс	Засгийн төлөөлөгч

Түүнчлэн хууль сахиулах үйл ажиллагааг гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалтаар зохицуулжээ.

Бүгд Найрамдах Эстони Улс 2011 онд “Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль” баталж, хууль сахиулах үйл ажиллагааг зохицуулсан. Тус хуулийн зорилго нь нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа (цаашид хууль сахиулах үйл ажиллагаа гэх)-ны ерөнхий зарчим, үндэс, зохион байгуулалтыг зохицуулахад оршино. Хууль сахиулах ажиллагаа, төрийн хяналт, нийтийн хэв журам, хууль сахиулах байгууллага, хууль сахиулах байгууллагын чиг үүрэг зэргийг тус хуулиар нарийвчлан зохицуулсан. Хууль сахиулах ажиллагаа гэдэг нь нийтийн дэг журамд учрах аюул (цаашид аюул занал гэх)-аас урьдчилан сэргийлэх, аюул заналхийлсэн гэж үзэж байгаа тохиолдолд аюул заналыг тогтоох, аюул заналыг эсэргүүцэх, нийтийн дэг журам зөрчсөн байдлыг арилгах (цаашид бууруулах гэх) гэсэн утгатай. Хууль сахиулах нь нийтийн хэв журам сахиулах үүрэгтэй этгээдэд хамаарах чиг үүрэг бөгөөд хууль сахиулах ажлыг хууль сахиулах эрх бүхий байгууллага хариуцна. Төрийн хяналт гэдэг нь аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, аюулыг олж тогтоох, түүнтэй тэмцэх, үймээн самууныг арилгах зорилготой хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа юм. Нийтийн дэг журам гэдэг нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хууль ёсны эрх, хүний субъектив эрхийг хамгаалах баталгаатай нийгмийн төлөв байдал юм. Хууль сахиулах байгууллага гэдэг нь төрийн хяналт шалгалтын чиг үүргийг гүйцэтгэх, хууль, журмаар эрх олгогдсон эрх бүхий байгууллага, эрх мэдэлтэн байна.²⁶ БНЭУ-ын хууль сахиулах байгууллага цагдаагийн байгууллага болон хилийн хамгаалалтын алба гэсэн хоёр хэсэгт хуваагдана. 2010 онд цагдаагийн алба, цагдаагийн ерөнхий газар, нийтийн дэг журмын цагдаа, хилийн хамгаалалтын алба, гадаадын иргэн, харьяатын алба гэсэн байгууллагуудыг нэгтгэж дээрх хоёр байгууллага бий болжээ.²⁷

Америкийн Нэгдсэн Улсын шүүхийн товчооны тодорхойлсноор хууль сахиулах үйл ажиллагаа гэдгийг хууль сахиулах, нийтийн дэг журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй агентлаг, ажилтан байхаар тодорхойлдог. Хууль сахиулах байгууллагын үндсэн үүрэг бол эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийг мөрдөн байцаах, шаардлагатай тохиолдолд баривчлах, цагдан хорих явдал юм. Зарим хууль сахиулах байгууллагууд, ялангуяа шерифийн алба нь эрүүгийн гэмт хэрэгт буруутгагдсан хүмүүсийг шаардлагатай тохиолдолд цагдан хориход чухал үүрэг гүйцэтгэдэг.²⁸

Цагдаагийн алба хаагчид хууль сахиулах, нийтийн дэг журам, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчлэх, мэдээлэл цуглуулах гэсэн дөрвөн чиг үүрэг хамаарна гэж орон нутгийн цагдаагийн алба хаагчтай холбон тайлбарласан ойлголт байдаг.²⁹ Ерөнхийдөө АНУ-ын хууль сахиулах байгууллагад Төрийн департамент (DOS), Сангийн яамны байгууллагууд, Батлан хамгаалах яам (DOD), Армийн департамент, Тэнгисийн цэргийн департамент, Агаарын департамент, Үндэсний аюулгүй байдлын газар, Хууль зүйн яам (DOJ), Дотоод хэргийн яам (USDI), Хөдөө аж ахуйн яам (USDA), Худалдааны яам (DOC), Эрүүл мэнд, хүний үйлчилгээний газар (HHS), Боловсролын яам (ED), Ахмад дайчдын хэргийн яам (VA), Дотоодын аюулгүй байдлын яам (DHS), Тээврийн яам (DOT)-ны холбогдох байгууллага болон Холбооны бусад хууль сахиулах байгууллага хамаарч байна (Хууль сахиулах байгууллагуудын дэлгэрэнгүй бүтцийг Хавсралт 2-оос харна уу).

Мөн судлаач, хууль зүйн доктор, профессор Д.Зүмбэрэлхам өөрийн бүтээлд Монгол Улсын хууль сахиулагч болон хууль сахиулах үйл ажиллагааны талаар байр сууриа илэрхийлсэн байна. Тэрээр “Нийгэмд шударга ёс тогтоох эрх ашгийн үүднээс нийгмийн гишүүдийн эрх чөлөө, тэгш байдлыг бодитой хангах ба эдгээрийг хуулиар баталгаажуулснаа бүх нийтээр дээдлэн биелүүлэх үүргийг Үндсэн хуулиар төр, иргэн аль аль нь хүлээсэн явдал хууль сахиулах эрх зүйн үндсэн эх сурвалж юм. Үндсэн хуулийн тухайн бүлгийн арван нэгдүгээр зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заасны “үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн дэг журмыг хангах үүргийг төр хүлээх” ойлголт бол чухамдаа хууль сахиулах чиг үүрэгтэй шууд хамааралтай. Хэдийгээр “хууль сахиулах” гэсэн нэр томъёо Үндсэн хуульд байхгүй боловч энэ ойлголтод багтах үүргийг төр дангаараа хүлээнэ гэдгийг дээрх заалтаар, салаа утгагүйгээр илэрхийлсэн байна. Мөн хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүрэг бол бас л хууль сахиулах чиг үүрэгтэй хамааралтай бөгөөд Үндсэн хуулийн өмнөх бүлгийн агуулгыг энэ бүлэгт улам дэлгэрүүлэн тодорхойлжээ. Одоогоор манай улсын аль ч хууль тогтоомжоор “хууль сахиулах” гэдэг ойлголтыг тодорхойлоогүй, түүнийг үйл ажиллагааны ямар хүрээнд болон байгууллагуудын ямар бүтцийн хэмжээнд авч үзэх талаар нэгдсэн санал, дүгнэлтэд харахан хүрээгүй байна. АНУ-ын хувьд тухайн улсад хууль сахиулах тогтолцоо бие даасан тусдаа байгууллагуудаас бүрдэх бөгөөд тус тусын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа хууль сахиулах

²⁶ Law enforcement act of Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/504012016003/consolide>

²⁷ Law enforcement in Estonia, <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/ESTONIA>

²⁸ Bureau of justice statistics. Law enforcement, <https://bjs.ojp.gov/topics/law-enforcement>

²⁹ Robert M.Bohm, Keith N. Haley. Criminal Justice (Fourth edition). p.162.

зорилгын үүднээс уялдуулан гүйцэтгэдэг. Мөн хууль сахиулах үйл ажиллагааг ихэнхдээ хуулийг албадан биелүүлүүлэх үйл ажиллагаагаар илрэх хүрээнд авч үзсэн байдал ажиглагдсан. Тэр ч байтугай цагдаагийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны нэг хэсэг нь хууль сахиулах, нөгөө хэсэг нь түүний шинжид багтахаргүй байна. Ингэж ялгамжтай авч үзэх нь төрийн хууль сахиулах хатуу хандлагыг түүнээс өөр ямар нийтлэг үйл ажиллагаагаар зөөлөн хүргэх вэ гэдэг зөв харьцаанд анхаарал хандуулах орчин үеийн олон улсын нийтлэг хандлагатай холбоотой. ОХУ-ын хууль сахиулах чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, профессор В.П.Божьев нарын сүүлийн үеийн бүтээлээс үзвэл тухайн улсад “хууль сахиулах” гэсэн ойлголтыг хуульчлаагүй, энэ нэр томъёонд ямар үйл ажиллагааг хамааруулах, аль байгууллагуудыг багтаах талаар нэгдмэл ойлголтод хүрээгүй хэвээр байгаа. Харин ихэнх судлаачид, эрдэмтэд хууль сахиулах байгууллагын хүрээг тогтоохдоо хууль сахиулах үйл ажиллагаа явуулж байгаа эсэх гэсэн шалгуураар дамжин тодорхойлдог аргачлал тогтсон гэж үзэж болохоор харагдаж байна. Тэгэхээр нэгдсэн ойлголтод хүрэх гол түлхүүр асуудал нь хууль сахиулах үйл ажиллагаа гэдгээ ямар хүрээнд, хэрхэн тодорхойлохтой холбоотой гэсэн үг. Тэднийхээр бол хууль сахиулах үйл ажиллагааны үндсэн зорилт нь “иргэд, хуулийн этгээд, төрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сахин хамгаалах, тэдний зүгээс өөрсдийнхөө энэ талаар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөлийг хангах явдал” гэж үзэж байна. Дээрх тойм судалгаанаас, мөн бусад эх сурвалжуудаас харахад хууль сахиулах байгууллагуудыг нэг бүтцэд “хайрцагласан”, нэгдсэн эрх зүйн зохицуулалтаар тэдгээрийн үйл ажиллагааг журамласан тохиолдол олон улсын туршлага талаасаа ховор бололтой байна. Энэ нь угаасаа ингэх боломжгүй, эсхүл ингэж зохицуулан зохион байгуулах нийгмийн хэрэгцээ, шаардлага байдаггүйтэй холбоотой байж мэдэх юм. Иймд үүнийг цаашдын судалгаа, үйл ажиллагаандаа тооцож үзэж лавшруулан тодруулахад анхаарахыг санал болгож байна³⁰ гэжээ.

Хууль сахиулагч болон хууль сахиулах үйл ажиллагааны талаар тодорхойлсон гадаад, дотоодын дээрх эх сурвалжуудыг нэгтгэн дүгнэвэл 2015 оны Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарт “цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг хууль сахиулагч” гэж тодорхойлсон тодорхойлолтыг өөрчлөхөөсөө илүү үүнийг хэрхэн ойлгохыг оновчтой тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн тус зохицуулалт нь бусад улсын Эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулбал нарийвчилж зохицуулсан, зорилгодоо зарим талаар нийцсэн тайлбар юм. Гэхдээ зарим нэмэлт, өөрчлөлтийг тус аутентик тайлбарт хийх нь зүйтэй.

1. Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагч гэж тодорхойлсон нь зөв хэдий ч үүнийг зөвхөн чиг үүрэгтэй нь холбож хууль сахиулагч гэж үзэх нь зүйтэй. Чиг үүргийн тухайд өмнө хэсэгт дурдсан хууль сахиулах үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэгч байвал тохирно. Хууль сахиулах чиг үүрэг буюу үйл ажиллагааны талаар тодорхойлсон гадаад, дотоодын эх сурвалжуудыг авч үзвэл хууль сахиулах үйл ажиллагааг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, зөрчил шалган шийдвэрлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах буюу боловсрол, эрүүл мэнд, худалдаа, үйлчилгээ гэх мэт салбарт төрийн хяналтыг хэрэгжүүлэх гэж ерөнхий байдлаар тодорхойлж болохоор байна. Тийм учраас хууль сахиулагч гэдгийн тодорхойлолт нь үүнд нийцсэн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагч гэх алба хаагчид нь дээрх чиг үүргийг буюу хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байх ёстой. Тухайлбал, цагдаа, тагнуулын, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчийн хувьд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, зөрчил шалган шийдвэрлэх, төрийн тусгай албан хаагчийн хувьд аюулгүй байдлыг хангах, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийн хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах буюу боловсрол, эрүүл мэнд, худалдаа, үйлчилгээ гэх мэт салбарт төрийн хяналтыг хэрэгжүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх чиг үүрэг хэрэгжүүлж байвал түүнийг хууль сахиулагч гэж үзэж болох юм. Хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагч гэдэгт дээрх үйл ажиллагаатай нь нийцүүлэн тодорхойлбол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан 32 төрлийн алба хаагчийг ойлгох нь зүйтэй. Энэ нь 2013 оны Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл болон 2015 оны Эрүүгийн хуулийг батлах үеийн уг нэр томъёог ойлгож байсан ойлголттой нийцэж байна.
2. Мөн дээрх ойлголтын зөрүүг тодорхойлохоос гадна хууль сахиулагч гэдэгт өмнө дурдсан хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч бусад албан тушаалтныг нэмж хуульчлах нь зүйтэй. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуульд хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй цэргийн алба хаагч, гал сөнөөгч, онцгой байдлын алба хаагчдыг хууль сахиулагч гэж үздэг. Тиймээс энэ мэтчилэн хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх албан хаагчийг нэмж хуульчлах нь зүйтэй.

³⁰ Д. Зүмбэрэлхам. “Монгол Улсын хууль сахиулах тогтолцоо, үйл ажиллагаа, чиг хандлага”. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хууль сахиулахын их сургууль, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, “Хууль сахиулах үйл ажиллагаа: Онол, практикийн тулгамдсан асуудал (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал) эмхэтгэл”, 5-12 дахь тал.

Ингэснээр хууль сахиулагч гэх тодорхойлолтод хамаарагдах алба хаагчдын эрх ашгийг өргөн хэмжээнд хамгаалах боломж үүснэ. Эсвэл хууль сахиулагч гэх тодорхойлолтыг Солонгос, Япон, Эстони зэрэг улсад зохицуулсан шиг ерөнхий байдлаар зохицуулж хууль сахиулагчийн эрх ашгийг хамгаалах боломжтой.

Практикт хууль сахиулагч, хууль сахиулах үйл ажиллагааг тодорхойлж буй байдал

Өмнөх хэсэгт Эрүүгийн хуульд хууль сахиулагчийг хэрхэн тодорхойлсон болохыг авч үзсэн. Энэ хэсэгт уг тодорхойлолтод хамаарах хууль сахиулагчдын эрх ашиг Эрүүгийн хуулиар хэрхэн хамгаалагдаж байгааг шүүхийн болон цагдаагийн байгууллагын практикт үндэслэн судаллаа.

Тус судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийн 1, 2.1, 2.2 буюу энгийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Үүний тулд 2017-2021 оны хооронд шийдвэрлэгдсэн хэргээс 23.1 дүгээр зүйлийн 1-д хамаарах 100, 23.1 дүгээр зүйлийн 2.1-д хамаарах 18, 23.1 дүгээр зүйлийн 2.2-т хамаарах шүүхийн 22 шийдвэрийг тус тус сонгосон. Шүүхийн шийдвэрт туссан хохирогчдыг албан тушаалаар нь дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 17. Шүүхийн шийдвэрт тодорхойлогдсон хууль сахиулагчдын төрлүүд

Хохирогч болсон хууль сахиулагч		Тоо
Цагдаагийн алба хаагч	Дүүргийн хэлтсийн цагдаа	1
	Хорооны цагдаа	1
	Сумын хэсгийн төлөөлөгч	39
	Эргүүлийн цагдаа	45
	Замын цагдаа	25
	Хэв журмын цагдаа	3
	Хэсгийн байцаагч	1
	Эрүүлжүүлэх болон албадан саатуулах байрны цагдаа	3
	Хүний нөөцийн мэргэжилтэн	1
	Жижүүр эмч	1
	Мөрдөгч	7
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагч	1	
Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1	
Олон нийтийн цагдаа	1	
Хилийн цэргийн алба хаагч	2	
Тодорхойгүй	8	
Нийт	140	

Хүснэгтээс харвал Эрүүгийн хуульд туссан хууль сахиулагчдаас ихэнх нь цагдаагийн алба хаагч болох нь харагдаж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн "хууль сахиулагч" хэмээх тодорхойлолтыг буруу ойлгосон, явцуу хэрэглэдгээс үүдэлтэй хэмээн судлаачийн хувьд үзэж байна. Судалгааны хүрээнд 2017-2021 оны хооронд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчийг төрлөөр нь тодорхойлсон.

Хүснэгт 18. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шүүхийн тоон мэдээнд тодорхойлсон хууль сахиулагчдын төрлүүд

Хохирогч болсон хууль сахиулагч	Тоо
Цагдаагийн алба хаагч	462
Тагнуулын алба хаагч	-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч	6
Хилийн цэрэг	3
Байгаль хамгаалагч	2
Бусад	3
Нийт	476

Энэ үзүүлэлт ч мөн ялгаагүй шүүхийн практиктай ижил дүр зурагтай байгаа нь хууль сахиулах чиг үүрэг гүйцэтгэж байгаа бусад хууль сахиулагчдын хууль сахиулах явцад нь тулгарч байгаа гэмт хэргийн шинжтэй үйлдлийг Эрүүгийн хуулиар хамгаалахгүй байна гэж үзэхэд хүргэж байна. Тиймээс Эрүүгийн хууль дахь "хууль сахиулагч" гэх тодорхойлолтыг нэг мөр ойлгож, ойлголтыг олон нийтэд сурталчилж, нэмэлт, өөрчлөлт оруулан хуульчилж хүрээг нь өргөжүүлснээр нийгэмд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй хууль сахиулагчдын эрх ашиг хамгаалагдах боломж бий болно.

Шигтгээ 1.

Авто эргүүлд 2016-2021 он хүртэл үүрэг гүйцэтгэхдээ дуудлага, мэдээллийн дагуу очиж, ихэвчлэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн иргэний бусдыг хэл амаар доромжлох, зодох гэх мэт үйлдлийг таслан зогсоох үеэр биеийн хүч болон хэл амаар доромжилж эсэргүүцдэг. Ихэвчлэн хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, хэв журмын байцаагч, жижүүрийн офицер, эрүүлжүүлэх байрны офицер (эмч), замын цагдаагийн офицер, замын цагдаагийн зохицуулагч, эргүүлийн цагдаа, эрүүлжүүлэх, баривчлах байрны цагдаа, хорооны цагдаа нар нь энэхүү үйлдлийн хохирогч болдог. Ерөнхийдөө тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хил хамгаалах албыг хууль сахиулах байгууллага гэдэгт хамааруулан үзэх нь зүйтэй.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын шөнийн эргүүлийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Лхагвасүрэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Эндээс дүгнэвэл 2015 оны Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарын цагдаа, тагнуулын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг хууль сахиулагч гэж тодорхойлсон тодорхойлолт нь зарим талаар оновчтой хэдий ч үүнийг хэрхэн ойлгох талаар нэгдмэл ойлголтод хүрэх нь зүйтэй. Учир нь хэт өргөн хүрээнд тодорхойгүй байдлаар томьёолсон байна. Тиймээс үүнийг нийтлэг байдлаар тодорхойлж "хууль сахиулагч" гэх нэр томьёонд хамаарах алба хаагчийг нэг мөр ойлгохдоо хууль сахиулагч болон хууль сахиулах ажиллагааны нийтлэг тодорхойлолтод үндэслэх нь зүйтэй.

Үүнээс гадна Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд заасан хууль сахиулагчийн тодорхойлолт, энэ тухай ойлголтод хамаарах алба хаагчдын эрх ашгийг бүрэн хамгаалахгүй байгаа шүүх, прокурорын практик байна. Хууль сахиулагч гэх тодорхойлолтыг нэг мөр ойлгож, ойлголтыг олон нийтэд сурталчлан, нэмэлт, өөрчлөлт оруулж хуульчилснаар тус практикийг өөрчлөх боломжтой.

ii. Хууль сахиулагчийн ойр дотны хүнийг Эрүүгийн хуулиар хамгаалах асуудал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1-д "Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан..." гэж зохицуулснаар зөвхөн хууль сахиулагчийг зохицуулалтад хамааруулан эрх ашгийг нь хамгаалсан байна. Гэтэл гадаадын зарим улсад хууль сахиулагчийн ойр дотны хүнийг тус зохицуулалтад хамааруулдаг. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 317 дугаар зүйлд "Нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль ёсны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь саад учруулах, эсхүл энэ үйл ажиллагааных нь төлөө өшөө авах зорилгоор хууль сахиулах байгууллагын ажилтан, цэргийн алба хаагч, түүнчлэн тэдний төрөл садны хүний амь насыг хохироосон бол³¹" гэж хуульчилж төрөл садны хүнийг, Киргиз улсын Эрүүгийн хуулийн 340, 341 дүгээр зүйлд "Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн амь насанд халдах гэмт хэргийн тухайд өшөө авах, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хамгаалах хууль ёсны үйл ажиллагаанд саад хийх зорилгоор хууль сахиулах байгууллагын алба хаагч, цэргийн алба хаагч болон түүний ойр дотны хүнд халдсан бол" гэж хуульчилж ойр дотны хүнийг нь тус тус хамгаалтад оруулан зохицуулж хууль сахиулагчийг эсэргүүцэхтэй адилтгаж ойлгодог байна. Үүнээс үзэхэд хууль сахиулагчийн ойр дотны, төрөл садны хүнийг хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогчид тооцох практик зарим улс оронд байна.

Мөн 2021 онд ХЗҮХ-гээс Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох талаар санал авах явцад цагдаагийн алба хаагчдаас хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал өгсөн байна. Тухайлбал, хөдөө сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын гэр бүлд заналхийлэх, дарамтлах асуудал цөөнгүй гардаг тул "Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан өөрийг нь болон тэдний гэр бүлийн гишүүдэд..." гэж нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн уг зохицуулалтын санкцыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн санал тус тус ирүүлжээ.

Судалгааны хүрээнд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт хамаарах шүүхийн 140 шийдвэрт шинжилгээ хийхэд 3 шийдвэрийн хувьд хууль сахиулагчийн ойр дотны хүн болон хууль сахиулагчийг эсэргүүцэх замаар үйлдсэн болох нь тогтоогджээ.

³¹ Орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль. УБ., 2021, 250 дахь тал.

Дээрхээс дүгнэхэд манай улсын хувьд ч хууль сахиулагчийн ойр дотны хүн тухайн гэмт хэргийн хохирогч болж байгаа тул энэ асуудлыг мөн анхааран үзэж, зохицуулах нь зүйтэй. “Ойр дотны хүн” гэх ойлголт Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн аутентик тайлбарт байх тул үүнийг шууд авч хэрэглэх боломжтой.

Шигтгээ 2.

Хууль сахиулагчийн эрх ашгийг хамгаалахад хууль эрх зүйн бодлого дутмаг, хуулийг чангатгах, бусад орны туршлагаас судалж нэвтрүүлэх, хууль сахиулагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг тусгаж өгдөггүй. Хуулийн хүрээнд хууль сахиулагчийн ойр дотны хүмүүсийн аюулгүй байдлыг хангах нь маш чухал асуудал юм.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын шөнийн эргүүлийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Лхагвасүрэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс

iii. Хууль сахиулагчийн тавьсан шаардлагыг Эрүүгийн хуульд харгалзан үзэх эсэх тухай асуудал

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 3-т “Албан хаагчийн үйл ажиллагаа хууль бус байгаа тохиолдолд энэ зүйлд зааснаар ял шийтгэл оногдуулахгүй. Гэмт хэрэгтэн албан хаагчийн үйл ажиллагааг хууль ёсны бус хэмээн андуурсан бөгөөд тэрээр энэхүү андуурлаас зайлсхийх боломжтой байсан бол шүүх дотоод итгэлийн хүрээнд түүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх (энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) юм уу энэ зүйлд зааснаар ял оногдуулахаас татгалзаж болно. Гэмт хэрэгтэн энэхүү андуурлаас зайлсхийх боломжгүй байсан бөгөөд түүнд мэдэгдэж байсан нөхцөл байдлын хүрээнд тэрээр албан хаагчийн хууль бус үйл ажиллагаанаас өөрийгөө хамгаалж өөртөө туслах боломжгүй байсан бол энэ зүйлийн дагуу ял шийтгэл оногдуулахгүй; хэрэв өөртөө туслах боломжтой байсан бол шүүх дотоод итгэлээр ялыг хөнгөрүүлэх (энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) юм уу энэ зүйлийн дагуу ял оногдуулахаас татгалзаж болно”³² гэж хууль сахиулагчийн шаардлагыг хууль бус байсан, хууль бус гэж андуурсан, хууль бус шаардлагаас өөртөө туслах боломжтой байсан нөхцөлд тус гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулсан. Тус зохицуулалт нь хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь зөвхөн хууль сахиулагчийн эрх ашгийг хамгаалаад зогсохгүй шаардлагад хамаарах этгээдийн эрхийг давхар хамгаалдаг болохыг илтгэсэн зохицуулалт юм. Монгол Улсын хувьд дээрх зохицуулалт болон төстэй зохицуулалт хуульчлагдаагүй.

Мөн дээрхээс гадна АНУ-ын Жоржиа муж улсын хуульд дээрхтэй адил зохицуулалтыг хуульчилсан байна. Жоржиа мужийн хуулиар хууль сахиулагч үүргээ хууль ёсны дагуу биелүүлээгүй тохиолдолд саад учруулахыг зөвшөөрдөг байна. Өөрөөр хэлбэл, хууль бусаар баривчлагдсан үед эсэргүүцэж саад учруулсан бол Жоржиа мужийн хууль тогтоомжоор тухайн хүнийг гэмт хэрэг хийсэн гэж үзэхгүй. Тухайлбал, “Гленний хэрэг”-тэй холбоотойгоор “Бага сургуулийн орчимд сэжигтэй хүн!” гэсэн дуудлагад алба хаагчид хэрхэн хариу өгсөн тохиолдлын талаар авч үзье. Гленн сургуулийн ойролцоо алхаж байгааг олж хараад офицерууд түүнийг хууль бусаар баривчилж, харин Гленн эргүүлийн машинд эвдрэл гэмтэл учруулжээ (S19G1236, (2020)). Түүнд хууль сахиулагчийн үйл ажиллагаанд саад учруулсан, төрийн өмчид халдаж, эвдэж гэмтээсэн гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн. Шүүхээс OCGA §16-10-24-ийг зөвхөн шүүгдэгч нь хууль сахиулах ажилтанд “албан үүргээ хууль ёсны дагуу гүйцэтгэхэд нь саад учруулсан буюу эсэргүүцсэн” тохиолдолд л хэрэглэнэ гэж үзсэн. Хэдийгээр шүүх Гленнийг баривчилсан нь хууль бус гэж үзсэн ч түүнийг цагдаагийн машиныг гэмтээж, төрийн өмчид хөндлөнгөөс оролцсон гэмт хэрэг үйлдсэн гэж тэмдэглэжээ.³³

Монгол Улсын хувьд шүүхийн практикаас үзэхэд хууль сахиулагчийн дараах шаардлагыг эсэргүүцсэнийг гэмт хэрэг үйлдсэнд тооцож байна.

Хүснэгт 19. Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт холбогдох гэмт хэргийн хохирогч болсон цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан шаардлага

№	Хууль сахиулагчийн тавьсан шаардлага	Тоо
1	Албан үүргээ гүйцэтгэхтэйгээ холбогдуулан	54
2	Нийгмийн хэв журмыг зөрчиж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан үйлдлийг нь шалгах шаардлага тавьсан.	16
3	Бичиг баримтаа үзүүлэх талаар шаардлага тавьсан.	9
4	Эрүүлжүүлэх байранд хүргэх шаардлага тавьсан.	4

³² Орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль. УБ., 2021, 409 дэх тал.

³³ Have You Been Charged with Obstructing or Hindering a Law Enforcement Officer in Georgia?, <https://www.georgiacriminalattorney.com/obstruction-of-a-law-enforcement-officer>

Хүснэгт 19-ийн үргэлжлэл

5	Согтуурсан жолоочид тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх шаардлага тавьсан.	3
6	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүнд "Харьж амар" гэсэн шаардлага тавьсан.	2
7	"Цагдаагийн тасаг руу авч явна" гэсэн шаардлага тавьсан.	2
9	"Авто машиныг нь ачиж шалгана" гэсэн шаардлага тавьсан.	1
10	Жолоочид "Машинаас буу" гэсэн шаардлага тавьсан.	1
11	Бүжиг тараах шаардлага тавьсан.	1
12	"Бие засах газраа бие засаач" гэсэн шаардлага тавьсан.	1
13	"Машинаа явган хүний зам дээрээс холдуул" гэсэн шаардлага тавьсан.	1
14	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон учир машиныг нь саатуулах шаардлага тавьсан.	1
16	Албадан саатуулах байранд хүргэх шаардлага тавьсан.	1
17	"Машинаа зогсоо" гэсэн шаардлага тавьсан.	1
18	Согтуурлын зэрэг шалгах шаардлага тавьсан.	1
19	"Зээлсэн мөнгөө өг" гэсэн шаардлага тавьсан.	1
	Нийт	100

Хүснэгт 20. Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт холбогдох гэмт хэргийн хохирогч болсон цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан шаардлага

№	Хууль сахиулагчийн тавьсан шаардлага	Тоо
1	Албан үүргээ биелүүлэхтэйгээ холбогдуулан	7
2	Баривчлах үедээ шаардлага тавьсан.	1
3	Гэмт хэргийг таслан зогсоох, баривчлах шаардлага тавьсан.	1
4	Биеийн байцаалтыг шалгах шаардлага тавьсан.	1
5	Шүүхийн шийдвэр биелүүлэх шаардлага тавьсан.	1
6	Пост дээр хууль ёсны шаардлага тавьсан.	1
7	Гудамж талбайд бусдыг айлган сүрдүүлж байхыг таслан зогсоохыг шаардсан.	1
	Нийт	13

Хүснэгт 21. Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт холбогдох гэмт хэргийн хохирогч болсон цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан шаардлага

№	Хууль сахиулагчийн тавьсан шаардлага	Тоо
1	Албан үүргээ биелүүлэхтэйгээ холбогдуулан	9
2	Нийгмийн хэв журмыг зөрчиж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан үйлдлийг нь шалгах шаардлага тавьсан.	3
3	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож явахад нь саатуулах шаардлага тавьсан.	3
4	Бичиг баримтаа шалгуулах шаардлага тавьсан.	2
5	Хэсэг рүү очиж шалгуулах шаардлага тавьсан.	1
6	Тээврийн хэрэгслийг зогсоох шаардлага тавьсан.	1
7	"Хаалга онгойлго" гэсэн шаардлага тавьсан.	1
	Нийт	20

Цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын судалгаанд нийт 914 алба хаагч оролцсоноос 453 нь ямар шаардлагыг эсэргүүцдэг талаар хариулсан болно.

Хүснэгт 22. Цагдаагийн алба хаагчаас иргэнд тавьсан, асуулгаар тодорхойлогдсон шаардлага

№	Хууль сахиулагчийн тавьсан шаардлагын төрөл	Хувь
1	Хэрүүл маргаан, зодооноо болих	24.3%
2	Ер нь тавьсан дийлэнх шаардлага	13.9%

Хүснэгт 22-ын үргэлжлэл

3	Хэл амаар доромжлохоо болих	12.4%
4	Түр саатуулах	11.7%
5	Бичиг баримт шалгах	10.4%
6	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн этгээдэд тавьсан шаардлага	7.5%
7	Торгуулийн арга хэмжээ авах	6.6%
8	Хууль ёсоор дуудан ирүүлэх	1.5%
9	Ковидын явган эргүүлээр үүрэг гүйцэтгэх үеийн шаардлага	0.7%

Дээрх хүснэгтээс үзэхэд хууль сахиулагч (ихэнх тохиолдолд цагдаагийн алба хаагч)-ийн шаардлага нь хуульд заасан олон төрлийн шаардлага байж болохоор байна. Үүнээс зарим шаардлага (тухайлбал, "Зээлсэн мөнгөө өг" гэсэн шаардлага) нь хууль бус байгаа нь ажиглагдаж байна. Үүнээс гадна шаардлагууд нь ямар нэгэн журам, хууль зөрчсөн байх, зөрчиж болзошгүй нөхцөл байдал бий болгож байна. Тиймээс Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтад хууль сахиулагчийн шаардлага болон шаардлагад хамаарч буй этгээдийн хүлээж авах байдалтай холбоотой зохицуулалт оруулах шаардлагатай байна.

iv. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг бүлэглэж үйлдэхтэй холбоотой асуудал

Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн нь одоогийн байдлаар галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн, хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн гэх үйлдлүүдийг хамааруулсан байдалтай байна. Тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хэрхэн хуульчлах, нэмж хуульчлах шаардлагатай эсэхийг судлахын тулд хэрэгцээ, шаардлагыг нь үндэслэх нь зүйтэй. Хэрэгцээ, шаардлагын тухайд дараах онолын, харьцуулсан судалгааны, практикийн гэх үндэслэл, шаардлагаар тус гэмт хэрэгт "бүлэглэж үйлдсэн бол" гэх хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нэмж хуульчлах нь зүйтэй гэж үзлээ.

Гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг судлаач С.Жанцан нь "...гол төлөв Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасан ялыг хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл байдлууд юм. Гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох нөхцөл байдлууд ямагт гэмт хэргийн зүйлчлэлийг өөрчлөх үндэслэл болдог. Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлууд нь их, онц их хэмжээтэй хор уршиг учруулах, давтан болон бүлэглэж үйлдсэн байх явдал байдаг"³⁴ гэж тодорхойлсон. Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний хувьд хэргийн зүйлчлэлийг өөрчлөх боломжтой их, онц их хэмжээтэй хор уршиг хууль сахиулагчид учруулдаг хүндрүүлэх бүрэлдэхүүн нь "бүлэглэж үйлдсэн" байх боломжтой. Учир нь хууль сахиулагчийг нэг хүн, эсвэл олон хүн нийлж эсэргүүцэх тохиолдлын гэм хор, хор уршгийн хэмжээ өөр байх нь боломжтой.

Харьцуулсан судалгааны хувьд БНЭУ-ын Эрүүгийн хуулийн тухайн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хууль бус үйлдэл хийхийг албадах зорилгоор, бүлэглэж, давтан, зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн болон сүрдүүлсэн үйлдлийг хамааруулсан.³⁵ 2002 оноос хойш үйлчилсэн тус Эрүүгийн хуульд одоо хүртэл бүлэглэж үйлдсэн гэх үйлдлийг хуульчилж, энэхүү зохицуулалт нь нийгмийн харилцааг зохицуулж, гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлж, шударга ёсны зарчмын хэрэгжилт болж байгаа нь уг хүндрүүлэх бүрэлдэхүүн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт тохирч байгааг харуулж байна.

Шүүхийн 140 шийдвэрт дүн шинжилгээ хийхэд тус үйлдлийг бүлэглэж хийсэн 9 тохиолдол байна. Тиймээс "бүлэглэж үйлдсэн" гэх хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нэмж хуульчлах үндэслэл, шаардлагыг авч үзэх шаардлагатай.

³⁴ С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. Боть 1: Гэмт хэргийн тухай сургаал. УБ., 2009, 290 дэх тал.

³⁵ Estonian Penal code, https://www.legislationline.org/download/id/9098/file/EST_CC_as%20of%20Ma_y%202021.pdf

ГУРАВ. ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хууль сахиулагчийг эсэргүүцэх үйлдэл, хууль сахиулагчид хамаарах субъект зэргийг гадаад улсууд хэрхэн зохицуулсан болохыг эх газрын эрх зүйн тогтолцоотой бөгөөд хууль сахиулах ажиллагаагаар дэлхийд дээгүүрт ордог улсууд болох Бүгд Найрамдах Солонгос Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсыг сонгон авч судаллаа.

3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт, нөхцөл байдал

1998 оны ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 113, 114, 115 дугаар зүйлд хууль сахиулах албан тушаалтныг эсэргүүцэх, хууль сахиулах албан тушаалтанд халдах, хууль сахиулах албан тушаалтантай ижил албан тушаалтныг эсэргүүцэх, түүнд халдах гэх гэмт хэргүүдийг хуульчилж зохицуулсан. Тухайлбал:

Хууль сахиулах албан тушаалтныг эсэргүүцэх (113 дугаар зүйл)

(1) Хууль тогтоомж, шүүхийн дүгнэлт, шийдвэр, эсвэл захирамж, тушаал гүйцэтгэж байгаа албан тушаалтны, эсвэл Холбооны зэвсэгт хүчний цэргийн үйл ажиллагааг хүч хэрэглэж, эсвэл хүч хэрэглэхээр заналхийлэн эсэргүүцсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял, эсвэл торгох ял шийтгэнэ.

(2) Онц ноцтойгоор үйлдсэн тохиолдолд зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Онц ноцтой гэдэгт дараах тохиолдлуудыг ойлгоно:

1. Гэмт хэрэгтэн, эсвэл гэмт хэргийн оролцогч зэвсэг буюу аюултай хэрэгсэл биедээ авч явсан;
2. Гэмт хэрэгтэн хүч хэрэглэсний улмаас хүний амь нас хохироосон, эсвэл бусдын бие махбодод хүнд гэмтэл учруулсан, эсвэл
3. Гэмт хэргийг хэд хэдэн оролцогчтой хамтран үйлдсэн.

(3) Албан хаагчийн үйл ажиллагаа хууль бус байгаа тохиолдолд энэ зүйлд зааснаар ял шийтгэл оногдуулахгүй. Гэмт хэрэгтэн албан хаагчийн үйл ажиллагааг хууль ёсны бус хэмээн андуурсан бөгөөд тэрээр энэхүү андуурлаас зайлсхийх боломжтой байсан бол шүүх дотоод итгэлийн хүрээнд түүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх (энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) юм уу энэ зүйлд зааснаар ял оногдуулахаас татгалзаж болно. Гэмт хэрэгтэн энэхүү андуурлаас зайлсхийх боломжгүй байсан бөгөөд түүнд мэдэгдэж байсан нөхцөл байдлын хүрээнд тэрээр албан хаагчийн хууль бус үйл ажиллагаанаас өөрийгөө хамгаалж өөртөө туслах боломжгүй байсан бол энэ зүйлийн дагуу ял шийтгэл оногдуулахгүй; хэрэв өөртөө туслах боломжтой байсан бол шүүх дотоод итгэлээр ялыг хөнгөрүүлэх (энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) юм уу энэ зүйлийн дагуу ял оногдуулахаас татгалзаж болно.

Хууль сахиулах албан тушаалтанд халдах (114 дүгээр зүйл)

(1) Хууль тогтоомж, шүүхийн дүгнэлт, шийдвэр, эсвэл захирамж, тушаал гүйцэтгэж байгаа албан тушаалтан, Холбооны зэвсэгт хүчний цэргийн эсрэг халдлага үйлдсэн бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(2) Энэ хуулийн 113 дугаар зүйлийн 2 дахь хэсэг мөн хамаарна.

(3) Энэ хуулийн 113 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар албан хаагч үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд энэ хуулийн 113 дугаар зүйлийн 3 болон 4 дэх хэсэг мөн хамаарна.

Хууль сахиулах албан тушаалтантай ижил албан тушаалтныг эсэргүүцэх, түүнд халдах (115 дугаар зүйл)

(1) Төрийн албан хаагчид хамаардаггүй ч цагдаагийн алба хаагчийн эрх эдэлж үүрэг хүлээдэг этгээд, эсвэл прокурорын байгууллагын мөрдөн шалгагчдыг хамгаалахын тулд дээрх хүмүүст энэ хуулийн 113 болон 114 дүгээр зүйл мөн адил хамаарна.

(2) Хууль сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий этгээдийг хамгаалахын тулд түүний хувьд энэ хуулийн 113 болон 114 дүгээр зүйл мөн адил үйлчилнэ.

(3) Золгүй тохиолдол, олон нийтийг хамарсан аюул, эсвэл онцгой байдлын үед гал сөнөөгчид, онцгой байдлын газар, эсвэл аврах газрын ажилтанд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж тэдний үйл ажиллагаанд саад учруулсан бол энэ хуулийн 113 дугаар зүйлд зааснаар ял шийтгэнэ. Тухайн нөхцөл байдалд албан тушаалтны эсрэг халдлага үйлдсэн бол энэ хуулийн 114 дүгээр зүйлийн дагуу ял шийтгэнэ³⁶.

Дээрх зохицуулалтын хувьд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтаас илүү өргөн хүрээтэй зохицуулагдсан байна. Үүнд:

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1-д хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн байх үйлдлийг хуульчилсан байдаг бол ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хууль тогтоомж, шүүхийн дүгнэлт, шийдвэр, эсвэл захирамж, тушаал гүйцэтгэж байгаа албан тушаалтны, эсвэл Холбооны зэвсэгт хүчний цэргийн үйл ажиллагааг хүч хэрэглэж, эсвэл хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн байхыг хуульчилсан нь хууль сахиулах албан тушаалтан буюу хууль сахиулагч, түүний гүйцэтгэж буй үүргийг илүү нарийвчлан, өргөн хүрээнд зохицуулсан болох нь харагдаж байна.
- Хүндрүүлэх бүрэлдэхүүний хувьд Монгол Улсын Эрүүгийн хуулийн зохицуулалтаас өөрөөр зохицуулсан зүйл нь гэмт хэргийг хэд хэдэн оролцогчтой хамтран үйлдсэн тохиолдолд хүндрүүлэхээс гадна Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусдаа гэмт хэрэг болгон зохицуулсан Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэг, 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсгийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулан хуульчилжээ. Монгол Улсын Эрүүгийн хуульд байхгүй зохицуулалтын тухайд алба хаагчийн хууль бус үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан байна.
- Мөн ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хууль сахиулах албан тушаалтанд халдсан үйлдлийг тусдаа гэмт хэрэг болгон хуульчилсан ба энэ нь хууль сахиулах албан тушаалтныг эсэргүүцэх гэмт хэрэгтэй давхар зүйлчлэгдэх, тухайн зохицуулалтаас эшлэх зохицуулалттай байна.
- Үүнээс гадна хууль сахиулах албан тушаалтантай ижил албан тушаалтныг эсэргүүцэх, түүнд халдах үйлдлийг гэмт хэрэгт тооцож зохицуулсан нь манай зохицуулалтаас ялгаатай байна. Тус гэмт хэргийн тухайд төрийн албан хаагчид хамаардаггүй ч цагдаагийн алба хаагчийн эрх эдэлж, үүрэг хүлээдэг этгээд, эсвэл прокурорын байгууллагын мөрдөн шалгагч, хууль сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий этгээд, золгүй тохиолдол, олон нийтийг хамарсан аюул, эсвэл онцгой байдлын үед гал сөнөөгчид, онцгой байдлын газар, эсвэл аврах газрын ажилтныг эсэргүүцсэн, халдсан үйлдлийг гэмт хэрэг болгон зохицуулсан нь илүү өргөн хүрээнд зохицуулсан зохицуулалт болжээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хууль сахиулагчийг дараах байдлаар авч үзсэн. Үүнд:

- Хууль тогтоомж биелүүлж байгаа албан тушаалтан;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэж байгаа албан тушаалтан;
- Шийдвэр, эсвэл захирамж гүйцэтгэж байгаа албан тушаалтан;
- Тушаал гүйцэтгэж байгаа албан тушаалтан;
- Холбооны зэвсэгт хүчний цэрэг;
- Золгүй тохиолдол, олон нийтийг хамарсан аюул, эсвэл онцгой байдлын үед гал сөнөөгчид, онцгой байдлын газар, эсвэл аврах газрын ажилтан;
- Төрийн албан хаагчид хамаардаггүй ч цагдаагийн алба хаагчийн эрх эдэлж, үүрэг хүлээдэг этгээд гэх байдлаар тодорхойлсон байна.

Өөрөөр хэлбэл, тус хуульд хууль сахиулагчийг ангилахдаа чиг үүргийн дагуу буюу гүйцэтгэж буй үйл ажиллагааных нь агуулгаар ангилсан байна.

ХБНГУ-ын хууль сахиулах байгууллага нь Үндсэн хуулиар мужуудад л байдаг бөгөөд энэ нь тус улсын төрийн тогтолцооны нэг гол шинж чанар юм. Тиймээс Франц, Итали, АНУ, Канад болон бусад олон орноос ялгаатай нь Германд Карабинери,

³⁶ Орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль. УБ., 2021, 409 дэх тал.

Үндэсний цагдаа, Холбооны мөрдөх товчоо, эсвэл RCMP-тай харьцуулахуйц холбооны цагдаагийн алба байдаггүй. 2005 онд Германы хил нээлттэй болсон тул Европын холбоо хөгжиж, Шенгений хэлэлцээр хөрш зэргэлдээ бүх улс оронд тархсантай холбогдуулан Bundesgrenzschutz-ыг Холбооны цагдаа (германаар Bundespolizei) болгон өөрчилсөн.³⁷

ХБНГУ-ын хууль сахиулах байгууллагад ерөнхийдөө Холбооны хууль сахиулах агентлагууд, мужийн хууль сахиулах байгууллага, орон нутгийн хууль сахиулах агентлагууд, Холбооны парламент (Бундестаг), Холбооны Батлан хамгаалах яам, Холбооны Сангийн яам, Холбооны Дотоод хэргийн яам, Bundespolizei (BPOL) буюу Холбооны цагдаа, Landespolizei буюу мужийн цагдаа, Жастиз буюу үйл ажиллагааг холбох албаны холбогдох байгууллагууд хамаарахаар байна (Хууль сахиулах байгууллагын дэлгэрэнгүй бүтцийг Хавсралт 3-аас харна уу).

Харин орон нутгийн хууль сахиулах байгууллагууд нь ХБНГУ-д дараах бүтэцтэй байна:

- Хотын захирамжийг сахиулах байгууллагууд;
- Kommunaler Ordnungsdienst (KOD) буюу Хотын хууль сахиулах, муж улсын болон орон нутгийн хуулиар өөр өөр зохицуулалттай албатууд;
- Ordnungsamt (OA) буюу “Хотын захирамжийн агентлаг” (хамгийн түгээмэл нэр томьёо);
- Städtischer Ordnungsdienst буюу “Хотын захиргааны алба”.

Хотын цагдаагийн хүчин

- Polizeibehörde буюу хэд хэдэн муж дахь орон нутгийн “Цагдаагийн газар”;
- Gemeindevollzugsdienst (GVD) буюу Баден-Вюртемберг муж улс дахь “Хотын захиргааны хууль сахиулах алба”;
- Коммуналполизей, эсвэл Стадтполизей буюу Хэссен муж улсын хотууд дахь “Олон нийтийн цагдаа”, эсвэл “Хотын цагдаа”.

Тус улсын эрүүгийн хуульд хууль сахиулагчийн ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн үйлдлүүдийг тус гэмт хэрэгт хамааруулаагүй нь манай улсынхтай ижил байна.

Мөн, өмнө дурдсанаар, ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хууль сахиулагчийн тавьсан шаардлагын талаар хуульчилсан нь дэвшилттэй байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн 3-т “Гэмт хэргийг хэд хэдэн оролцогчтой хамтран үйлдсэн” гэх нөхцөлийг тусгаж, тухайн тохиолдолд тус гэмт хэргийг хүндрүүлэхээр авч үзжээ. Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Эрүүгийн хуульд байх “бүлэглэж үйлдсэн” гэх ойлголттой дүйцэх юм. Тухайлбал, 2015 оны Эрүүгийн хуулийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ” гэж тодорхойлсон бол ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт үүнийг “Гэмт хэргийг хэд хэдэн этгээд хамтран гүйцэтгэсэн бол хүн тус бүрийг гүйцэтгэгч (хамтран гүйцэтгэгч) гэж үзэж ял оногдуулна” гэж тодорхойлсон байна. ХБНГУ-ын хувьд хууль сахиулагчийг бүлэглэж эсэргүүцсэн, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлснийг нийгмийн хор аюулаар өндөрт тооцож ийнхүү хүндрүүлэх бүрэлдэхүүнд хамаатуулан зохицуулсан нь сайн туршлага болж байна.

3.2. Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт, нөхцөл байдал

Бүгд Найрамдах Солонгос Улсын 1963 оны Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 136 дугаар зүйлд “Албан тушаалын үйл ажиллагаатай нь холбогдуулан эсэргүүцсэн гэмт хэргүүд” туссан ба төрийн байгууллагын ажилтанд хуулиар хүлээсэн үүрэгтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорьж албадан хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл 10 сая хүртэл воноор торгох ял шийтгэнэ гэсэн нийтлэг хэм хэмжээтэй.

Төрийн албанд саад учруулах гэмт хэрэг (Widerstand gegen die Staatsgewalt) нь улс болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулснаар үүсдэг.³⁸ Өөрөөр хэлбэл, төрийн эрхийг хэрэгжүүлдэг төрийн албан хаагчийн биед халдах, заналхийлэхийг төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хэрэгжүүлж байгаа төрийн үйл ажиллагаанд саад учруулах үйлдэл гэж ойлгоно. Төрийн алба нь төрийн албан хаагчаар дамжин хэрэгждэг бөгөөд энэ нь төрийн албан хаагчийг хамгаалах зорилгоор эрүүгийн хуульд тусгайлан зүйл, заалт оруулж хамгаалалт хийж байгаа зүйл огт биш,³⁹ эсрэгээрээ төрийн албыг хамгаалж байгаа нэгэн хэлбэр юм.

³⁷ Law enforcement in Germany, https://themarshall.fandom.com/wiki/Law_enforcement_in_Germany

³⁸ 이재삼, 형법각론, 박영사, 2007, 731면.

³⁹ 이재영, 공무집행방해죄에 있어서 직무를 집행하는 의미, 사법연수원, 2007, 265면.

БНСУ-д төрийн албанд саад учруулах гэмт хэргийн хохирогч нь төрийн албыг гүйцэтгэхэд оролцож байгаа этгээд байх албагүй бөгөөд гуравдагч этгээд болох хэн ч байсан энэ гэмт хэргийн хохирогч болж болно.

Харин төрийн албыг гүйцэтгэгч албан хаагч гэдэгт тухайн албыг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчийг ойлгоно. Төрийн албан хаагч гэдэг нь хуулийн дагуу улс болон төрийн байгууллагын албан үүргийг гүйцэтгэж байгаа этгээдийг хэлнэ.⁴⁰

Төрийн алба хэрэгжүүлэх хүрээ гэж төрийн албан хаагч хуулийн дагуу хэрэгжүүлдэг албыг хэлэх бөгөөд “албан үүргээ хэрэгжүүлж байгаа” гэдэг нь тодорхой албан үүрэг гүйцэтгэж байгааг хэлэх бөгөөд нийтлэг албан үүрэг (Dienstpflicht) үүнд хамаарахгүй.⁴¹ “Хэрэгжүүлж байгаа” гэдэг нь төрийн албан хаагч төрийн албан үүргээ гүйцэтгэхийн тулд зайлшгүй хийх үйлдлийг бодитоор хийж байгаа үйлдэл болон тухайн үйлдлийг хийхийн тулд ажиллаж байгаа цаг үеийг тооцно.⁴²

БНСУ-ын Эрүүгийн хуульд төрийн албанд саад учруулах (136.1) талаар зүйл, заалт байдгаас гадна албан үүрэг тулгах (136.2), алба хаагчийг төөрөгдөлд оруулж төрийн албанд саад учруулах (137), шүүх болон Үндэсний ассамблей (парламент)-н танхим дахь гутаан доромжлох (138), зэвсэг хэрэглэн төрийн албанд саад учруулах (144) гэх мэт үйлдлийг төрийн албанд саад учруулсанд тооцон шийтгэдэг.

Эрүүгийн хуульд, нэгдүгээрт, төрийн албанд саад учруулсан бүхий л хэлбэрийг шийтгэх бус, төрийн албан хаагчийг заналхийлсэн, эсвэл хүч хэрэглэсэн үйлдэл болон албан тушаалаа урвуулан төрийн албанд саад учруулах гэмт хэргийг зүйлчилж, хоёрдугаарт, эвдэж сүйтгэх, хулгайлах аргаар төрийн албанд саад учруулах тохиолдолд тухайн эд зүйлсийг битүүмжлэх, хураах, гуравдугаарт, төрийн албан хаагчийн биед халдах, заналхийлсэн этгээдийг шийтгэх тохиолдолд төрийн албан хаагчийн гүйцэтгэж байсан алба, гүйцэтгэх гэж буй алба (албан үүрэг тулгах) гэж хуваан үздэг.

Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлийн 136.1 дэх хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэж буй төрийн албан хаагчийн биед халдаж, заналхийлсэн этгээдийг 5 жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл арван сая хүртэлх воноор торгоно” гэж заасан.

Энэхүү заалт нь хуулийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагчийг эсэргүүцсэн гэмт хэрэгт хамааралтай бөгөөд хууль бус үүргийн гүйцэтгэл нь энэ заалтад хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч хуулийн дагуу албан үүргээ гүйцэтгэх үүрэг хүлээх ёстой бөгөөд үүнийг Дээд шүүхээс, нэгдүгээрт, албан үүргээ гүйцэтгэж байгаа тухайн үйлдэл нь хуулийн хүрээнд байх, хоёрдугаарт, албан үүргээ гүйцэтгэх тодорхой нэгэн арга барилд тулгуурласан байна⁴³ гэж заасан.

Уг заалтад тусгасан “биед халдах” гэх ойлголтын хувьд хүний биед шууд ба шууд бус хэлбэрээр хүч хэрэглэн халдсаныг, “заналхийлэх” гэдэг нь тодорхой хэмжээний хор хөнөөл хүргэхээ илэрхийлснийг тус тус ойлгоно.⁴⁴

Төрийн албан хаагчийн биед халдах, заналхийлэх үйлдэл нь хэр хэмжээний байж эрүүгийн хуулийн хариуцлага хүлээлгэх вэ гэдэг асуудал тулгардаг. Солонгосын Дээд шүүх нь “төрийн албыг хэрэгжүүлэхэд саад учруулахуйц үйлдэл”⁴⁵ бол дээрх заалтын дагуу ял эдлүүлэх ёстой хэмээн үзсэн байдаг. Гэхдээ төрийн албан хаагч харилцагч талын эсэргүүцлийг тоомсорлоогүй, эсвэл биед нь шууд болон шууд бусаар халдаагүй тохиолдолд энэхүү заалт үйлчлэхгүй. Жишээ нь, замын цагдаа согтуугаар жолоо барьсан гэмт хэрэгтнийг илрүүлэх үүднээс шалгалт хийх явцад жолооч шалгуулахгүйгээр шууд явсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлийн 136.1 дэх хэсэг үйлчлэхгүй гэж үздэг.⁴⁶

Мөн Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “төрийн албан хаагчид түүний албыг тулган шаардах, албан ажлаас нь чөлөөлүүлэх зорилгоор биед нь халдаж, заналхийлсэн тохиолдолд 136 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэнэ” гэж заасан. “Албан үүргээс чөлөөлүүлэх зорилгоор” гэдэг нь албан үүргийн гүйцэтгэлд саад учруулах зорилгоор түүний эрхийн хэрэгжилтийн үндэс болох албан ажлаас нь чөлөөлүүлэх зорилгоор үйлдсэн үйлдлийг хэлнэ. Энэхүү заалтын зорилго нь, нэгдүгээрт, улсын үйл ажиллагааг хэвийн хангах, хоёрдугаарт, төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх, үргэлжлүүлэх эрхийн хамгаалалт болно.⁴⁷

Төрийн албанд саад учруулахтай холбоотой бас нэгэн заалт бол Эрүүгийн хуулийн 137 дугаар зүйл бөгөөд уг зүйлд “алба хаагчийг төөрөгдөлд оруулж төрийн албанд саад учруулсан этгээдэд 5 жил хүртэлх хорих ял, эсхүл 10 сая хүртэлх воноор торгоно” гэж заасан. “Төөрөгдөл” гэж тодорхой зорилгод хүрэхийн тулд харилцагч талд андуурал, ташаа ойлголт төрүүлэхийг

⁴⁰ 이재삼, 형법각론, 박영사, 2012, 740면.

⁴¹ Arzt/Weber S. 39; Horn SK.

⁴² 대법원 1999.9.12. 99도383.

⁴³ 대법원 1991.5.10. 선고 91도453 판결.

⁴⁴ 이재삼·장영민·강동범, 형법각론, 박영사, 2017, 746면.

⁴⁵ 대법원 1970. 6. 30. 70도1121, 대법원 2011. 2. 10. 2010도15986 판결.

⁴⁶ 대법원 1994. 9. 9. 94도701; 대법원 1996. 4. 26. 96도281 판결.

⁴⁷ 한정환, 형법각론, 박영사, 2018, 80면.

хэлэх⁴⁸ бөгөөд энэхүү төөрөгдлийг ашиглан төрийн албан хаагчаар хуульд заасан үүргээс нь өөр үүрэг гүйцэтгүүлэх, хууль бус шийдвэр гаргахад нь нөлөөлсөн бол дээрх заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Улсын үйл ажиллагааг хангахын тулд хуулийн дагуу ард иргэдийн эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлах, хамгаалах үүрэг бүхий байгууллагыг хууль сахиулагч байгууллагад тооцож байгаа нийтлэг хандлага байна. Үүнд цагдаа, прокурорын газар болон өргөн утгаараа шүүх байгууллага, түр саатуулах газар гэх мэт байгууллагыг хууль сахиулах байгууллага гэж ойлгож болно.

Үүнээс улсын бодлого, үүргийг хэрэгжүүлдэг хамгийн идэвхтэй байгууллага бол цагдаагийн газар буюу цагдаагийн алба хаагч юм.

Тиймээс ч цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна. Энэ хуулийн 2 дугаар зүйлд цагдаагийн гүйцэтгэх үүргийг нарийн заасан байна. Үүнд:

- ард иргэдийн тайван, аюулгүй байдлыг хангах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах;
- гэмт хэргийн хохирогчийг хамгаалах;
- өндөр албан тушаалтныг хамгаалах, террортой тэмцэх;
- нийтийн аюулгүй байдлын төлөө аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, бэлтгэх;
- авто замын хяналт;
- гадны ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах;
- нийтийн аюулгүй байдал болон нийгмийн эмх цэгцтэй байдлыг хангахтай холбоотой бусад үүрэг гэж заасан байна.

2014 оноос хойш БНСУ-ын Ерөнхий прокурорын газраас “Хууль сахиулагч төрийн албан хаагчийг эсэргүүцсэн этгээдийг журамлах тухай” журам батлан хэрэгжүүлж байна. Энэ журмын дагуу хууль сахиулагчийг эсэргүүцсэн тохиолдолд өмнө гэмт хэрэг үйлдэж байгаагүй, согтуугаар үйлдсэн, хууль сахиулагч цагдаагийн алба хаагчид хүнд гэмтэл учруулаагүй байсан ч тухайн этгээдийг баривчлахаар заасан ба сүүлийн үед гал сөнөөгч, түргэн дуудлагын алба хаагчдын биед халдах тохиолдол ихсэж буйтай холбоотойгоор 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулан, дээрх алба хаагчдын биед халдсан бол баривчлан байцаалт авч байна.

Энэ журмыг хэрэгжүүлж эхэлсэн оны 4 дүгээр сараас 9 дүгээр сар хүртэлх 6 сарын туршид төрийн албанд саад учруулсан хэргээр 1123 иргэн баривчлагдан байцаалт өгсөн нь өмнөх оныхтой харьцуулахад 2.5 хувиар өссөн бол гадуур байцаалт өгсөн иргэдийн тоо 3.5 хувиар нэмэгдсэн байна.⁴⁹

Дээр өгүүлснээс дүгнэвэл БНСУ-ын Эрүүгийн хуульд тухайн гэмт хэргийг үйлдлээр нь салгаж, олон төрлийн гэмт хэрэг болгон хуульчилсан байна. Тухайлбал, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс гадна албан үүрэг тулгах, төөрөгдүүлэх, гутаан доромжлох, саад учруулах гэх үйлдлүүдийг хамарч байна. Үүнээс гадна тухайн судалгааны шийдвэрлэх томоохон асуудал болох хууль сахиулагчид хамаарах субъектийн хувьд улсын үйл ажиллагааг хангахын тулд хуулийн дагуу ард иргэдийн эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлах, хамгаалах үүрэг бүхий байгууллагыг ойлгохоор зохицуулсан. Энэхүү байдал нь ерөнхий бөгөөд Монгол Улстай адил цагдаагийн байгууллагыг хууль сахиулагчийн гол төлөөлөл болгон авч үздэг байна. Мөн үүнээс гадна төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагааны талаар хуульчилж өгсөн ба тухайн албан тушаалтнаас гадна гуравдагч этгээдийг уг гэмт хэрэгт хамаатуулан үзсэнээрээ онцлог байна.

⁴⁸ 대법원 2003. 10.9. 선고 2000도4993 판결.

⁴⁹ 대검찰청, 공무집행방해사범 엄정 대응 방침 시행, 2015. 12. 3. 보도자료.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Судалгааны энэхүү бүлэгт хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай авч үзэх бөгөөд бүтцийн хувьд уг агуулгаар хэсгүүдэд хуваасан болно. Арга зүйн хувьд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тус гэмт хэргийн дэлгэрэнгүй тоон мэдээлэл, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн мэдээлэл, цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын асуулга болон шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийх замаар хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн үйлдэгдэж буй нөхцөл байдлыг илрүүлэн, үйлдэгдэж буй шалтгааныг түүнээс тодруулж, эцэст нь тус гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай авч үзэж тодорхой санал, зөвлөмж дэвшүүлсэн.

4.1. Гэмт хэргийн нөхцөл байдал

• Цагдаагийн байгууллагын тоон мэдээлэл

Цагдаагийн байгууллагаас хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн талаар уг гэмт хэргийн бүртгэгдсэн тоон мэдээлэл, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь, гэмт хэрэг үйлдэгдсэн гарагийн мэдээлэл, гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн мэдээлэл, гэмт хэрэг үйлдэгдсэн газрын мэдээлэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын болон нөхөн төлүүлэлтийн хэмжээний мэдээлэл, тус гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчдыг үйл ажиллагааных нь төрлөөр (цаашид төрлөөр гэх) ангилсан тоон мэдээлэл, гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчдыг төрлөөр болон орон нутгаар ангилсан тоон мэдээлэл, гэмт хэргийн хохирогчийг албан тушаалын байдлаар нь ангилсан тоон мэдээлэл, гэмт хэргийн хохирогчийн нас, хүйсийн байдлын мэдээлэл, гэмт хэрэгт холбогдогчийн боловсролын түвшний мэдээлэл, гэмт хэргийн холбогдогчийн нийгмийн байдлын мэдээлэл, гэмт хэрэгт холбогдогчийн гэмт хэрэг үйлдсэн байдлын мэдээлэл зэргийг ирүүлсэн байна.

Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн гаралтын байдлыг авч үзвэл (Хавсралт 5-ын 1 дэх хүснэгтийг харна уу) 2017 онд 46, 2018 онд 85, 2019 онд 97, 2020 онд 116, 2021 оны эхний хагаст 107 удаагийн гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн. Энэхүү тоон үзүүлэлтээс харвал тус гэмт хэргийн тоо жилээс жилд тогтмол өссөн байх бөгөөд тэр тусмаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас улс орон даяар хөл хорио тогтоосон байсан 2020, 2021 оны эхний хагас жилүүдэд ч өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Газар нутгийн байршлын хувьд авч үзвэл тухайн онуудад орон нутгийн хувьд Төв аймаг болон Дорноговь аймагт энэ гэмт хэргийн гаралт хамгийн өндөр буюу 23 байсан бол Говь-Алтай аймагт 0, Сүхбаатар аймагт 6 бүртгэгдсэн нь хамгийн бага байна. Харин нийслэлийн хувьд Баянзүрх дүүрэгт 53, Сүхбаатар дүүрэгт 39 бүртгэгдсэн нь хамгийн их, Багахангай дүүрэгт 0, Налайх дүүрэгт 5 бүртгэгдсэн нь хамгийн бага үзүүлэлт юм.

Гэмт хэрэг үйлдэгдсэн гарагуудыг авч үзвэл (Хавсралт 5-ын 2 дахь хүснэгтийг харна уу) 2017 он буюу тухайн зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хугацаанаас 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийслэлд 7 хоногийн бүх өдөр тогтмол буюу 22-33 удаагийн гэмт хэрэг бүртгэгдсэн бол орон нутагт мөн адил бүх өдөр тогтмол буюу 33-47 удаагийн гэмт хэрэг бүртгэгджээ.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн тухайд (Хавсралт 5-ын 3 дахь хүснэгтийг харна уу) 22 цагаас 06 цагийн хооронд тухайн гэмт хэрэг түлхүү үйлдэгддэг байна. 2017-2021 оны хооронд дээрх цаг хугацаанд нийт 216 хэрэг үйлдэгдсэн нь мөн хугацаанд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 47.8 хувийг эзэлж байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг авч үзвэл (Хавсралт 5-ын 4 дэх хүснэгтийг харна уу) дээрх хугацаанд гудамж, талбайд нийт 195 гэмт хэрэг бүртгэгдсэн бол үүний дараа гэр, орон сууцанд 77, төрийн байгууллагад 66 гэмт хэрэг тус тус үйлдэгджээ. Эндээс тус гэмт хэргийг ихэвчлэн гудамж, талбайд үйлддэг нь харагдаж байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс учирсан хохирлын хувьд (Хавсралт 5-ын 5 дахь хүснэгтийг харна уу) 2017 онд 19 960 000 төгрөг, 2018 онд 53 438 000 төгрөг, 2019 онд 66 394 813 төгрөг, 2020 онд 52 552 497 төгрөг, 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 14 290 000 төгрөгийн хохирол тус тус учруулжээ.

Тус гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчдыг төрлөөр ангилсан тоон мэдээллээс харвал (Хавсралт 5-ын 6 дахь хүснэгтийг харна уу) тухайн жилүүдэд цагдаагийн алба хаагч нийт 468 удаа тус гэмт хэргийн хохирогч болсон нь нийт хохирогчдын 76.3 хувь нь болж байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчдын тухайд цагдаагийн алба хаагч өндөр үзүүлэлттэй байгааг дээр дурдсан. Тэгвэл энэхүү үзүүлэлтийг орон нутгаар ангилбал (Хавсралт 5-ын 7 дахь хүснэгтийг харна уу) нийслэлд хамгийн их буюу 198, Говь-Алтай аймагт хамгийн бага буюу 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тухайн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдол Увс аймагт 2, Хэнтий аймагт 2, нийслэлд 2, хилийн цэргийн алба хаагч хохирогч болсон тохиолдол Дорноговь аймагт 3, байгаль хамгаалагч хохирогч болсон тохиолдол Төв, Хэнтий аймагт тус бүр 1, бусад албан хаагчийн хувьд 2 бүртгэгджээ. Дээрхээс дүгнэвэл зарим аймагт тус гэмт хэргийн улмаас цагдаагийн алба хаагч хохирсон тохиолдол цөөн байгааг эс тооцвол орон нутагт нийтлэг байдлаар цагдаагийн алба хаагчид тус гэмт хэргийн хохирогч болох нь их байна. Харин бусад албан хаагчийн хувьд тус гэмт хэргийн хохирогч болж буй тохиолдол орон нутагт эрс бага байна.

Гэмт хэргийн хохирогчийг албан тушаалын байдлаар нь ангилснаас үзвэл (Хавсралт 5-ын 8 дахь хүснэгтийг харна уу) эргүүлийн цагдаа хохирогч болсон нь хамгийн олон буюу 85 тохиолдол, үүний дараа замын цагдаагийн зохицуулагч 79 тохиолдлоор удаалсан бол цагдаагийн алба хаагчаас бусад алба хаагч болон олон нийтийн цагдаагийн үзүүлэлт бага байна. Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллийн хувьд хууль сахиулагчид хамаарахгүй этгээдийг оруулсан, хууль сахиулагчийн төрлийг бүхлээр нь тодорхойлоогүй зэрэг дутагдал илэрч байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчдыг насны хувьд авч үзвэл 18-54 насны тусгай албан хаагчид байна (Хавсралт 5-ын 9 дэх хүснэгтийг харна уу). Үүний дотор 25-34 насны хохирогчдын тоо дийлэнх хувийг эзэлж байх бөгөөд ихэнхдээ эрэгтэй хүн тухайн гэмт хэргийн хохирогч болдог ажээ. Эдгээр шинж нь хохирогчдын мэргэжлийн онцлогтой шууд холбоотой болох нь ойлгомжтой.

Харин хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдсэн холбогдогчдын хувьд дийлэнх нь 16-60 насны хүмүүс байна. Үүнээс ихэвчлэн холбогдогч болдог нийгмийн бүлгийг авч үзвэл 18-29 насны хүмүүс байна. Харин хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн холбогдогчдын насны бүлгүүд хоорондоо ойролцоо байна (Хавсралт 5-ын 10 дахь хүснэгтийг харна уу).

Тухайн гэмт хэрэгт холбогдогчдыг боловсролын түшингээр нь бүлэглэн авч үзвэл (Хавсралт 5-ын 11 дэх хүснэгтийг харна уу) бүрэн дунд боловсролтой хүмүүс бусад бүлгийн хүмүүсээс илүү их холбогддог болох нь харагдаж байна.

Тус хэрэгт холбогдогчийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлбол (Хавсралт 5-ын 12 дахь хүснэгтийг харна уу) ихэвчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй этгээдүүд тухайн гэмт хэргийг үйлддэг байна. Гэвч малчин, төрийн албан хаагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувийн хэвшилд ажиллагчийн үзүүлэлт ч их байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт холбогдогчийн гэмт хэрэг үйлдсэн байдлын (Хавсралт 5-ын 13 дахь хүснэгтийг харна уу) тоон мэдээллээс харвал 2017 оноос 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 76,6 хувь нь согтуугаар үйлдэгджээ. Эндээс гэмт хэрэгт холбогдогчийн гэмт хэрэг үйлдсэн байдлыг авч үзвэл ихэвчлэн согтуугаар тус гэмт хэргийг үйлддэг байна.

• Шүүхийн тоон мэдээлэл

Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн мэдээлэлд дурдсанаар 2017 оны 7 дугаар сараас 2020 он дуустал шүүхээр шийдвэрлэгдсэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт нийт 148 хүн торгох ялаар, 1 хүн нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 30 хүн хорих ялаар, 1 хүн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээгээр тус тус шийтгүүлсэн байна (Хавсралт 5-ын 14 дэх хүснэгтийг харна уу).

Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн ерөнхий мэдээлэлд дурдсанаар (Хавсралт 5-ын 15, 16 дахь хүснэгтийг харна уу) ял шийтгүүлсэн этгээдүүдийг насны ангиллаар авч үзвэл тухайн жилүүдэд 18-21 настай 8, 22-29 настай 64, 30-34 настай 37, 35 наснаас дээш 70 хүн бүртгэгдсэн нь ял шийтгүүлсэн нийт этгээдийн 39 хувь нь байна. Боловсролын түвшнээр нь авч үзвэл бакалаврын зэрэгтэй 55, тусгай мэргэжлийн дунд 13, бүрэн дунд 78, суурь боловсролтой 20, бага боловсролтой 13 хүн тус тус бүртгэгдсэн байна. Үүнээс ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл эрхэлсэн тодорхой ажилгүй хүн хамгийн олон буюу 84 байгаа бол аж ахуй нэгжийн албан тушаалтан 14, малчин 12, төрийн тусгай албан хаагч 9, төрийн үйлчилгээний албан хаагч 8 гэх үзүүлэлттэй байна.

• Холбогдох шүүхийн шийдвэр

Судалгааны хүрээнд 2017-гоос 2021 оны хооронд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлээр зүйлчлэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд анализ хийсэн. Ийнхүү анализ хийхдээ тухайн онд шийдвэрлэсэн

хэргүүдийн шүүхийн шийдвэрээс санамсаргүй байдлаар 20 шийдвэр сонгож, халдлагад өртсөн хууль сахиулагчийн төрөл, хууль сахиулагчийн тавьсан шаардлага, хууль сахиулагчийг эсэргүүцсэн байдал, ойр дотны хүнийх нь эсрэг халдлага үйлдсэн эсэх, түүний дотор халдлагыг бүлэглэж үйлдсэн эсэх, согтуугаар үйлдсэн эсэхийг шалгуур болгон авч үзсэн.

• Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчлэн шийдвэрлэсэн шийтгэх тогтоол

Сонгосон хугацаан дахь бидний авч үзэж буй 20 хэргээс 2017 онд 14 хэрэг, 2018 онд 16 хэрэг, 2019 онд 19 хэрэг, 2020 онд 16 хэрэг, 2021 онд 18 хэрэг тус тус согтуугаар үйлдэгдсэн байна. Санамсаргүй байдлаар 20 хэрэг сонгоход дээрх тооны хэрэг согтуугаар үйлдэгдсэн байгаа нь тус гэмт хэрэг дийлэнх тохиолдолд согтуугаар үйлдэгддэг болохыг харуулж байна.

Шүүхийн шийдвэрт анализ хийх болсон бидний гол зорилго бол хууль сахиулагч иргэнд ямар шаардлага тавьсны улмаас тухайн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг гарсан болохыг судлахад оршиж байв.

Хүснэгт 23. Шүүхийн шийдвэрт тодорхойлсон хууль сахиулагчийн тавьсан шаардлага /23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг/

№	Иргэнд тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлага (шүүхийн шийдвэрт дурдсанаар)	2017	2018	2019	2020	2021
1	Нийгмийн хэв журмыг зөрчиж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан үйлдлийг нь шалгах тухай шаардлага тавьсан.	3	5	1	2	6
2	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон учир машиныг саатуулах болон согтуурлын зэргийг нь хэмжих шаардлага тавьсан.	2	3	1	2	1
3	Албан үүргээ гүйцэтгэхтэйгээ холбогдуулан шаардлага тавьсан.	5	8	16	13	11
4	Албадан саатуулах байртай холбоотой шаардлага тавьсан.	1				
5	Эрүүлжүүлэх байранд хүргэх тухай шаардлага тавьсан.	3	2	1		
6	Машиныг зогсоох шаардлага тавьсан.	1			1	
7	Бичиг баримтаа шалгуулах шаардлага тавьсан.	1	2	1	1	2
8	Машиныг явган хүний зам дээрээс холдуулах шаардлага тавьсан.	1				
9	"Бие засах газраа бие засаач ээ!" гэсэн шаардлага тавьсан.	1				
10	Үйл ажиллагааг зогсоох (бүжиг тараах) шаардлага тавьсан.	1				
11	"Зээлсэн мөнгөө өг" гэсэн шаардлага тавьсан.	1				
12	Машин ачих шаардлага тавьсан.				1	

Дээр дурдагдсанаас "Албан үүргээ гүйцэтгэхтэйгээ холбогдуулан шаардлага тавьсан" гэх төрлийн шаардлага хамгийн олон давтагдаж байх ч энэ нь шүүхийн шийтгэх тогтоолд тухайн байдлаар шууд тодорхойлж, ямар нэг тайлбаргүйгээр бичигджээ.

2017 оны 93 дугаартай шийтгэх тогтоолд хохирогч эргүүлийн цагдаа нь иргэнд "Зээлсэн мөнгөө өг" гэх шаардлага тавьсан байх бөгөөд шүүх үүнийг хууль ёсны шаардлага хэмээн үзсэн байгаагаас "Хууль сахиулагчийн шаардлага зөвхөн хууль ёсны байх ёстой" гэх үндсэн шинж зарим тохиолдолд хангагддаггүй болох нь харагдаж байна.

• Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсгээр зүйлчлэн шийдвэрлэсэн шийтгэх тогтоол

Хуулийн энэхүү хэсгийн дагуу 2017-гоос 2021 оны хооронд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн 15 шийтгэх тогтоолыг санамсаргүй байдлаар сонгон, халдлагад өртсөн хууль сахиулагчийн төрөл, хууль сахиулагчийн тавьсан шаардлага, хууль сахиулагчийг эсэргүүцсэн байдал, хэрэглэсэн галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл, ойр дотны хүнийх нь эсрэг халдлага үйлдсэн эсэхийг шалгуур болгон авч үзсэн.

Хууль сахиулагчийн тавьсан шаардлагын хувьд дээрх шийтгэх тогтоолуудыг ангилан авч үзвэл албан үүргээ гүйцэтгэхтэйгээ холбогдуулан тавьсан шаардлага 7, гудамж талбайд бусдыг айлган сүрдүүлж байхыг таслан зогсоохыг шаардсан 1, пост дээр хууль ёсны шаардлага тавьсан 1, шүүхийн шийдвэр биелүүлэх шаардлага 1, биеийн байцаалт шалгах шаардлага 1, гэмт хэргийг таслан зогсоох, баривчлах үед тавьсан шаардлага 2 байна.

Шийтгэх тогтоолд хууль сахиулагчийн зүгээс тавьсан шаардлагын тухай төдий л дэлгэрэнгүй авч үзээгүй буюу хууль сахиулагч тус шаардлагаа чухам ямар нөхцөл байдалд, хэрхэн тавьсан, иргэнтэй хэрхэн харилцсан талаарх мэдээлэл огт үгүй бөгөөд "албан үүргээ гүйцэтгэхтэйгээ холбогдуулан шаардлага тавьсан" хэмээн хэт ерөнхий үгээр, шууд тодорхойлсон нь өмнөх хэсэгтэй ижил байна. Түүнчлэн иргэн биеийн байцаалтаа биедээ байнга авч явах үүргийг эрх зүйн ямар нэг актын дагуу хүлээлгээгүй атал биеийн байцаалтаа үзүүлэхийг иргэнээс шаардах нь хууль ёсны шаардлага мөн эсэхэд анхаарах

нь зүйтэй. Бусад шаардлагын хувьд илт ойлгомжтой, хууль ёсны шаардлагууд байх бөгөөд баривчлах үед болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх шаардлагыг эсэргүүцэж зэвсэг ашигласан нь өмнөх хэсгээс ялгагдах онцлог юм.

Хүснэгт 24. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл

№	Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл	Тохиолдлын тоо
1	Хутга	6
2	Буу	2
3	Газ	2
4	Сүх	1
5	Заазуур	1
6	Уурга	1

Дээрх хүснэгтээс харвал иргэд хууль сахиулагчийг эсэргүүцэхдээ ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлсийн хувьд уурга болон газыг эс тооцвол хүнийг шууд үхэлд хүргэх боломжтой зэвсгүүд байна.

• **Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсгээр зүйлчлэн шийдвэрлэсэн шийтгэх тогтоол**

Хуулийн энэхүү хэсгийн дагуу 2017-гоос 2021 оны хооронд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн 22 шийтгэх тогтоолыг санамсаргүй байдлаар сонгон, халдлагад өртсөн хууль сахиулагчийн төрөл, хууль сахиулагчийн тавьсан шаардлага, хууль сахиулагчийг эсэргүүцсэн байдал, мөн халдлагад өртсөн албаны тоног төхөөрөмж, барилга байгууламж, ойр дотны хүнийг нь эсрэг халдлага үйлдсэн эсэхийг шалгуур болгон авч үзсэн.

Хүснэгт 25. Шүүхийн шийдвэрт тодорхойлсон хууль сахиулагчийн тавьсан шаардлага /23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг/

№	Иргэнд тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлага (шүүхийн шийдвэрт дурдсанаар)	Тоо
1	Нийгмийн хэв журмыг зөрчиж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан үйлдлийг нь шалгах тухай шаардлага тавьсан.	2
2	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон учир машиныг саатуулах болон согтуурлын зэргийг нь хэмжих тухай шаардлага тавьсан.	3
3	Албан үүргээ гүйцэтгэхтэйгээ холбогдуулан шаардлага тавьсан.	9
4	Бичиг баримтаа шалгуулах шаардлага тавьсан.	2
5	Тээврийн хэрэгслийг зогсоох шаардлага тавьсан.	1
6	Хэв журам зөрчсөн үйлдлийг шалгах шаардлага тавьсан.	2

Эдгээр шаардлага нь хуулийн бусад хэсгийн дагуу шийдвэрлэсэн хэргүүдийнхтэй ижил байна.

Хүснэгт 26. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэхдээ халдсан объектууд

№	Халдлагын объект	Тоо
1	Цагдаагийн автомашинд халдсан.	7
2	Цагдаагийн хувцас, хэрэглэлийг урж, энгэрийн камерыг нь эвдсэн.	3
3	Цагдаагийн хэсгийн эд хогшлыг эвдэлсэн.	4
4	Цагдаагийн байранд халдсан.	4
5	Цагдаагийн драгерыг эвдэлсэн.	2
6	Цагдаагийн хэлтсийн станцад халдсан.	1
7	Цагдаагийн албан хэрэгцээний табыг эвдэлсэн.	1

Дээрх хүснэгтээс харвал нийтлэг байдлаар шаардлага тавьсан цагдаагийн алба хаагчийн биедээ авч явсан, хэрэглэж байсан, унаж явсан бүхий л эд зүйлд халдсан байх бөгөөд цагдаагийн албан газар буюу хэлтсийн эд хогшилд ч ихээхэн халдсан байна. Өөрөөр хэлбэл, шаардлага тавьсан цагдаагийн алба хаагчтай холбоотой бүхий л объектод халдах нийтлэг хандлага ажиглагдаж байна.

• Цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын асуулга

Судалгааны хүрээнд цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын асуулгаас хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн үйлдэгдэж буй нөхцөл байдалтай холбоотой хэсгийг энд асуултын дугаар, асуулт, асуултад хариулсан байдлыг харуулсан хүснэгтийн хамт оруулж, дүн шинжилгээ хийсэн болно.

Анкетын асуулгын “Таны албан үүргээ биелүүлэхтэй холбоотой тавьсан ямар шаардлагыг эсэргүүцсэн бэ?” гэх асуултад нийт 914 цагдаагийн алба хаагчаас 453 алба хаагч хариулсан байна (Хавсралт 4-ийн 1 дэх хүснэгтийг харна уу). Тухайн асуултад хариулсан байдлыг доорх графикт харууллаа.


График 1. Эсэргүүцэл үзүүлсэн иргэдэд тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлага



Графикаас харвал 24.3 хувь буюу хамгийн их дурдагдсан хариулт нь “хэрүүл маргаан, зодооноо болих” байгаа бол хамгийн бага буюу 0.7 хувь нь “Ковидын явган эргүүлээр үүрэг гүйцэтгэхэд иргэд шаардлагыг маш их эсэргүүцсэн” гэх хариулт байна.

Анкетын асуулгын “Таны албан үүргээ биелүүлэхтэй холбоотой шаардлагыг тухайн этгээд хэрхэн эсэргүүцсэн бэ?” гэх асуултад нийт 962 цагдаагийн алба хаагч хариулсан (Хавсралт 4-ийн 2 дахь хүснэгтийг харна уу).

График 2 . Иргэдийн эсэргүүцлийн хэлбэр



Графикаас дүгнэвэл иргэд дийлэнх тохиолдолд асуулгад оролцсон цагдаагийн алба хаагчдын тавьсан шаардлагыг гэмтэл учруулахгүйгээр хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлэх байдлаар эсэргүүцсэн байна.

Гэмт хэргийн нөхцөл, байдлын хувьд тоон мэдээллүүдээс харвал цагдаагийн алба хаагч тухайн жилүүдэд нийт 468 удаа тус гэмт хэргийн хохирогч болсон нь энэ төрлийн гэмт хэргийн нийт хохирогчдын 76.3 хувийг эзэлж байна. Эндээс хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн улмаас цагдаагийн алба хаагч хамгийн их хохирогч болдог нь харагдаж байгаа юм. Иймээс тус гэмт хэргийн шалтгааныг судлахдаа цагдаагийн алба хаагчдын хувьд тухайлан авч үзэх шаардлагатай. Харин хохирогчийн нас, хүйсийн байдлын хувьд хууль сахиулагчийн ажлын байрны онцлогтой холбоотойгоор тухайн ажлын байрны шаардлага, нөхцөлөөс шууд хамааралтай байна. Энэ нь тус гэмт хэргийн шалтгааныг илрүүлэхэд төдий л ач холбогдолтой үзүүлэлт биш хэмээн үзлээ.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь, гэмт хэрэг үйлдэгдсэн гарагийн мэдээлэл, гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн мэдээлэл, гэмт хэрэг үйлдэгдсэн газрын мэдээлэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын болон нөхөн төлүүлэлтийн хэмжээний мэдээлэл, тус гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчийг ажил үүргийнх нь төрлөөр ангилсан тоон мэдээлэл, гэмт хэргийн хохирогч болсон хууль сахиулагчдыг төрлөөр нь болон оршин суугаа орон нутгаар нь ангилсан тоон мэдээлэл, гэмт хэрэгт холбогдогчийн боловсролын түвшний мэдээлэл, гэмт хэргийн холбогдогчийн нийгмийн байдлын мэдээллүүдэд анализ хийхэд шалгуур үзүүлэлтүүдийн тоон утга хоорондоо харьцангуй ижил буюу ойролцоо байна.

Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн мэдээлэл, “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн ерөнхий мэдээлэл, “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн насны ангилал, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, иргэний харьяаллын мэдээллүүдэд анализ хийхэд дээр дурдсантай мөн адил шалгуур үзүүлэлтүүдийнх нь тоон утга хоорондоо харьцангуй ижил буюу ойролцоо байна.

Цагдаагийн болон шүүхийн дээрх тоон мэдээллүүдэд тодорхой нэг үзүүлэлт бусад үзүүлэлтээс их байгаа боловч тэр нь нийт үзүүлэлтийн 50 хувьд хүрэхгүй байгаа учир тухайн үзүүлэлт нэг бүрийг тухайлан авч үзэх нь оновчгүй. Харин дээрх тоон мэдээллүүд дэх шалгуур үзүүлэлтүүдийн тоон утга хоорондоо ийнхүү ойролцоо, тухайлан авч үзэх шаардлагагүй байгаа нь тус гэмт хэргийн нөхцөл байдлыг илтгэх чухал үзүүлэлт юм. Гэмт хэрэг үйлдэгдсэн орон зай, байршлын хувьд нийтлэг бус байх бөгөөд гэмт хэрэгт холбогдогчийн нас, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд ангилан авч үзсэн бүлгүүд өөр хоорондоо ойролцоо үзүүлэлттэйгээр тус гэмт хэрэг үйлдэгдэж байгаагаас хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг иргэд нийтлэг байдлаар үйлддэг болох нь харагдаж байна.

Харин гэмт хэрэгт холбогдогчийн гэмт хэрэг үйлдсэн байдлын хувьд 2017 оноос 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар үйлдэгдсэн, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 76,6 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байх бөгөөд шүүхийн тоон мэдээлэлд ч согтуугаар үйлдсэн тохиолдол олон байна. Мөн анализ хийхээр сонгосон шүүхийн шийтгэх тогтоолуудад ч тус гэмт хэргийг согтуугаар үйлдсэн тохиолдол олон байгааг холбогдох хэсэгт дурдсан билээ. Эдгээрээс дүгнэвэл иргэд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг дийлэнх тохиолдолд согтуугаар үйлдэх хандлагатай байна. Гэвч энэ нь тийм ч онцлохуйц нөхцөл байдал биш юм. Учир нь манай улсад дийлэнх тохиолдолд согтуугаар үйлдэгддэг гэмт хэргийн төрөл маш түгээмэл байдаг. Иймд тус асуудлаар илүү өргөн цар хүрээтэй, нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй хэмээн үзэж, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг архиан согтуурахтай холбон тусгайлан судлах шаардлагагүй гэж үзлээ.

Санамсаргүй байдлаар сонгосон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд анализ хийж үзэхэд хууль сахиулагч тухайн тохиолдолд шаардлагыг хэрхэн, ямар үг хэрэглэж, ямар нөхцөл байдалд тавьсан талаар буюу шаардлагын тухай нарийн тодорхой мэдээлэл үгүй боловч бидний сонгосон бүх шийтгэх тогтоолд шүүхээс хууль сахиулагчийн тавьсан шаардлагыг хууль ёсны шаардлага хэмээн үзжээ. Цаашид тус хэргийн объектив нөхцөл байдлын тухай шүүхийн шийтгэх тогтоолд бичихдээ дэлгэрэнгүй бичих буюу хангалттай тодорхой, үндэслэл бүхий байх шаардлагатайг энд дурдах нь зүйтэй юм. Гэвч шүүхийн шийтгэх тогтоолууд нэгэнт хүчин төгөлдөр болсныг харгалзан, шүүхэд тодорхой хэмжээнд итгэсний үндсэн дээр тохиолдол бүрд иргэд заавал биелүүлэх нь тодорхой буюу хууль, журам, дүрэм болоод зан суртахууны заавал биелүүлэх хэм хэмжээнд илт эс нийцсэн үйлдэл хийсэн, хийж байсан атлаа хууль сахиулагчийн зүгээс тухайн үйлдлийг нь таслан зогсоох шаардлага тавихад эс биелүүлсэн, биелүүлэхээс татгалзаж, тавьсан шаардлагынх нь төлөө хууль сахиулагчид хүч хэрэглэн халдсан байгааг тусгайлан авч үзэж, судалгааны дараагийн бүлэгт судлахаар шийдлээ.

4.2. Гэмт хэргийн шалтгаан

Өмнөх хэсэгт бид хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт холбогдох тоон болон чанарын мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж, тус гэмт хэргийн үйлдэгдэж буй нөхцөл байдлыг тодорхойлсон билээ.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн улмаас цагдаагийн алба хаагч хамгийн их хохирогч болдог нь өмнөх хэсэгт нотлогдсон тул энэ хэсэгт эн түүрүүнд цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын судалгааны гэмт хэргийн шалтгаантай холбогдох хэсэгт анализ хийж, түүнээс гарсан үр дүнтэй холбоотой судалгаа болон криминологийн онолын ойлголтуудыг авч үзэн, тус гэмт хэргийн үйлдэгддэг шалтгааныг илрүүлэхийг зорилоо.


• Цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын асуулга

Цагдаагийн алба хаагчид албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан ямар нэг этгээдээс өөрт нь хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн үйлдэл хийж байсан эсэх тухай асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2433 алба хаагч хариулсан ба 37.6 хувь нь “тийм”, 62.4 хувь нь “үгүй” гэж хариулжээ (Хавсралт 4-ийн 3 дахь хүснэгтийг харна уу).

Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэргийн зохицуулалтын хэрэгжилттэй холбоотой тулгамдаж буй асуудлыг алба хаагчдаас асууж тодруулах зорилготой асуултад (Хавсралт 4-ийн 4 дэх хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 712 алба хаагч хариулсан ба 62.9 хувь нь “Өөр асуудал байхгүй”, 17.6 хувь нь “Хуулийн зохицуулалт муу”, 4.9 хувь нь “Мэдэхгүй байна”, 2.8 хувь нь “хуулийн заалтыг иргэдэд сурталчлах, ойлгуулах”, 2.0 хувь нь “удирдлага, менежментээр хангах”, 1.3 хувь нь “Дээрх асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа албан хаагчид нь төдий л ач холбогдол өгдөггүй”, 1.4 хувь нь “Ар гэрт заналхийлж айлгадаг”, 1.8 хувь нь “энгэрийн камер; тусгай хэрэгслээр хангаж өгөх”, 1.1 хувь нь “Прокурор санал дэмжихгүй татгалзах нь олон”, 0.8 хувь нь “Алба хаагчид өөрсдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, харилцааны соёлыг сайжруулах”, 0.7 хувь нь “Хууль сахиулагчид нэр хүндгүй болж байна”, 0.7 хувь нь “Цагдаагийн байгууллагыг үйлчилгээний биш, хүчний байгууллага болгох хэрэгтэй”, 0.3 хувь нь “Танил талаараа хэргийг хаалгадаг”, 0.3 хувь нь “сэтгэл зүйн байдалд анхаарах”, 0.3 хувь нь “Иргэд бусдыгаа цагдаа нарын эсрэг уриалдаг, шууд бичлэг хийдэг”, 0.1 хувь нь “Бичиг цаасны ажил их байдаг”, 0.1 хувь нь “Алба хаагчдыг гүтгэдэг” гэж хариулсан байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилготой асуултад (Хавсралт 4-ийн 5 дахь хүснэгтийг харна уу) давхардсан тоогоор нийт 4363 хариулт байна. Тэдгээр хариултыг хувьчлан доорх графикт харууллаа.


График 3. Гэмт хэргийн шалтгаан (судалгаанд хамрагдагсдын хариулснаар)



Хууль сахиулагчид (өөрийн байгууллагын) мэдлэг, ур чадвартай нь холбоотой ямар асуудлууд тулгардгийг тодруулах зорилгоор алба хаагчдаас асуусан асуултад (Хавсралт 4-ийн 6 дахь хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2349 алба хаагч хариулсан ба 73.0 хувь нь “Шинэ албан хаагчийн мэдлэг; ур чадвар муу байдаг”, 11.2 хувь “Хуучин албан хаагчдын мэдлэг; ур чадвар муу байдаг”, 10.4 хувь нь “Орон нутгийн албан хаагчдын мэдлэг; ур чадвар муу байдаг”, 5.4 хувь нь “Нийслэлийн албан хаагчдын мэдлэг; ур чадвар муу байдаг” гэж хариулжээ.

“Хууль сахиулагчид (өөрийн байгууллагын) мэдлэг, ур чадвараа дээшлүүлж чаддаг уу?” гэх асуултад (Хавсралт 4-ийн 7 дахь хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2283 алба хаагч хариулсан ба 42.4 хувь нь “чаддаг”, 35.4 хувь нь “чаддаггүй”, 22.3 хувь нь “хааяа” гэж хариулсан байна.

График 4. Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 7 дахь асуултад хариулсан байдал




Мэдлэг, ур чадвараа хааяа дээшлүүлдэг, эсвэл дээшлүүлж чадахгүй байгаа нь ямар шалтгаантай болохыг тодруулах зорилгоор асуусан асуултад (Хавсралт 4-ийн 8 дахь хүснэгтийг харна уу) давхардсан тоогоор нийт 2838 хариулт байгаагаас 61.3 хувь нь “Ажлын ачаалал их”, 15.4 хувь нь “Сургалт ховор байдаг”, 7.9 хувь нь “Албаны дарга нар дургүй байдаг”, 7.8

хувь нь “Сурах хүсэл байдаггүй”, 6.6 хувь нь “Эх сурвалж ховор байдаг”, 1.0 хувь нь “Бусад” (“Сургалт үр дүнгүй байдаг”-22, “Суралгалтад суусан цаг ажлын цагаар бодогддоггүй”-1, “Цар тахалтай холбоотой”-1, “Дарга нар анхаарал хандуулдаггүйтэй холбоотой”-3) гэж хариулсан байна.

“Цагдаагийн алба хаагчдын иргэнтэй харилцах харилцааны соёлыг та хэрхэн үнэлэх вэ?” гэх асуултад (Хавсралт 4-ийн 9 дэх хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2308 алба хаагч хариулсан ба 35 хувь нь “дунд”, 33.8 хувь нь “муу”, 21.8 хувь нь “маш муу”, 6.9 хувь нь “сайн”, 2.5 хувь нь “маш сайн” гэж хариулжээ.


График 5. Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 9 дэх асуултад хариулсан байдал



“Хууль сахиулагчийн харилцааны соёл муу гэж үнэлэгдэх нь гол төлөв юунаас хамаардаг вэ?” гэх асуултад (Хавсралт 4-ийн 10 дахь хүснэгтийг харна уу) давхардсан тоогоор 3464 хариулт байгаагаас 29.6 хувь нь “ажлын ачаалал”, 26.0 хувь нь “иргэдийн харилцаа”, 24.8 хувь нь “алба хаагчийн зан ааш муугаас”, 18.1 хувь нь “нийгмийн асуудлуудаас”, 0.5 хувь нь “бусад” (“ажлын онцлогоос”-3, “дарга болон хамтран ажиллагсдын харилцаа, ажлын зохион байгуулалт”-12, “хувь хүнээс”-2, “дээрх бүгд” /хүснэгтийн 1-4 дэх хариулт/-1) гэж хариулсан байна.

Нийгэмд хууль сахиулагчийн нэр хүнд хэрхэн үнэлэгддэг болохыг тодруулах асуултад (Хавсралт 4-ийн 11 дэх хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2300 алба хаагч хариулсан ба 42.6 хувь нь “дунд”, 21.4 хувь нь “муу”, 16.8 хувь нь “сайн”, 9.8 хувь нь “маш сайн”, 9.5 хувь нь “маш муу” байдаг гэж хариулжээ.


График 6. Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 11 дэх асуултад хариулсан байдал



Хууль сахиулагчийн нэр хүнд нийгэмд муугаар үнэлэгдэх шалтгааныг тодруулах зорилготой асуултад (Хавсралт 4-ийн 12 дахь хүснэгтийг харна уу) давхардсан тоогоор 3018 хариулт байгаагаас 12.9 хувь нь “Тухайн байгууллагын үйл ажиллагааны

алдаа”, 17.7 хувь нь “Тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог”, 14.1 хувь нь “Удирдлагуудтай холбоотой асуудал”, 20.2 хувь нь “Танин мэдүүлэх, сурталчилгааны ажил дутмаг”, 34.3 хувь нь “Улс төр, нийгэмтэй холбоотой асуудал”, 0.7 хувь нь “бусад” (“Тухайн хувь хүнээс нь хамаарна”-10, “Эрх зүйн зохицуулалт муу байгаагаас”-6, “Ажлын ачаалал их байгаагаас”-4, “Ажлын онцлогоос”-2) гэж хариулсан байгаа ба асуулгад оролцогчдын хариулсан байдлыг доорх графикт харууллаа.

График 7. Судалгаанд оролцогчид Хавсралт 4-ийн 12 дахь асуултад хариулсан байдал



“Хууль сахиулагчийн (Өөрийн байгууллагын) үйл ажиллагаанд иргэд хэр хүндэтгэлтэй ханддаг вэ?” гэх асуултад (Хавсралт 4-ийн 13 дахь хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2269 алба хаагч хариулсан ба 45.5 хувь нь “дунд зэрэг”, 22.2 хувь нь “хүндэтгэлгүй ханддаг”, 15.0 хувь нь “хүндэтгэлтэй ханддаг”, 12.0 хувь нь “огт хүндэтгэлтэй ханддаггүй” хэмээн хариулжээ.

Хууль сахиулагчийн үйл ажиллагаанд иргэд хүндэтгэлгүй хандах шалтгааныг тодруулах асуултад (Хавсралт 4-ийн 14 дэх хүснэгтийг харна уу) давхардсан тоогоор 2917 хариулт байгаагаас 34.5 хувь нь “Улс төр, нийгэмтэй холбоотой асуудал”, 21.6 хувь нь “Танин мэдүүлэх, сурталчилгааны ажил дутмаг”, 20.1 хувь нь “Тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог”, 12.6 хувь нь “Тухайн байгууллагын үйл ажиллагааны алдаа”, 10.3 хувь нь “Удирдлагуудтай холбоотой асуудал”, 1.0 хувь нь “бусад” (“Тухайн хувь хүнээс нь хамаарна”-15, “Иргэд цагдаагийн байгууллагын тухай сөрөг хандлагатай байдагтай холбоотой”-8, “ажлын онцлогоос”-2, “Иргэд хуулийн мэдлэггүйтэй холбоотой”-3) гэж хариулсан байна.

Анкетын асуулгын “Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн үйлдэл буюу хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн үйлдлийн хохирогч болсон тохиолдолд албадын дарга нар хэрхэн хүлээж авдаг вэ?” гэх асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2009 алба хаагч хариулсан (Хавсралт 4-ийн 15 дахь хүснэгтийг харна уу).

Хүснэгт 27. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд албадын дарга нарын хүлээн авдаг байдал

№	Хариулт	Хувь
1	Эрхийг хамгаалдаг.	52.4%
2	Хууль сахиулагч нь бусдад заналхийлүүлж, халдлагад өртөх нь хэвийн үзэгдэл гэж хариу өгдөг.	21.1%
3	Энэ талаар сонсохыг ч хүсдэггүй.	6.5%
4	Тэнэг, чадваргүйгээр нь дууддаг.	10.9%
5	Хүлээж авалгүй уурладаг.	7.5%
6	Шоолдог.	0.6%
7	Бусад	1.0%
Нийт		100.0%

“Тухайн гэмт хэргийн хохирогч болсны дараа хуулийн байгууллагаар хэргээ шийдвэрлүүлж чаддаг уу?” гэсэн асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 1872 алба хаагч хариулсан ба 58.7 хувь нь “чадсан”, 41.3 хувь нь “чадаагүй” гэж хариулсан байна (Хавсралт 4-ийн 16 дахь хүснэгтийг харна уу).

Цагдаагийн алба хаагч хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хохирогч болсон ч хэргээ цагдаагийн байгууллагаар шийдвэрлүүлээгүй шалтгааныг тодруулах зорилготой анкетын асуулгын холбогдох асуултад (Хавсралт 4-ийн 17 дахь хүснэгтийг харна уу) цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 1072 алба хаагч хариулсан ба 34.7 хувь нь “Хууль сахиулагч хүний хувьд хэвийн үзэгдэл гэж бодсон”, 24.8 хувь нь “Хэргийг шийдвэрлэх үйл явцаас төвөгшөөсөн”, 18.3 хувь нь “Дээр дурдсан албадын дарга нарын сөрөг үйл ажиллагаатай холбоотой”, 13.9 хувь нь “Санаа зовсон, бусдаас ичсэн”, 7.3 хувь нь “Хэн нэгний ятгалгад орсон”, 1.0 хувь нь “Бусад” (“Прокурорын байгууллагаас хэргийг шийдвэрлэдэггүй”-5, “Иргэдийн эрх ашгийг тэргүүнд тавьдаг”-1, “Хууль нь ойлгомжгүй”-1, “Алба хаагчид байгууллагын нэр хүндээ хамгаалахын тулд эрхээ эдэлдэггүй”-3) гэж хариулсан байна.

“Хууль сахиулагчийн эрх ашгийг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг та хэрхэн үнэлэх вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2240 алба хаагч хариулсан ба 44.2 хувь нь “дунд”, 18.3 хувь нь “сайн”, 17.0 хувь нь “маш сайн”, 14.5 хувь нь “муу”, 6.0 хувь нь “маш муу” хэмээн хариулжээ (Хавсралт 4-ийн 18 дахь хүснэгтийг харна уу). Тус асуултад “муу” хэргийг хариулсан 535 оролцогчдос 426-ийнхүү үнэлэх болсон шалтгааныг нь тодруулах зорилгоор тавьсан асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 406 алба хаагч хариулсан байна (Хавсралт 4-ийн 19 дэх хүснэгтийг харна уу).

Хүснэгт 28. Хууль сахиулагчийн эрх ашгийг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчны талаарх хууль сахиулагчдын үнэлэмж

№	Хариулт	Хувь
1	Хуулийн зохицуулалт ойлгомжгүй, муу, бодит байдалд нийцээгүй.	14.8
2	Тухайн гэмт хэргийг санкц бага байгаатай холбоотой.	4.4
3	Хууль сахиулагчийн эрх мэдэл дутмаг.	2.0
4	Албан хаагчаас өө хайж, буруутгадаг.	11.3
5	Албан хаагчийн эрх ашгийг хамгаалах талаар анхаарч ажилладаггүй.	10.3
6	Дарга нар, албаныхан, байгуулга нь байдаг л зүйл гэсэн хандлагаар ханддаг, тоодоггүй.	9.6
7	Албан хаагчаа хамгаалах чиглэлээр хууль тогтоомж хомс, хэрэгждэггүй.	8.1
8	Мэргэшсэн удирдлага муу.	10.3
9	Цагдаагийн байгууллагын нэр хүнд ард иргэдийн дунд муу.	7.1
10	Иргэдийн эрх ашгийг түүрүүнд тавьдаг.	5.7
11	Хүчний байгууллага үйлчилгээний байгууллага болсонтой холбоотой иргэдийн харилцаа, хандлага өөрчлөгдөж, үл хүндэтгэх болсон.	4.2
12	Ажлын ачаалал их, ажиллах нөхцөл тааруу, албан хаагч бүрд чиглэсэн сургалт дутмаг.	3.4
13	Хууль сахиулагчийг хамгаалах холбоо, байгууллага байхгүй.	3.0
14	Цагдаагийн байгууллага, хуулийн тухай мэдлэг олгох сургалт /иргэдэд/ муу.	4.0
15	Нийгмээрээ их бухимдалтай байгаатай холбоотой.	1.8
Нийт		100

Анкетын асуулгын “Хууль сахиулагчийн (Өөрийн байгууллагын) хууль ёсны үйл ажиллагааны талаар мэдээлэл, сурталчилгаа нийгэмд хэр зэрэг түгээгддэг вэ?” хэмээх асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 2215 алба хаагч хариулсан ба 46.6 хувь нь “дунд”, 23.3 хувь нь “муу”, 13.2 хувь нь “сайн”, 5.2 хувь нь “маш сайн”, 11.6 хувь нь “маш муу” байдаг гэж тус тус хариулжээ (Хавсралт 4-ийн 20 дахь хүснэгтийг харна уу).

Анкетын асуулгад анализ хийж дараах байдлаар нэгтгэн дүгнэв. Үүнд:

1. Судалгаанд оролцсон дийлэнх цагдаагийн алба хаагчид хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгааныг иргэдийн хууль сахиулагчийг үл хүндэтгэх байдал, хууль сахиулагчийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт сул байдаг, алба хаагчийн харилцааны соёл, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дутмаг, цагдаагийн байгууллага болон алба хаагчдын нэр хүнд муу байдагтай холбоотой хэмээн хариулжээ.
2. Цагдаагийн алба хаагчдад мэдлэг, ур чадвартай нь холбоотой тулгардаг гол асуудал нь шинэ албан хаагчийн мэдлэг, ур чадвар муу байдагтай холбоотой хэмээн судалгаанд хамрагдсан дийлэнх алба хаагчид хариулсан байна.
3. Цагдаагийн алба хаагчид дийлэнх тохиолдолд мэдлэг, ур чадвараа дээшлүүлж чаддаггүй буюу тийм боломж хааяа олддог байна. Тийнхүү мэдлэг, ур чадвараа дээшлүүлж чаддаггүй шалтгааныг алба хаагчдын ажлын ачаалалтай холбоотой хэмээн тэд хариулжээ.

4. Цагдаагийн алба хаагчдын иргэнтэй харилцах харилцааны соёлыг дийлэнх алба хаагчид муу, маш муу хэмээн үнэлжээ. Ийнхүү алба хаагч харилцааны соёл муу байгааг ажлын ачаалал, иргэдийн харилцаа, алба хаагчийн муу зан ааш, нийгмийн асуудлуудаас болсон хэмээн хариулсан бөгөөд тус хариултууд тоон үзүүлэлтийн хувьд хоорондоо ойролцоо дүнтэй байгаагаас үзвэл эдгээр асуудал бүгд цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл муу байх шалтгааныг үүсгэж буй нийтлэг асуудал болж байгааг харуулж байна.
5. Нийгэмд цагдаагийн байгууллагын нэр хүнд хэрхэн үнэлэгддэг болохыг тандсан асуултын хариултад судалгаанд оролцсон тус байгууллагын дийлэнх алба хаагчид нийгэм дэх өөрийн байгууллагын нэр хүндийг дунд, муу, маш муу хэмээн хариулсан нь анхаарал татаж байна. Ийнхүү таагүй үнэлэгдэх болсон шалтгааныг судалгаанд оролцсон дийлэнх алба хаагчид улс төр, нийгэмтэй холбоотой асуудал болон иргэдэд цагдаагийн албаны талаар танин мэдүүлэх, сурталчилгааны ажил дутмаг байдагтай холбоотой гэж хариулсан байна.
6. Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн дийлэнх нь дунд зэрэг болон хүндэтгэлгүй, огт хүндэтгэлгүй ханддаг хэмээсэн байна. Ийнхүү иргэд хүндэтгэлгүй хандах шалтгааныг дийлэнх алба хаагчид улс төр, нийгэмтэй холбоотой асуудал, иргэдэд тус байгууллагын талаарх танин мэдүүлэх, сурталчилгааны ажил дутмаг байдагтай, мөн тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж байгаа хэмээн хариулсан байна.

Иргэд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг нийтлэг байдлаар үйлдэхдээ заавал биелүүлэх нь тодорхой буюу хууль, журам, дүрэм болоод зан суртахууны заавал биелүүлэх хэм хэмжээнд илт эс нийцсэн үйлдэл хийсэн, хийж байсан атлаа хууль сахиулагчийн зүгээс тухайн үйлдлийг нь таслан зогсоох шаардлага тавихад эс биелүүлсэн, биелүүлэхээс татгалзаж, тавьсан шаардлагынх нь төлөө хууль сахиулагчид хүч хэрэглэн халдаж байгаа нь эн тэрүүнд иргэд тийнхүү хүч хэрэглэн халдах буюу эсэргүүцэх нь зөв хэмээн итгэж байгаатай, мөн цагдаагийн тавьж буй шаардлагаас үл хамааран “цагдаа” хэмээх мэргэжил, мэргэжлийн үйл ажиллагааг нь эс хүлээн зөвшөөрч буйтай хамаатай байж болох юм. Энэхүү дүгнэлтийг цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын судалгааны үр дүн баталгаажуулж байна. Үүгээр зогсохгүй хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгааныг алба хаагчид өөрсдөө тухайн алба хаагчдын мэдлэг ур чадвар, харилцааны соёлтой холбоотой хэмээж, өөрийн байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндийг эерэг бус, сөрөг байдлаар үнэлсэн нь анхаарал татаж байна. Иймд дараагийн дэд хэсэгт цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн үзэл бодол, үнэлэмж, хандлага, тус байгууллага хүний эрхийг хэрхэн ханган ажиллаж буй талаар хийсэн судалгаануудыг авч үзлээ.

• Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ба хүний эрхийн асуудал

2012-2016 онд Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар хөндлөнгийн судалгааны байгууллагууд дээрх тайланг таван удаа гаргасан байна. Энэхүү судалгаанд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн 2017 онд хийгдсэн судалгааг авч үзэх нь илүү ач холбогдолтой гэж үзлээ. Түүнчлэн тус судалгааны үр дүнг өмнөх таван удаагийн судалгаатай харьцуулан дүгнэсэн нь тухайн судалгааны ач холбогдлыг улам нэмэгдүүлж байгаа юм.

Тус судалгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэглэгч болон алба хаагчийн зүгээс үнэлэх судалгааны аргачлал боловсруулах, уг аргачлалын дагуу судалгаа явуулж, дүгнэлт хийх, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах зорилготой⁵⁰ бөгөөд судалгааны түүвэрлэлтийг иргэд, алба хаагч, хамтран ажилладаг байгууллага гэсэн гурван бүлэгт хуваан сонгосон. Бидний судалгаанд тус судалгааны иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан холбогдож байх тул энэ хэсэгт тухайн хэсгийн дүгнэлтийг онцлон авч үзэв.

Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдлыг иргэд ерөнхийд нь дунд зэрэг гэж үнэлжээ. “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн тодорхойлолтын хувьд асуулгад оролцогчдын 28.7 хувь нь “Огт санал нийлэхгүй”, “Санал нийлэхгүй” гэсэн хариулт сонгож, дундаж үнэлгээ нь 2.96 гэсэн үзүүлэлттэй гарсан нь сэтгэл ханамж дунджаас доогуур байгааг илэрхийлж байна гэж үзжээ.⁵¹

Нээлттэй Нийгэм Форум, Дотоод хэргийн их сургуультай хамтран “Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх” талаар судалгаа хийсэн байна. Энэхүү судалгаа нь цагдаагийн мэргэжлийн албаны чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хуваарь, алба хаагчийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт нь хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, эерэг болон сөрөг талыг нь үнэлэн дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах зорилготой⁵² ажээ.

⁵⁰ Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Нээлттэй Нийгэм Форум. Цагдаагийн байгууллага-Хэрэглэгчийн үнэлгээ-2017, УБ., 2018, 4 дэх тал.

⁵¹ Мөн тэнд, 64 дэх тал.

⁵² Нээлттэй Нийгэм Форум, Дотоод хэргийн их сургууль. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх. УБ., 2020, 4 дэх тал.

Тус судалгаанд дүгнэснээр цагдаагийн алба хаагчийн зарим эрхийг хязгаарлах нь албаны онцлог гэж судалгаанд оролцогчдын 64 хувь нь үзсэн байх бөгөөд хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь хүний эрхтэй зөрчилдөг гэж 63 хувь нь үзжээ. Энэ нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа алба хаагчийн хувийн эрхийг хязгаарлахын хамт тэднээс явуулж буй үйл ажиллагаа нь иргэний эрхийг хүндэтгэх, хангах зарчимтай зөрчилдөж байдгийг илтгэж байна хэмээн дүгнэсэн байна.

Дээрх асуудлаас улбаалан иргэд, алба хаагчдын эрх, эрх чөлөө баталгаатай хангагдаж чадахгүй байх нөхцөл үүсэж байх тул зохион байгуулалтын шинжтэй асуудлыг засаж залруулах нь чухал. Үүний тулд алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг боловсронгуй болгон сайжруулах, холбогдох заалтыг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Үндсэн Хуульд заасан хүний эрх, эрх чөлөөтэй уялдуулах нь зүйтэй хэмээн дүгнэсэн байна.⁵³

Стратеги академи 2021 онд олон нийтийн хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэг, түүний хэрэгжилтийг тодорхойлон, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах зорилгоор⁵⁴ “Хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаа” гэх судалгааг нийслэл Улаанбаатар хотын 9 дүүрэг, бүс тус бүрийн төлөөлөл болсон 4 аймгийн 8 сумын 2056 хүнээс анкетын асуулга, 120 хүнээс фокус бүлгийн ярилцлагын аргаар судалгааны мэдээлэл цуглуулан гүйцэтгэсэн байна.

Нэлээд өргөн агуулгатай тус судалгаанаас бидний судалгаанд холбогдох хэсгүүдийг онцлон авч үзье. Төрийн дарамтаас ангид байх эрх зөрчигдсөн тохиолдлын тухай авч үзэхдээ цагдаа, хууль сахиулах байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүрэгтэй ч иргэдийг Зөрчлийн тухай хууль болон бусад хуулийн үндэслэлээр торгож, улсын төсөв бүрдүүлэхэд анхаарч байна хэмээн эдгээр үйлдлийг төрийн дарамт гэж үзжээ. Хүний эрхийн үүднээс задлан харвал төр хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхгүй байгаа тохиолдолд төрийн дарамтаас ангид байх, эсвэл төрийн бодлого, шийдвэр, хэм хэмжээг дагахгүй тэрслэх хандлага иргэдийн дунд тогтож болзошгүй. Ялангуяа хүний эрхэд суурилсан байдлаар хүмүүсийн амьдралд нөлөөтэй шийдвэр гаргах үүрэг хүлээгчдийн зүгээс гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагаа хуулийн дагуу аливаа нэгэн ялгаварлан гадуурхах, тал харахгүйгээр чигч, эрх тэгш, хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байдлаар биелүүлэхгүй байгаа тохиолдолд эв нэгдэлгүй, хагаралдсан, гадуурхагдсан, оролцогч талууд нь нэгнээ үгүйсгэсэн туршлага ч тогтож болзошгүй нөхцөл байдал хэдийнэ бүрэлдсэн гэж дүгнэжээ.⁵⁵

Энэхүү судалгааны төрийн байгууллагын үйлчилгээ дэх сэтгэл ханамжийг тандсан “Таны хандсан байгууллага гомдлыг тань хэрхэн шийдвэрлэсэн бэ?” гэх асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 42.9 хувь нь “муу”, 28.6 хувь нь “дунд зэрэг” хэмээн хариулсан байх бөгөөд ийнхүү цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлэсэн байдалд сэтгэл ханамжгүй байгаа шалтгааныг тодруулахад танил тал, хөрөнгө мөнгөтэй хүний талд асуудлыг шийдвэрлэдэгтэй холбоотой гэжээ. Судалгаанд оролцогчид нүдэнд харагдахуйц гэмтэл бэртэл биед учраагүй тохиолдолд цагдаа нар хэрэг үүсгэж, хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд “Өргөдөл өгөөд үз” гэдэг хариу өгч, шийдэхгүй байх гэсэн байр сууриас асуудалд хандах, гомдол гаргасан хүн өөрөө буруутан болох эрсдэл үүсдэг гэдэгт санал нэгдсэн байна.⁵⁶

Мөн судалгааны “Дараах байгууллагаас аль нь хүний эрхийг хамгийн их зөрчиж байгаа гэж та бодож байна вэ?” гэх асуултад судалгаанд оролцогчдын 31.7 хувь нь буюу ойролцоогоор гурван хүн тутмын нэг нь замын цагдаагаас бусад цагдаа хүний эрхийг хамгийн их зөрчдөг гэж хариулсан.⁵⁷

Замын цагдаагаас бусад цагдааг хүний эрхийг зөрчдөг гэж судалгаанд оролцогч иргэд үзэхдээ архиан согтуурсан иргэнийг зодох, хувиараа худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг хавчин гадуурхах, торгох, гэмт хэрэгт холбогдох, гэрч болох, мэдээлэл өгөх зэргээр цагдаагийн байгууллагатай холбогдсон тохиолдолд олон удаа дуудаж, цагийг нь үрэх, хүнд суртал гаргаж, залхаан цээрлүүлдэг гэж хариулжээ.⁵⁸

Судалгаанд оролцогчид Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй төрийн дарамтаас ангид байх эрх зөрчигдсөн тухай дурдахдаа цагдаа, хууль сахиулах байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүрэгтэй ч иргэдийг Зөрчлийн тухай хууль болон бусад хуулийн үндэслэлээр торгож, улсын төсөв бүрдүүлэхэд анхаарч байна гээд тус үйлдлийг төрийн дарамт гэж үзсэн байна.⁵⁹

⁵³ Нээлттэй Нийгэм Форум, Дотоод хэргийн их сургууль. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх. УБ., 2020, 64 дэх тал.

⁵⁴ Стратеги академи. Хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаа. УБ., 2021, 11 дэх тал.

⁵⁵ Мөн тэнд, 53 дахь тал.

⁵⁶ Мөн тэнд, 80 дахь тал.

⁵⁷ Мөн тэнд, 82 дахь тал.

⁵⁸ Мөн тэнд, 86 дахь тал.

⁵⁹ Мөн тэнд, 96 дахь тал.

“Ковид-19 цар тахал ба хууль сахиулах ажиллагаа, Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол” судалгаа нь Монголын Эмнести Интернэшнлээс Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр хийгдсэн бөгөөд агуулгын хувьд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний үеэрх цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн байна.

Олон нийтийн жагсаал, цуглааныг албадан тараасан, иргэдийг үндэслэлгүйгээр баривчилсан, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах хорио цээрийн дэглэм зөрчсөн хүмүүст таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа эрсдэлд оруулсан, ялгаварлан гадуурхаж, хүч хэрэглэсэн, хүнлэг бус харилцсан цөөнгүй тохиолдлыг Монголын Эмнести Интернэшнл баримтжуулсан байна.

Төрийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар тодорхой биш, мэдээллийн солилцоо хэт удаашралтай байгаа зэрэг нь цагдаа, иргэдийн хооронд үл ойлголцол үүсэх нөхцөл бүрдүүлж байгаа хэдий ч цагдаагийн алба хаагчийн хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдол нь хүний эрх зөрчигдөх шалтгаан болж байна⁶⁰ хэмээн үзжээ.

Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн үзэл бодол, үнэлэмж, хандлагын тухай хийгдсэн дээрх дөрвөн судалгаанаас дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдлын хувьд иргэдийн сэтгэл ханамж дунджаас доогуур түвшинд үнэлэгддэг бөгөөд энэ нь хэдийнэ тогтмол үр дүн болсон байна.
- Цагдаагийн алба хаагчийн зарим эрхийг хязгаарлах нь албаны онцлог гэж дийлэнх алба хаагчид үздэг бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа алба хаагчийн хувийн эрхийг хязгаарлахын хамт тэднээс явуулж буй үйл ажиллагаа нь иргэний эрхийг хүндэтгэх, хангах зарчимтай зөрчилдөж байдгийг илтгэж байна.
- Хууль сахиулах байгууллага, тэр дундаа цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүрэгтэй ч иргэдийг Зөрчлийн тухай хууль болон бусад хуулийн үндэслэлээр торгож, улсын төсөв бүрдүүлэхэд анхаарч байгааг төрийн дарамт гэж үзэх үндэслэлтэй.
- Цагдаагийн байгууллагад гомдол гаргасан иргэд гомдол шалгаж, шийдвэрлэх тус байгууллагын үйл ажиллагаанд дийлэнхдээ сэтгэл ханамжгүй, шийдвэрлэсэн байдал нь шударга гэдэгт итгэдэггүй бөгөөд нүдэнд харагдахуйц гэмтэл бэртэл учраагүй тохиолдолд хэрэг үүсгэж, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаггүй, үл тоох хандлагатай, гомдол гаргасан иргэн өөрөө хохирох эрсдэл үүсдэг гэж үздэг байна.
- Дийлэнх иргэд замын цагдаагаас бусад цагдаа хүний эрхийг хамгийн их зөрчдөг гэж үзэх хандлагатай байна.
- Улмаар энэхүү нөхцөл байдал Ковид-19 цар тахлын үед улам даамжирч жагсаал, цуглааныг албадан тараасан, иргэдийг үндэслэлгүйгээр баривчилсан, таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа ялгаварлан гадуурхаж, хүч хэрэглэсэн, хүнлэг бус харилцсан тохиолдол олширсныг бид дээр дурдсан судалгааны үр дүнгээс харсан билээ.

• Криминологийн онолын үүднээс авч үзсэн нь

Цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын судалгаанд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгааныг алба хаагчид, нэн тэргүүнд хууль сахиулагчийг үл хүндэтгэх байдал болон алба хаагчийн харилцааны соёл, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дутмаг, цагдаагийн байгууллага болон алба хаагчдын нэр хүнд муу байдагтай холбоотой хэмээн хариулсан. Тийм ч учраас удаах дэд хэсэгт бид цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн үзэл бодол, үнэлэмж, хандлага, хүний эрхийг хэрхэн хангаж ажиллаж буй тухай хийгдсэн судалгаануудыг авч үзсэн билээ.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага болох цагдаагийн байгууллага хүний эрхийг хамгийн ихээр зөрчигч хэмээн иргэдэд үнэлэгдэж, хүний эрхийн чиглэлийн судалгаанд тус байгууллагын зарим үйл ажиллагааг төрийн дарамт хэмээн тодорхойлж байгааг бид харлаа. Энэхүү нөхцөл байдал нь хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн шалтгаан болох эсэх тухайд криминологийн шинжлэх ухааны онолын үүднээс бид энэ хэсэгт авч үзэх болно.

⁶⁰ Монголын Эмнести Интернэшнл, Нээлттэй Нийгэм Форум. Ковид-19 цар тахал ба хууль сахиулах ажиллагаа, Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол. УБ., 2021, 25 дахь тал.

Differential Coercion and Social Support Theory буюу Дифференциал албадлага ба нийгмийн дэмжлэгийн онол

Энэхүү онол нь криминологийн хяналтын онолын нэг юм. Хяналтын онолын үндсэн үзэл баримтлал нь хяналтын механизмууд сулрах, үгүй болох тохиолдолд хүн гэмт хэрэг, зөрчил үйлддэг гэх гол үзэл санаанд суурилдаг. Гэвч хяналт нь үргэлж эерэг үр дүнтэй байна гэж үгүй бөгөөд Агнев тэргүүтэй криминологичид хүнийг хянах тэрхүү хяналт нь албадлагын шинжтэй болсноор үр дүн нь хүлээн зөвшөөрөх бус, эсэргүүцэх хариу үйлдэл үзүүлэх шалтгаан нь болдог хэмээн үздэг.⁶¹

Америкийн криминологич Марк Колвин гэмт хэргийг хувь хүнийг хэт ихээр, байнга хянаж байдаг тогтолцоо, уг тогтолцооны зүгээс хувь хүнд үзүүлэх хүчилсэн дарамтын үр дүнд бий болдог хэмээн үзсэн. Түүний үзсэнээр дарамт, шахалт үзүүлэх нь хүмүүсийг зөв хандлага руу биш харин ч гэм буруутай, эсэргүүцсэн, зөрүүд хандлага руу түлхдэг байна.⁶² Колвин өөрийн эрдэм шинжилгээний ажлуудад гэмт хэрэг, зөрчлөөс ангид нийгмийг цогцлоохын тулд хүмүүсийг хүчээр дарамтлах замаар хяналтдаа байлгах аргаас илүү халуун дулаан, найрсаг харилцаа үүсгэж, нийгмийн дэмжлэгээр удирдан чиглүүлэх ёстой тухай өгүүлсэн байдаг.

Дифференциал албадлага ба нийгмийн дэмжлэгийн онолын хувьд хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэх хандлагатай болгодог нийгмийн сонголтын үзэл санаатай гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд түлхэж байгаа буюу гэмт хэрэг үйлдэхийг саатуулах, хориглох механизм суларч байдаг гэх учир шалтгааны үзэл санааг дифференциал байдлаар авч үзсэн юм. Энэхүү онолын гол ойлголт нь хяналт бол нэг талаасаа дарамт шахалт, нөгөө талаасаа зөв зүйтэй, зарим талаараа бүр шаардлагатай арга хэмжээ мөн. Колвины үзэж буйгаар хяналт нь албадах нөлөөтэй, эсвэл нийгмийн дэмжлэгийн шинжтэй байж болно. Түүнчлэн хяналт нь тогтолцоо бүхий нийлбэр цогц тогтмол, эсвэл тогтмол бус тохиолдлын шинжтэй байж болно. Эдгээр нөхцөлийг Колвин гэм буруутай үйлдэл үйлдэх магадлалаар нь дөрвөн загварт ангилан авч үзсэн байдаг.

Онолын үүднээс дээрх албадах гэх шинжийг харгалзахгүйгээр хяналт нь өөрөө системтэй, тогтмол хэрэгжсэн тохиолдолд ихэвчлэн хүлээн зөвшөөрөх, дагах, хэрэгжүүлэх шинж ажиглагддаг бол албадах арга хэрэглэсэн үед түүнийг хүлээн зөвшөөрөх шинж ил ажиглагддаг ч далдуур энэ дарамтаас зугтах, эсэргүүцэх хандлага үргэлж байдаг байна. Чарльз Титель энэхүү хяналтыг “Хяналт, тэнцвэрийн онол”-оороо гурав ангилан авч үзсэн байдаг. Үүнд:

1. Хэт хяналт;
2. Сул хяналт;
3. Тэнцвэрт байдал.⁶³

Хэт хяналт бол хүнийг хянах хяналтын хэрээр тухайн хүн ч бусдыг хянана. Сул хяналт бол хувь хүн бусдыг хянах хяналтаас илүү хяналт түүнийг хянадаг. Тэнцвэртэй байдал бол хувь хүнийг хянах хяналт, түүний бусдыг хянах хяналт тэнцвэртэй гэсэн үг юм. Дутуу хяналтад буй хүмүүс энэ дутуугаа нөхөхийн тулд бусдыг илүү их хянах, дарамтлах, хүч хэрэглэхээс ч буцахгүй. Хэт их хяналттай хүмүүс өөрт байгаа хүчийг хянах, хүч хэрэглэх магадлалтай байдаг ажээ. Колвин 2000 онд бүтцийн хувьд дутуу хяналт, илүү хяналт, албадлагыг тогтмол болон тогтмол бус байдлаар нь ангилан, дараах тогтолцоонуудад хуваасан байдаг. Эдгээр нь:

- Type 1: Consistent, Non-Coercive буюу Хэлбэр I Тогтмол нийгмийн дэмжлэг;
- Type 2: Erratic, Non-Coercive буюу Хэлбэр II Тогтмол бус нийгмийн дэмжлэг;
- Type 3: Consistent, Coercive буюу Хэлбэр III Тогтмол албадлага;
- Type 4: Erratic, Coercive буюу Хэлбэр IV Тогтмол бус албадлага.⁶⁴

Дээрх загваруудаас Type 3: Consistent, Coercive буюу Хэлбэр III Тогтмол албадлагын талаар авч үзье. Энэхүү хяналтын тогтолцоонд хувь хүн өөрт хэрэгцээтэй нийгмийн дэмжлэгийг хангалттай хүртдэггүй ба харин хянагч, хяналтад байгаа хүн хоёрын хооронд шийтгэлд суурилсан харилцаа үүсдэг онцлогтой. Шийтгэлд суурилсан харилцаанаас өөр харилцаа байхгүй тул хүмүүс хүлээн зөвшөөрөх, хүчээр дагахаас өөр аргагүй болдог. Ийнхүү албадах нь хүнд айдас, түгшүүр төрүүлдэг бөгөөд үүнд тулгуурлан хүссэн хандлага руугаа чиглүүлэх боломж олгодог хүч юм хэмээн Колвин тодорхойлсон байдаг. Мөн албадлага нь нийгмийн дэмжлэг, хангамжийг буцаан хураах, хурааж авах сүрдүүлэг бий болгодог гэжээ.

Тогтоосон дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд хамгийн хатуу шийтгэдэг энэ хяналтын тогтолцоонд буруутай үйлдлийг уучлах, эсвэл хоёр дахь боломж олгох зэрэг нөхцөл байдаггүй бөгөөд хүнийг зөв зүйтэй үйлдлийнх нь төлөө шагнах, урамшуулах тогтолцоо ч байдаггүй. Энэхүү гурав дахь хэлбэрийн хяналтад байдаг хүмүүс дүрэм журмыг хүчээр, үг дуугүй

⁶¹ Осман Долу. Криминологийн онолууд. Орч. Э.Дашгаадан, УБ., 2022, 166 дахь тал.

⁶² Мөн тэнд, 167 дахь тал.

⁶³ Мөн тэнд.

⁶⁴ Hasan Bükür. Encyclopedia of Criminological Theory. Colvin, Mark: Coercion Theory. 2014, pp. 196-199 дэх тал.

дагах үүрэгтэй бөгөөд энэ нөхцөлд дотогш хаалттай болж, нийгмийн амьдралд оролцохгүй болдог ба дотогшоо чиглэсэн уур хилэн, арчаагүй байдал, айдас, сэтгэлийн хямралд орж улмаар сэтгэцийн эмгэгтэй болох нь ч бий. Ингэснээр хүний зан үйл, хандлагыг тодорхойлогч нь гадаад хяналтын механизм болдог. Хувь хүний зан үйлд нөлөөлөх гол хүчин зүйл нь шийтгэлээс зугтах рефлекс болдог. Энэ нөхцөлд хүмүүсийн дунд антисоциал хандлага бий болдог байна. Хэдийгээр тэдгээр хүмүүс архаг гэмт хэрэгтэн болдоггүй ч сэтгэлзүйн хямралын улмаас хүн амины хэрэг, халдлага зэрэг санамсаргүй хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэх хандлагатай байдаг.⁶⁵

Гэмт хэргийн нөхцөл байдлын тухай авч үзсэн өмнөх хэсэгт хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдсэн орон зай, байршлын хувьд нийтлэг бус бөгөөд гэмт хэрэгт холбогдогчийн нас, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд ангилан авч үзсэн бүлгүүд өөр хоорондоо ойролцоо үзүүлэлттэйгээр тус гэмт хэрэг үйлдэгдэж байгаагаас иргэд нийтлэг байдлаар хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлддэг болохыг илрүүлсэн билээ. Ийнхүү нийтлэг байдлаар тус гэмт хэргийг үйлдэхийн сацуу заавал биелүүлэх нь тодорхой буюу хууль, журам, дүрэм болоод зан суртахууны заавал биелүүлэх хэм хэмжээнд илт эс нийцсэн үйлдэл хийсэн, хийж байсан атлаа хууль сахиулагчийн зүгээс тус үйлдлийг нь таслан зогсоох шаардлага тавихад эс биелүүлсэн, биелүүлэхээс татгалзаж уг шаардлагынх нь төлөө хууль сахиулагчид хүч хэрэглэн халдаж байгаагийн шалтгаан нь хууль сахиулагч цагдаагийн байгууллага хүний эрхийг хамгийн ихээр зөрчигч хэмээн олон нийтэд үнэлэгдэж, тус байгууллагын зарим үйл ажиллагаа хүний эрхийг үл хэрэгссэн, төрийн зүгээс иргэдэд үзүүлж буй дарамт буюу албадлага болж хувирсантай холбоотой. Энэ ч утгаараа манай нөхцөл байдал Колвины томьёолсон "Хэлбэр III Тогтмол албадлага"-ын тогтолцоотой ижил байна.

Учир нь тус гэмт хэргийг үйлдэж буй нөхцөл байдал тун нийтлэг байгаа нь хэн ч, хэзээ ч уг гэмт хэргийг үйлдэхэд бэлэн байгааг буюу гэмт хэрэг үйлдэх нь тухайн хүний зүгээс үзүүлэх хариу үйлдэл мэт байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, иргэд өөрт дарамт учруулагч, албадагч этгээдийг шууд эсэргүүцэх хариу үйлдэл үзүүлж байна гэсэн үг юм. Уг хариу үйлдэл нь хууль сахиулагч болох цагдаагийн байгууллагын алба хаагчийн хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдолтой, илт албадлагын шинжтэй үйл ажиллагаанаас шалтгаалж байна.

Гэмт хэргийн шалтгааны тухай авч үзсэн судалгааны энэ хэсгийг дүгнэвэл судалгаанд оролцсон дийлэнх цагдаагийн алба хаагчид хууль сахиулах гэмт хэргийн шалтгааныг иргэдийн хууль сахиулагчийг үл хүндэтгэх байдал их, хууль сахиулагчийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт сул байдаг, алба хаагчийн харилцааны соёл, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дутмаг, цагдаагийн байгууллага болон алба хаагчдын нэр хүнд муу байдагтай холбоотой хэмээн хариулжээ. Ийнхүү алба хаагчид өөрсдөө өөрийн байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндийг эерэг бус, сөрөг үнэлгээгээр үнэлсэн нь өөрсдөө ч энэхүү нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрдөг болохыг харуулж байна.

Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдлын талаарх иргэдийн сэтгэл ханамж тогтмол дунджаас доогуур түвшинд үнэлэгдсээр өдийг хүрсэн ба тус байгууллагад гомдол гаргасан иргэд гомдлыг шалгаж, шийдвэрлэх үйл ажиллагаанд дийлэнхдээ сэтгэл ханамжгүй, шийдвэрлэсэн байдал нь шударга гэдэгт итгэдэггүй бөгөөд нүдэнд харагдахуйц гэмтэл бэртэл учраагүй тохиолдолд хэрэг үүсгэж, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаггүй, үл тоох хандлагатай, гомдол гаргасан иргэн өөрөө хохирох эрсдэл үүсдэг гэж үздэг байна.

Цагдаагийн байгууллагын хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдолтой үйлдлүүдээс үүдэн дийлэнх иргэд цагдаа хүний эрхийг хамгийн их зөрчдөг гэж үзэх хандлагатай байна. Үүнээс гадна цагдаагийн зарим үндсэн чиг үргийн үйлдлийг төрийн дарамт гэж тодорхойлох болжээ.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэж буй нөхцөл байдал тун нийтлэг байдалтай байгаа нь тухайн хүний зүгээс үзүүлэх хариу үйлдэл мэт байгааг Differential Coercion and Social Support Theory буюу Дифференциал албадлага ба нийгмийн дэмжлэгийн онолын үүднээс авч үзвэл тус гэмт хэргийн үндсэн шалтгаан нь хууль сахиулагч болох цагдаагийн байгууллагын алба хаагчийн хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдолтой, илт албадлагын шинжтэй үйлдэл, үйл ажиллагаа болох нь тодорхой байна.

4.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай

Судалгааны өмнөх хэсгүүдэд бид хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нөхцөл байдлыг тодруулж, уг гэмт хэргийн шалтгааныг түүнээс тодорхойлсон билээ. Энэ хэсэгт цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын судалгаанд хийсэн анализ болон өмнөх хэсгүүдийн дүгнэлтэд үндэслэн тухайн гэмт хэргээс хэрхэн сэргийлэх тухай авч үзэх болно.

⁶⁵ Hasan Büker. Encyclopedia of Criminological Theory. Colvin, Mark: Coercion Theory. 2014, pp.196-199.

• Цагдаагийн алба хаагчдаас авсан анкетын асуулга

Анкетын асуулгын “Хууль сахиулагчийн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дутмаг байхаас үүдэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн сэргийлж болох вэ?” гэх асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 724 алба хаагч хариулсан ба 24.7 хувь нь албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах, 20.3 хувь нь хууль сахиулагчийн мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, 12.0 хувь нь иргэдийн ухамсрыг дээшлүүлэх, 9.9 хувь нь олон жил ажилласан дадлага туршлагатай алба хаагчдыг дадлагажуулах багшаар тавих, туршлагатай алба хаагчдыг шинэ алба хаагчдын хамтрагчаар ажиллуулах, 9.0 хувь нь ажлын орчныг сайжруулах (цалин хөлс, хангамж, ажлаас гадуурх цаг), 6.9 хувь нь эрх зүйн орчныг сайжруулах, 5.9 хувь нь өөрийнхөө аюулгүй байдлыг хангадаг болгох, 4.4 хувь нь цагдаагийн байгууллагад авч байгаа алба хаагчдаа сайтар судалж, чадвар, чадамжтайг нь авч ажиллуулах, босго өндөр байх, 4.0 хувь нь иргэд болон хууль сахиулагчийн хамтын ажиллагааг сайжруулах, 2.9 хувь нь хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх болон өөрийгөө хамгаалах хуулийн зүйл, заалтыг судлуулж, түүний дагуу иргэдтэй харилцахад нь дээд шатны байгууллагаас дарамт үзүүлдэггүй байх, зоригтой болгох гэж тус тус хариулсан байна (Хавсралт 4-ийн 21 дэх хүснэгтийг харна уу).

“Албан хаагчийн нэр хүндтэй холбоотой асуудлаас үүдэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн сэргийлж болох вэ?” хэмээх асуултад судалгаанд оролцсон цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 716 алба хаагч хариулсан ба 58.8 хувь нь удирдлагаас арга хэмжээ авах, 10.1 хувь нь иргэдэд чиглэсэн мэдээ мэдээлэл түгээх, сурталчлах, 8.5 хувь нь албан хаагч өөрөө хичээж мэдлэг, ур чадвараа сайжруулах, 7.4 хувь нь харилцаа, хандлага сайжруулах, 7.3 хувь нь код журмын дагуу харилцах, 6.3 хувь нь эрх зүйн орчныг сайжруулах, 0.8 хувь нь цагдаагийн байгууллагыг улс төрөөс ангид байлгах, 0.4 хувь нь нөхцөл байдлыг зөв үнэлж ажилладаг байх, мөн 0.4 хувь нь хүчний байгууллага болох гэж хариулжээ (Хавсралт 4-ийн 22 дахь хүснэгтийг харна уу).

Иргэдийн хууль сахиулагчийг үл хүндэтгэх байдалтай холбоотой асуудлаас үүдэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн сэргийлж болох талаарх асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 961 алба хаагч хариулсан ба 28.9 хувь нь иргэдэд хууль эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, 20.4 хувь нь иргэд болон хууль сахиулагчид хоорондын харилцаандаа анхаарах, 9.6 хувь нь хуульд өөрчлөлт оруулах, 9.1 хувь нь мэдэхгүй, санал байхгүй, 6.8 хувь нь хуулийг иргэдэд сурталчлах (олон нийтийн цахим сүлжээгээр), 6.7 хувь нь хариуцлагыг хүндрүүлэх, 5.4 хувь нь соён гэгээрүүлэх ажил эрчимтэй хийх, 4.9 хувь нь хандлага өөрчлөх, 3.5 хувь нь цагдаагийн байгууллагыг улс төрөөс ангид болгох, 3.0 хувь нь алба хаагчдын хувийн ур чадварыг дээшлүүлэх, бие бялдрын тал дээр анхаарах, 1.7 хувь нь хуулийн биелэлтийг хангах гэж хариулсан байна (Хавсралт 4-ийн 23 дахь хүснэгтийг харна уу).

Анкетын “Албаны даргын үйл ажиллагааны доголдолтой холбоотой асуудлаас үүдэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн сэргийлж болох вэ?” гэх асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 539 алба хаагч хариулсан ба 26.3 хувь нь хоорондын харилцааг сайжруулах, 17.8 хувь нь мэдэхгүй байна, 15.5 хувь нь хууль сахиулагч, дарга хоёрын хамтын ажиллагааг сайжруулах, 12.4 хувь нь цаг тухай бүрт мэдээллээр хангах, 9.1 хувь нь сургалт, сурталчилгаа зохион байгуулах, 8.0 хувь нь хяналтыг сайжруулах, 6.3 хувь нь албаны сургалтыг үр өгөөжтэй болгох, 4.6 хувь нь зөв үүрэг, чиглэлийн дагуу л ажиллах, төв байгууллагын даргад мэдэгдэх гэж хариулсан байна (Хавсралт 4-ийн 24 дэх хүснэгтийг харна уу).

“Хууль сахиулагчийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт сул байгаатай холбоотой асуудлаас үүдэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн сэргийлж болох вэ?” гэх асуултад нийт 2522 цагдаагийн алба хаагчаас 562 алба хаагч хариулсан ба 44.8 хувь нь хуулийн зохицуулалтыг чангатгах, сайжруулах, өөрчлөх, 15.1 хувь нь мэдэхгүй байна, 10.3 хувь нь иргэдэд сурталчлах /тухайн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай/, 8.5 хувь нь хариуцлагатай байдал, 6.8 хувь нь санал хүсэлт байхгүй, 5.1 хувь нь техник, технологийг сайжруулах, 4.4 хувь нь хувь хүний ухамсар, 3.4 хувь нь мэдлэг боловсролоо сайжруулах /алба хаагч/, 1.6 хувь нь олон улсаас жишиг судлан практикт буулгах гэж хариулжээ (Хавсралт 4-ийн 25 дахь хүснэгтийг харна уу).

Тохиолдлын байдлаар тухайн гэмт хэрэг үйлдэгддэгтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн сэргийлэх тухай асуултад судалгаанд оролцсон цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 556 алба хаагч хариулсан ба 46.2 хувь нь удирдлагаас арга хэмжээ авах, 15.5 хувь нь иргэдэд энэ төрлийн гэмт хэргийн талаар ойлголт өгөх, 9.7 хувь нь урьдчилан сэргийлэх ажил хийх, 6.3 хувь нь албан хаагчид харилцаандаа анхаарах, 5.9 хувь нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, 5.2 хувь нь хариуцлагатай ажиллах, аюулгүй байдлаа хангах, 3.8 хувь нь аюулгүй байдлаа хангах, 3.6 хувь нь албаны нэр хүндийг өсгөх, хууль сахиулагчийн ажлын талаар сурталчлах, 1.8 хувь нь хувь хүний ухамсар, 0.7 хувь нь хүчний байгууллага болгох, 0.5 хувь нь урьдчилан сэргийлэх боломж байдаггүй, 0.4 хувь нь гэмт хэргийг таслах зогсоох, мөн 0.4 хувь нь цагдаагийн байгууллагыг улс төрөөс ангид байлгах хэрэгтэй хэмээн тус тус хариулсан байна (Хавсралт 4-ийн 26 дахь хүснэгтийг харна уу).

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай асуултад цагдаагийн нийт 2522 алба хаагчаас 372 алба хаагч хариулсан ба 41.7 хувь нь иргэдэд хуулийг ойлгомжтой, сонирхолтой байдлаар сурталчлах, хүлээлгэх хариуцлагыг ойлгуулах, 24.7 хувь нь удирдлагаас арга хэмжээ авах, 17.2 хувь нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, 9.1 хувь нь албан хаагчид харилцаандаа анхаарах, 3.5 хувь нь иргэд, цагдаагийн байгууллагын алба хаагчид хоорондын итгэлцлийг нэмэгдүүлж, уялдаа холбоог сайжруулах, 2.6 хувь нь хүчний байгууллага болох, 0.8 хувь нь бусад орны практикаас суралцах, судлах, 0.4 хувь нь цагдаагийн байгууллагыг улс төрөөс ангид байлгах хэрэгтэй гэж тус тус хариулжээ (Хавсралт 4-ийн 27 дахь хүснэгтийг харна уу).

Цагдаагийн алба хаагчаас авсан анкетын асуулгын үр дүнг нэгтгэвэл дийлэнх алба хаагчид хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс дараах байдлаар урьдчилан сэргийлэх боломжтой гэж хариулсан байна. Үүнд:

- Хууль сахиулагчийн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дутмаг байдлаас үүдэн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс сэргийлэхийн тулд албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулж, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх нь зүйтэй.
- Алба хаагчийн нэр хүндтэй холбоотойгоор хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс сэргийлэхийн тулд цагдаагийн байгууллагын удирдлагын зүгээс асуудалд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ёстой бөгөөд үүний нэг жишээ нь иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл түгээх, сурталчлах ажил юм.
- Иргэдийн хууль сахиулагчийг үл хүндэтгэх байдлын улмаас хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс сэргийлэхийн тулд иргэдэд хууль эрхзүйн мэдлэгийг нь дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, иргэд, алба хаагч хоорондын харилцаанд анхаарах шаардлагатай.
- Хууль сахиулагчийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт сул байгаагаас шалтгаалсан хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдэхээс сэргийлэхийн тулд хуулийн зохицуулалтыг сайжруулах, өөрчлөх хэрэгтэй.

Түүнчлэн хэдийгээр дийлэнх биш ч бүх асуултад тодорхой тооны алба хаагчид алба хаагчийн харилцаа, хандлагыг сайжруулж, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлснээр хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс сэргийлнэ хэмээн хариулсан байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, тэр дундаа шинэ алба хаагчийн хувьд үүнд илүү анхаарах хэрэгтэй.
2. Алба хаагчдын ажлын ачаалалтай уялдуулан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах боломж олгох буюу тухайн зорилгоор сургалтын үйл ажиллагааг үр дүнтэйгээр, тогтмол зохион байгуулж байх шаардлагатай.
3. Нийгэмд цагдаагийн албаны нэр хүнд муу байгаагийн нэг шалтгаан нь тус байгууллагын зүгээс цагдаагийн байгууллага улс төрийн аль нэг хүчнээс хамааралтай мэт үйл ажиллагаа явуулах болсонтой холбоотой байх тул цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгахад цаашид анхаарах шаардлагатай.
4. Цагдаагийн алба хаагч болоход нэн тэргүүнд харилцааны соёл, ёс зүйн төлөвшил, хүний эрхийн мэдрэмж, мэдлэгийг шалгуур үзүүлэлт болгож байхыг боловсон хүчний бодлогодоо зайлшгүй тусгах нь зүйтэй.
5. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхдээ албадлага, хяналт, шийтгэлд төвлөрөх нь төрийн зүгээс иргэдэд дарамт учруулж, тухайн үйл ажиллагааныхаа үндсэн зорилгоос эсрэг үр дүнг бий болгох эрсдэлтэйг харгалзан үзэж, нийгмийн дэмжлэгт суурилсан хяналтын тогтолцоог гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогод тодорхой хэмжээгээр ч болов тусгах шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Хууль сахиулах үйл ажиллагаа нь хууль сахиулагч гэх албан хаагчийн төлөөллөөр дамжин хэрэгждэг бөгөөд төрөөс хүний эрхийг хамгаалах, нийтийн эмх замбараатай байдал, дэг журмыг сахиулахад чиглэдэг. Хууль сахиулагчийг эсэргүүцэх ойлголтын талаар түгээмэл тодорхойлолт, онолын үзэл баримтлал гэх мэт дэлхий нийтээр нэг түвшинд ойлгодог тодорхойлсон зүйл байдаггүй бөгөөд улс орон бүр өөр өөрийн эрх зүйн тогтолцоонд үүнийг гэмт хэрэг болгон янз бүрээр зохицуулдаг байна. Энэ нь тухайн улс орон дахь уг гэмт хэрэг, нийгмийн үзэгдлийн гаралтын давтамж, хор хөнөөл, нийгэмд аюултай байдал болон хууль сахиулах байгууллагын ажилтны нийгмийн баталгааг хэрхэн хангаж буйтай холбоотой гэж таамаглаж байна.
2. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалт нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ээс 2015 оны “Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)” хүртэл хуульчлагдсан түүхэн уламжлал бүхий зохицуулалт бөгөөд улам бүр шинэчлэгдэн боловсронгуй болсоор өдийг хүрчээ.
3. Гэмт хэргийн хувьд хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн үйлдэл байх бол зөрчлийн хувьд хууль ёсны шаардлага биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан, үйл ажиллагаанд нь саад учруулсан, хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон үйлдэл байна.
4. 2017-гоос 2021 онд Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийт 451 тохиолдол цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Үүнээс 2017 онд 46, 2018 онд 85, 2019 онд 97, 2020 онд 116, 2021 онд 107 тус тус бүртгэгдсэн. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал нь 2017 оны 7 дугаар сараас 2020 он хүртэл нийт 102 байх ба сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тухайд прокурорын байгууллага 2020 онд нийт 198 хэрэг, 2021 онд нийт 241 хэрэгт тус тус хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байна. Энэ нь тухайн онуудад тус гэмт хэрэг 21.7 хувиар өссөн байгаа үзүүлэлт юм. Ял шийтгүүлсэн нийт этгээдүүдээс хорих ял эдэлж буй хүмүүс 2017 оноос 2021 оны 7 дугаар сарын 30 хүртэл нийт 9 бүртгэгдсэн байна. 2017 онд тухайн зохицуулалт үйлчилж эхэлснээс хойш 2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн байхгүй байна. Харин торгох ялын тухайд 2017 онд 7, 2018 онд 14, 2019 онд 24, 2020 онд 33, 2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар 42, нийтдээ 120 этгээд тухайн ялаар шийтгүүлсэн байна. Торгох ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн тухайд 2017-2021 оны 7 дугаар сарын 30-ны байдлаар 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр шийтгүүлсэн 112, 23.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсгээр шийтгүүлсэн 8 байна. Торгуулийн хэмжээний тухайд ял шийтгүүлсэн нэг этгээдэд дунджаар 3105666 төгрөгийн торгууль ногдуулсан байна.
5. 2015 оны Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарын цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг хууль сахиулагч гэж тодорхойлсон тодорхойлолт нь зарим талаар оновчтой хэдий ч үүнийг хэрхэн ойлгох талаар нэгдмэл ойлголтод хүрэх нь зүйтэй. Учир нь хэтэрхий өргөн хүрээнд тодорхойгүй байдлаар тодорхойлсон байна. Тиймээс үүнийг нийтлэг байдлаар тодорхойлж “хууль сахиулагч” гэх нэр томъёонд хамаарах алба хаагчийг нэг мөр ойлгохдоо хууль сахиулагч болон хууль сахиулах үйл ажиллагааны талаар нийтлэг тодорхойлолтод үндэслэх нь зүйтэй. Мөн үүнээс гадна Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд заасан хууль сахиулагчийн тодорхойлолт, ойлголтод хамаарах алба хаагчдын эрх ашгийг бүрэн хамгаалахгүй байгаа шүүх, прокурорын практик байна. Хууль сахиулагч гэх тодорхойлолтыг нэг мөр ойлгож, уг ойлголтыг олон нийтэд сурталчилж, нэмэлт, өөрчлөлт оруулж хуульчилснаар тухайн практикийг өөрчлөх боломжтой.
6. Монгол Улсад Эрүүгийн хуулиар хууль сахиулагчийн ойр дотны хүний эрх ашгийг хамгаалдаггүй бөгөөд бусад улс оронд зохицуулж байгаа нөхцөл байдал, цагдаагийн алба хаагчдын хэрэгцээ, шаардлага, бодит хэрэгт бүртгэгдсэн байдал зэргээс дүгнэвэл хууль сахиулагчийн ойр дотны хүнийг Эрүүгийн хуулиар хамгаалах шаардлагатай байх тул Эрүүгийн хуульд нэмэлт оруулж тус зохицуулалтыг хуульчлах хэрэгтэй байна.
7. Хууль сахиулагч (ихэнх тохиолдолд цагдаагийн алба хаагч)-ийн шаардлага нь хуульд заасан олон төрлийн шаардлага байж болохоор байна. Үүнээс зарим шаардлага (тухайлбал, “Зээлсэн мөнгөө өг” гэсэн шаардлага) нь хууль бус байгаа нь ажиглагдаж байна. Үүнээс гадна шаардлагууд нь ямар нэгэн журам, хууль зөрчсөн, зөрчиж болзошгүй нөхцөл байдал бий болгож байна. Тиймээс Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл буюу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтад хууль сахиулагчийн шаардлага болон шаардлагад хамаарч буй этгээдийн хүлээж авах байдалтай холбоотой зохицуулалт оруулах шаардлагатай байна.

8. Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “бүлэглэж үйлдсэн” гэх үйлдлийн шинжийг нэмж хуульчлах онолын, харьцуулсан судалгааны, практикийн хэрэгцээ, шаардлага байгаа тул тус хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нэмж хуульчлах шаардлагатай.
9. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд эн тэрүүнд тус гэмт хэргийн улмаас цагдаагийн алба хаагч хамгийн их хохирогч болдог болох нь харагдаж байна. Харин гэмт хэрэг үйлдэгдсэн орон зай, байршлын хувьд нийтлэг бус бөгөөд гэмт хэрэгт холбогдогчийн нас, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд тодорхой нэг бүлэг өндөр үзүүлэлт харуулахгүй байгаагаас иргэд нийтлэг байдлаар хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлддэг болох нь харагдаж байна. Түүнчлэн иргэд заавал биелүүлэх нь тодорхой буюу хууль, журам, дүрэм болоод зан суртахууны заавал биелүүлэх хэм хэмжээнд илт эс нийцсэн үйлдэл хийсэн, хийж байсан атлаа хууль сахиулагчийн зүгээс уг үйлдлийг нь таслан зогсоох шаардлага тавихад эс биелүүлэн, биелүүлэхээс татгалзаж, шаардлага тавьсных нь төлөө хууль сахиулагчид хүч хэрэглэн халдаж байна. Судалгаанд оролцсон дийлэнх цагдаагийн алба хаагчид хууль сахиулах гэмт хэргийн шалтгааныг иргэдийн хууль сахиулагчийг үл хүндэтгэх байдал их, хууль сахиулагчийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт сул байдаг, алба хаагчийн харилцааны соёл, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дутмаг, цагдаагийн байгууллага болон алба хаагчдын нэр хүнд муу байдагтай холбоотой хэмээн хариулжээ. Ийнхүү алба хаагчид өөрсдөө өөрийн байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндийг эерэг бус, сөрөг үнэлгээгээр үнэлсэн нь өөрсдөө ч энэхүү нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрдөг болохыг харуулж байна. Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдлын талаарх иргэдийн сэтгэл ханамж тогтмол дунджаас доогуур түвшинд үнэлэгдсээр өдийг хүрсэн ба сүүлийн жилүүдэд тус байгууллагын үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд ч итгэл хүлээлгэхээс иргэд татгалзах хандлагатай байх болсон. Цагдаагийн байгууллагын хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдолтой үйлдлүүдээс үүдэн дийлэнх иргэд цагдаа хүний эрхийг хамгийн их зөрчдөг гэж үзэх хандлагатай байна. Үүнээс гадна цагдаагийн зарим үндсэн чиг үргийн үйлдлийг төрийн дарамт гэж тодорхойлох болжээ. Криминологийн шинжлэх ухааны Differential Coercion and Social Support Theory буюу Дифференциал албадлага ба нийгмийн дэмжлэгийн онолын үүднээс тус гэмт хэргийн үндсэн шалтгаан нь хууль сахиулагч болох цагдаагийн байгууллагын алба хаагчийн хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдолтой, илт албадлагын шинжтэй үйлдэл, үйл ажиллагаа хэмээн дүгнэх нь үндэслэлтэй гэж үзлээ.
10. Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, тэр дундаа шинэ албан хаагчийн хувьд үүнд илүү их анхаарах хэрэгтэй байна. Алба хаагчдын ажлын ачаалалтай уялдуулан тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах боломж олгох буюу тухайн зорилгоор сургалтын үйл ажиллагааг үр дүнтэйгээр, тогтмол зохион байгуулж байх шаардлагатай. Нийгэмд цагдаагийн албаны нэр хүнд муу байгаагийн нэг шалтгаан нь тус байгууллагын зүгээс цагдаагийн байгууллага улс төрийн аль нэг хүчнээс хамааралтай мэт үйл ажиллагаа явуулах болсонтой холбоотой байх тул цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгахад цаашид анхаарах шаардлагатай. Цагдаагийн алба хаагч болоход нэн тэргүүнд харилцааны соёл, ёс зүйн төлөвшил, хүний эрхийн мэдрэмж, мэдлэгийг шалгуур үзүүлэлт болгож байхыг боловсон хүчний бодлогодоо зайлшгүй тусгах нь зүйтэй. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхдээ албадлага, хяналт, шийтгэлд төвлөрөх нь төрийн зүгээс иргэдэд дарамт учруулж, тухайн үйл ажиллагааныхаа үндсэн зорилгоос эсрэг үр дүнг бий болгох эрсдэлтэйг харгалзан үзэж, нийгмийн дэмжлэгт суурилсан хяналтын тогтолцоог төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод тодорхой хэмжээгээр ч болов тусгах шаардлагатай байна.
11. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хуульд тухайн гэмт хэргийг үйлдлээр нь салгаж, олон төрлийн гэмт хэрэг болгон хуульчилсан байна. Тухайлбал, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс гадна албан үүрэг тулгах, төөрөгдүүлэх, гутаан доромжлох, саад учруулах гэх үйлдлүүдийг хамарч байна. Хууль сахиулагчид хамаарах субъектийн тухайд улсын үйл ажиллагааг хангахын тулд хуулийн дагуу ард иргэдийн эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлах, хамгаалах үүрэг бүхий байгууллагыг ойлгохоор зохицуулсан. Энэхүү байдал нь ерөнхий бөгөөд Монгол Улстай адил цагдаагийн байгууллагыг хууль сахиулагчийн гол төлөөлөл болгон авч үздэг байна. Мөн төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагааны талаар хуульчилж өгсөн бөгөөд тухайн албан тушаалтнаас гадна гуравдагч этгээдийг тухайн гэмт хэрэгт хамаатуулан үзсэнээрээ онцлог байна.
12. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд хууль сахиулагч буюу хууль тогтоомж биелүүлж байгаа албан тушаалтан, шүүхийн дүгнэлт гүйцэтгэж байгаа албан тушаалтан, шийдвэр эсвэл захирамж гүйцэтгэж байгаа албан тушаалтан, тушаал гүйцэтгэж байгаа албан тушаалтан, холбооны зэвсэгт хүчний цэрэг, төрийн албан хаагчид хамаардаггүй ч цагдаагийн алба хаагчийн эрх эдэлж үүрэг хүлээдэг этгээдийн ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн үйлдлийг хамааруулаагүй байна. Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд мөн дээрх байдлаар зохицуулсан билээ. Мөн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн зохицуулалтад хууль сахиулагчийн тавьсан шаардлагын талаар хуульчилсан байгаа нь тухайн зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлж байна.

Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн 3-т "Гэмт хэргийг хэд хэдэн оролцогчтой хамтран үйлдсэн" гэх нөхцөлийг тусгаж, тухайн тохиолдолд тус гэмт хэргийг хүндрүүлэхээр авч үзжээ. Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Эрүүгийн хуульд байх "бүлэглэж үйлдсэн" гэх ойлголттой дүйцэх юм. Тухайлбал, 2015 оны Эрүүгийн хуулийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ" гэж тодорхойлсон бол Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 1998 оны Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт үүнийг "Гэмт хэргийг хэд хэдэн этгээд хамтран гүйцэтгэсэн бол хүн тус бүрийг гүйцэтгэгч (хамтран гүйцэтгэгч) гэж үзэж ял оногдуулна" гэж тодорхойлсон байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд хууль сахиулагчийг бүлэглэж эсэргүүцсэн, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлснийг нийгмийн хор аюулаар өндөр хэрэгт тооцож, ийнхүү хүндрүүлэх бүрэлдэхүүнд хамаатуулан зохицуулсан нь сайн туршлага болж байна.

ЭХ СУРВАЛЖ

• **Хууль тогтоомж****Монгол хэлээр:**

1. Үндсэн хууль (1992).
2. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) (2015).
3. Зөрчлийн тухай хууль (2017).
4. Эрүүгийн хууль (2002).
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017).
6. Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002).
7. Шүүх цаазын бичиг (1926).
8. Шүүх цаазын бичиг (1929).
9. Шүүх цаазын бичиг (1934).
10. Эрүүгийн хууль (1961).
11. Эрүүгийн хууль (1985).
12. 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.
13. 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.
14. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг (Шинэчилсэн найруулга), Боть III.
15. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг (Шинэчилсэн найруулга), Боть IV.
16. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг (Шинэчилсэн найруулга), Боть V.
17. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг (Шинэчилсэн найруулга), Боть VI.
18. 2013 оны Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл.
19. 2013 оны Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн танилцуулга.
20. 2013 оны Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн үзэл баримтлал.

Гадаад хэлээр:

1. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль (1997).
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль (1997).
3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль (1998).
4. Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүүгийн хууль.
5. Бүгд Найрамдах Молдова Улсын Эрүүгийн хууль.
6. Данийн Хаант Улсын Эрүүгийн хууль.
7. Япон Улсын Эрүүгийн хууль (1907).
8. Бүгд Найрамдах Эстони Улсын Эрүүгийн хууль (2001).
9. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль (1963).

• **Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл****Монгол хэлээр:**

1. Гэмт хэргийн цагаан ном-2018. УБ., 2019.
2. Гэмт хэргийн цагаан ном-2019. УБ., 2020.
3. Прокурорын байгууллагын 2020 оны тоон мэдээ.
4. Орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль. УБ., 2021.
5. Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, "Эрх зүйн боловсрол" академи. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2013.
6. Н.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал). УБ., 2011.
7. С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (Тусгай анги). УБ., 1998.

8. Ж.Авхиа. Бүгд найрамдах Монгол Ард Улсын эрүүгийн эрх. УБ., 1973.
9. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги. УБ., 2018.
10. Л.Дорждэрэм. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, доромжлох гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, криминологийн зарим асуудал. 2013.
11. Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээ.
